

Олон нийтэд зориулав

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ
НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА**

(2016.10.03-2017.02.10)

УЛААНБААТАР ХОТ

2017 ОН

АГУУЛГА

Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганыг нээж Улсын Их Хурлын даргын хэлсэн үг	7
---	---

НЭГ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1 Улсын их хурлын 2017 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны нэгдсэн тойм	17
---	----

ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Байнгын хороодын бүрэлдэхүүн.....	20
2.1. Байнгын болон дэд хороодын үйл ажиллагааны талаархи мэдээлэл.....	23

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах ажлын талаар.....	56
3.2. Улсын Их Хурлын гишүүдийн тавьсан асуулга, асуулт.....	57
3.3. Нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээлэл.....	58

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа.....	72
4.2. Улсын Их Хуралд иргэд, сонгогчдоос ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	75
4.3. Мэдээллийн технологи, техник ашиглалтын мэдээ	76
4.4. Судалгаа, шинжилгээ, мэдээлэл лавлагаа	78
4.5 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа	79

ТАВ. ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганаар баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын жагсаалт	86
Хавсралт 2. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлгийн шатанд байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүд	87
Хавсралт 3. Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганаар баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга	95

А) Төрийн байгуулалтын болон хууль зүйн чиглэлээр

1. Монгол Улсын хилийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн танилцуулга	99
2. Арбитрын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн танилцуулга	101
3. Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн танилцуулга	104
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын танилцуулга	107
5. Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	109
6. Дотоодын цэргийн тухай хуулийн танилцуулга	111
7. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн талаархи товч танилцуулга.....	113
8. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт орлуулах тухай хуулийн танилцуулга	114
9. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга	115
10. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон “Нийтийн сонсгол зохион байгуулах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга	116
11. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	117
12. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, сонгуулийн санал авах өдрийг тогтоох тухай”, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолуудын танилцуулга	119
13. Монгол Улсын Их Хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга	120

Б) Төсөв, санхүүгийн чиглэлээр

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн танилцуулга.....	121
2. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай	123

3. Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн танилцуулга	126
4. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн танилцуулга	127
5. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон дагаж мөрдөх журмын тухай хуулийн танилцуулга	128
6. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга	129
7. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга	130

В) Эдийн засгийн чиглэлээр

1. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн танилцуулга.....	131
2. “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга	133
3. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга	134
4. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	135
5. “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга	137

Г) Нийгэм, боловсрол, соёл, шинэжлэх ухааны чиглэлээр

1. Ахмад настны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн танилцуулга.....	139
2. Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн танилцуулга	140
3. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн танилцуулга.....	141
4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	142
5. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг дагаж мөрдөх, журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	143

Д) Байгаль орчин, хөдөө, аж ахуйн чиглэлээр

1. “Хэнтий Хаан уулын нэрийг өөрчлөх тухай”
Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга 146

Е) Аюулгүй байдал, Олон улсын гэрээ, конвенцийн чиглэлээр

1. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн
танилцуулга 148
2. Олон улсын гэрээний тухай хууль
/шинэчилсэн найруулга/-ийн танилцуулга..... 151
3. Гамигаас хамгаалах тухай хууль
/шинэчилсэн найруулга/-ийн танилцуулга 153
4. Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны
Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан
“Экспортыг дэмжих төсөл”-ийн Санхүүжилтийн
хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн
танилцуулга..... 155
5. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах
Австри Улсын Засгийн газар хооронд байгуулсан
“Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг
соёрхон батлах тухай” хуулийн танилцуулга..... 157
6. Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай
Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай протоколд нэгдэн орох тухай хуулийн
танилцуулга..... 159
7. Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай хуулийн танилцуулга..... 161
- Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганыг хааж
Улсын Их Хурлын даргын хэлсэн үг 163

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АБГББХ	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн хөгжлийн банк
БОХХААБХ	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСВУ	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
БХАТИХ	Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал
БХЯ	Батлан хамгаалах яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЁЗДХ	Ёс зүйн дэд хороо
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАН	Монгол Ардын Нам
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль
НББСШУБХ	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ОХУ	Оросын Холбооны Улс
ОУВС	Олон улсын валютын сан
ӨБХ	Өргөдлийн байнгын хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ТББХ	Төрийн байгуулалтын байнгын хороо
ТБХ	Төсвийн байнгын хороо
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЗХДХ	Төсвийн зарлагын хяналтын дэд хороо
ТХДХ	Тусгай хяналтын дэд хороо
УИХ	Улсын Их Хурал
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХЭДХ	Хүний эрхийн дэд хороо
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо
ЭСЯ	Элчин сайдын яам

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫГ НЭЭЖ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛДЫН ХЭЛСЭН ҮГ



*Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,
Хүндэт зочид оо*

Монгол Улсын Их Хурлын долоо дахь удаагийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурал 2016 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагаагаа эхэлж байна. Та бид Анхдугаар чуулганаар ард түмний сонгуулийн үр дүнг баталгаажуулан Монгол Улсын Засгийн газрыг эмхлэн байгуулсан бол ээлжит бус чуулганаар улс орны санхүү, эдийн засгийн тулгамдаж буй асуудлаар хэд хэдэн чухал шийдвэрүүдийг батлан гаргасан билээ. Улсын Их Хурлын чуулганы энэ удаагийн завсарлагааны үеэр гишүүд сонгогдсон тойрогтоо ажиллаж, ард иргэдийнхээ санаа бодлыг сонсон, бодит байдалтай танилцаж, үнэлэлт дүгнэлт хийж ирсэн байгаа.

Олон улсын байгууллага, эрдэмтэн судлаачид, ард иргэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр улс орны эдийн засаг, санхүүгийн байдлын талаар санаа бодлоо илэрхийлсээр байна. Та бид улстөржилгүйгээр бодит байдалд шударгаар хандаж чадвал бүгд ижил төстэй дүгнэлтэд хүрэх биз ээ. Эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал хүнд байна. Эдийн засгийн өсөлт 2012 оноос улирал дараалан буурсаар 2016 онд 0.1-0.6 хувь хүрэхээр байгааг

олон улсын санхүүгийн байгууллагуудаас анхааруулсан. Ажлын байр хомсдож ажилгүйдлийн түвшин 2009 оноос хойш анх удаагаа хоёр оронтой тоонд шилжээд байна.

Иргэдийн худалдан авах чадвар эрс буурсны зэрэгцээ зарим барааны үнэ унаж, эдийн засагт үнийн өсөлт биш, дефляци бий болсныг мэргэжлийн байгууллагаас зарлалаа. Энэ нь Монгол Улсын эдийн засаг огцом агшиж байгааг илт харуулж байгаа юм. Сангийн яам, Монголбанкны зүгээс мөнгөний болон төсвийн бодлогоор эдийн засгийг идэвхжүүлэх боломж хязгаарлагдмал байгаа нь хэнд ч ойлгомжтой байна. Ийм нөхцөлд макро эдийн засгийн зохицуулалтаа оновчтой болгон, хувийн хэвшлийг бүх талаар дэмжиж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгийн хүндрэлээс гарах нь чухал юм.

Тамын тогооны үлгэр хэлэлцэхээ хойш тавьж, гацаанд ороод олон жил болж байгаа томоохон төслүүдийг хөдөлгөх цаг нь одоо нэгэнт болсон. Улстөржсөн хоосон хэрүүл тэмцлээ зогсоож, ажлаа эхлүүл гэдэг үүрэг, даалгаврыг ард түмэн сонгуулиар бидэнд өгсөн. Дөрвөн жил өнгөрсний дараа хийж амжаагүйдээ халаглан, харамсаж суухгүйн тулд хурдтай ажиллах шаардлага Улсын Их Хурал, Засгийн газарт аль алинд нь тавигдаж байна.

Томоохон төслүүдийг байрнаас нь хөдөлгөж, хэрэгжүүлэх тухай саналаа Улсын Их Хуралд оруулан, шуурхай шийдвэрлүүлэх боломж Засгийн газарт нээлттэй байгааг сануулъя. Алдсан цаг хугацаа, алдагдсан боломж эргэж олдохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Улсын Их Хурлын сонгуулиар парламентад нэг нам үнэмлэхүй олонхи болсон. Хяналт тавих боломжгүй боллоо гэж шүүмжлэх өнгө аяс ч сонсогдож байна. Улсын Их Хурал аливаа алдаанаас ангид биш гэдгээ мартаж болохгүй. Анхдугаар чуулганаар бид Улсын Их Хурлын дотоод зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Улсын Их Хурлын бүтцийн байгууллага-Байнгын хороодод цөөнхийн төлөөллийг аль болох хүртээмжтэй оролцуулах бодлого баримталсан гэдгийг ард түмэн харсан, ойлгосон байх. Цөөнхийн үгийг тэвчээртэй сонсож, гаргах шийдвэртээ тэдний санал, үндэслэлийг аль болох тусгах нь алдаа гаргахаас сэргийлэх чухал хөшүүрэг мөн. Олонхиороо түрээ барьж, хүчээр асуудлыг шийвэрлэх нь улс оронд ямар хор уршигтайг өнгөрсөн Улсын Их Хурлын жишээн дээрээс бид харсан.

Монгол Улсаа хөгжүүлэхэд Ардын намын зам, Ардчилсан намын арга гэж тэс өөр зүйл байх ёсгүй, харин зөвхөн “Зөв арга зам” л байх ёстой гэдэгт итгэлтэй байна. Бидний монголчуудад XXI зууны гараан дээр олон улсын тавцанд улс төр, эдийн засгийн хувьд хөл дээрээ баттай зогсох үүлэн чөлөөний нар шиг

ховорхон боломж олоод байгааг ухамсарлаж, үндэсний эрх, ашиг сонирхлоо тэргүүн зэрэгт тавьж Монголоо гэсэн сэтгэлээр ажиллаасай гэж улстөрчдөөсөө хүсэж байна.

Бидэнд итгэх хөрөнгө оруулагчдын итгэл сул хэвээр байна. Гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс илүү хүнд суртал, дарамт шахалт, хууль зүйн тогтворгүй орчин, үл ойлголцол, нэг цонхны бодлогогүй байдал зэрэг нь хөрөнгө оруулагчдын урмыг хугалах томоохон хүчин зүйл болсоор байна. Үе үеийн эрх баригчид хөрөнгө оруулалтын орчныг засаж сайжруулахыг эрмэлзэж, тодорхой хүчин чармайлт гаргадаг хэдий ч үр дүн чамлалттай байсаар байна. Төрийн хүнд суртал, үр ашиггүй зохицуулалтыг арилгахад чиглэсэн бодлогын зоримог өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай болжээ.

Иргэдийн оролцоо хяналт нь төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангахад нэн чухал билээ. Төр засгаас авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд олон нийтийн хяналтыг бий болгож, бэхжүүлэх асуудлыг анхаарах нь зүйтэй байна. Албан тушаалтны баталж буй тушаал, шийдвэр, байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, хувийн ашиг сонирхол болон хөрөнгө, орлогод иргэд, олон нийтийн зүгээс хяналт тавих боломж нөхцөлийг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэхийн зэрэгцээ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг энэ намрын чуулганаар батлах нь зүйтэй байна. Зөвхөн сайхан үзэл баримтлалтай хууль хангалтгүй. Харин хуулийг хэрэгжүүлэх механизм, хүний нөөц, хөрөнгө санхүү зэрэг хүчин зүйлүүдээ сайтар тооцон, амьдралын шаардлагаас урган төлжсөн хуулийг Улсын Их Хурал батлан гаргах шаардлагатай байна.

Сүүлийн үед батлагдсан хуулиуд Үндсэн хууль зөрчсөн нь Цэцийн шийдвэрээр тогтоогдох нь энгийн үзэгдэл боллоо. Засгийн газраас оруулж байгаа хуулийн төслүүд шаардлага хангахгүй байгааг нуух хэрэггүй. Тухайлбал, саяхан Улсын Их Хурлаас Засгийн газарт буцаасан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэхэд анхны болон эцсийн хэлэлцүүлгийн шатанд нийт 536, Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийг хэлэлцүүлэхэд 252 зарчмын зөрүүтэй болон найруулгын санал гарч байсан байна. Энэ нь Засгийн газраас боловсруулан оруулж ирсэн хуулийн төслийн анхны үзэл баримтлал үндсэндээ байхгүй болсон гэсэн үг юм. Энэ чуулганаар урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг дэмжсэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох Үндсэн чиглэлийг хэлэлцэж батална.

Засгийн газар хууль санаачлагчдаас санаачлан хэлэлцүүлэх хуулийн төслүүдийг бодлогын хувьд нэгтгэн, ингэхдээ бодлогын уламжлалыг хадгалах,

аль болох тогтвортой байх зарчмыг баримтлахын сацуу шинэчлэлийг нийгмийн харилцааны ямар салбарт түлхүү авч үзэх шаардлагатайг тодорхойлно. Өргөн мэдүүлсэн, баталсан хуулийн тоогоор ажлаа дүгнэж, сонгогчиддоо тайлагнахыг хичээдэг өрөөсгөл ойлголтоос салж, санаачилж батлуулсан хуулиудынх нь нийгмийн амьдралыг зохицуулахад гүйцэтгэсэн үүрэг, бодлогын залгамж байдлыг хэрхэн хангасан болон дэвшил хөгжилд оруулсан бодит хувь нэмэр, үр дүнтэй нь холбон дүгнэдэг арга барилд шилжих цаг болжээ.

Намрын ээлжит чуулганаар хэлэлцэхээр төлөвлөж байгаа 2017 оны төсөв, мөнгө, эдийн засгийн бодлогын шийдвэрүүд дээр Улсын Их Хурлын гишүүд бид бүхэн оюун бодлоо уралдуулан, аливаа улстөржилт, субъектив хүчин зүйлээс ангид байж, асуудалд бодитой хандаж шийдвэр гаргахыг улс орны нөхцөл байдал, улс үндэсний эрх ашиг зүй ёсоор шаардаж байна.

Гаргах шийдвэрүүд амаргүй, олон нийтэд тэр бүр таалагдахгүй байж болох хэдий ч дунд, урт хугацаанд өгөөжөө өгч, ирээдүйн хөгжлийн суурийг тавих шийдэл дээр харилцан ойлголцож, нэгдсэн шийдвэрт хүрэхийн төлөө дор бүрнээ хичээн ажиллах учиртай.

Энэ намрын чуулганаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэнэ. Мөн Эрүүгийн, Зөрчлийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөөд байна. Сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх явцад амьдралд нийцэхгүй асуудлууд гарч байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Монгол Улсын Их Хурлын, Орон нутгийн сонгуулийн үйл ажиллагааг нэг хуулиар зохицуулахаар хуульчилсныг дахин авч үзэх, сонгууль тус бүрийн онцлогт тохирсон зохицуулалттай байх хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Сонгуулийн хуулийг өөрчлөн найруулахаар төлөвлөөд байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль удахгүй болно. Энэ сонгуульд улс төрийн нам, эвслүүд нэр дэвшигчээ өрсөлдүүлнэ. Ажлын арвин туршлагатай, мэдлэг боловсролтой, шударга, өндөр ёс суртахуунтай, олондоо танигдаж хүндлэгдсэн хүмүүс сонгогдон ажиллана гэдэгт итгэлтэй байна. Сонгуулийг хуулийн дагуу, шударга зохион байгуулах нь Сонгуулийн ерөнхий хороо, бүх шатны сонгуулийн байгууллагын эрхэм үүрэг мөн.

Энэ жил бичин жил. Өвөл хаяанд ирлээ. Өмнө тохиож байсан бичин жилүүдийн хатуухан сорилтыг байнга санаж, өвлийг өнтэй давах бэлтгэлээ сайтар базаах талаар малчид, тариаланчид, орон нутгийн иргэд хүчин чармайлтаа дайчлан ажиллаж байгаад эргэлзэхгүй байна. Төр, орон нутгийн бүх шатны байгууллагууд энэ чиглэлээр өөрсдөөсөө хамаарах бүхнийг хийж, цаг тухайд

нь шуурхай зохицуулалтаар хангах нь нэн чухал гэдгийг сануулъя. Нийслэлийн иргэдийн хамгийн тулгамдсан асуудлын нэг болоод удаж байгаа хотын утааны асуудалд Засгийн газар, нийслэлийн удирдлагууд хамтран ажиллаж, бодитой үр дүн гаргахыг иргэд хүсэн хүлээсээр байгаа гэдгийг сануулан хэлье.

Эрхэм гишүүд ээ,

Намрын чуулган өмнөө тавьсан зорилтоо амжилттай шийдвэрлэж, улс орны хөгжил дэвшилд түүхэн хувь нэмрээ оруулна гэдэгт итгэл төгс байна.

Чуулганы болон Байнгын хорооны ажиллагаанд идэвхтэй оролцон, үр бүтээлтэй ажиллахыг эрхэм гишүүд Та бүхнээс хүсье.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы ажиллагаа нээснийг мэдэгдье.



Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа



Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгч Биатэ Транкман, Швейцарийн хөгжлийн агентлагийн Хамтын ажиллагааны захирал Габриэла Спирлинар “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн баримт бичигт гарын үсэг зурлаа. /2016.10.03/



Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд Монгол, ОХУ-ын Засгийн газар хоорондын комиссын Оросын хэсгийн дарга, ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн сайд С.Е.Донскойг хүлээн авч уулзлаа. /2016.12.13/



Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд “Нүүдлийн аялал жуулчлал ба хотуудын тогтвортой хөгжил” сэдэвт Торгоны замын аялал жуулчлалын олон улсын анхдугаар бага хуралд оролцов. /2016.10.13/



Монгол Улс анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах улсаа зарлан тунхагласны 92 жилийн ойг тохиолдуулан Монголын нийт ард түмэнд мэндчилгээ дэвшүүлж АИХ-ын зарим депутатад шагнал гардуулав. 2016.11.26



2016 оны аравдугаар сарын 04-05-ны өдрүүдэд Баянхонгор, Өвөрхангай, Архангай аймагт, аравдугаар сарын 11-ний өдөр Төв аймагт ажиллав.



Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд Авлигын эсрэг үндэсний чуулганд оролцож үг хэллээ. 2017.01.11



Аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга, Засаг дарга нартай уулзаж, үүрэг даалгавар өгөв. 2017.01.06



Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойд зориулсан Шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээний шувтаргын тоглолтод оролцож, үг хэлэв. 2017.01.07



Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд 2017.02.13-15-нд Завхан, Увс, Ховд, Баян-Өлгий аймагт ажиллав.



Төвдийн Өөртөө Засах Орны Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын төлөөлөгч, Төвдийн Өөртөө Засах Орны дэд дарга Бямбадам тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. 2016.10.31



“Ахмад настны эрх, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын баталгаа” сэдэвт үндэсний чуулганд Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд үг хэлэв. 2017.02.10



Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд Монгол дахь Америкийн Худалдааны танхимын гишүүдтэй уулзалт хийв. /2017.01.25/

НЭГ

ҮЛСЫН ИХ ХҮРЛЫН ХҮҮЛЬ ТОГТООХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА

НЭГ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1 УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТОЙМ

ХУРАЛДСАН ӨДӨР, ТОО

2016.10.03-2017.02.10 ХҮРТЭЛ



- бие даасан хууль - **22**
- нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль - **175**
- хүчингүй болсонд тооцох тухай хууль - **15**
- гэрээ конвенц соёрхон батлах тухай хууль - **3**
- Улсын Их Хурлын тогтоол - **59**

УИХ-ЫН ГИШҮҮДЭЭС БОЛОН АЖЛЫН

ХЭСГЭЭС АСУУСАН



АСУУЛТ, ХАРИУЛТ **1204**

УИХ-ЫН ГИШҮҮД ҮГ ХЭЛСЭН

681 удаа,

44 цаг 26 минут



ТӨРИЙН ОРДОНТОЙ
ТАНИЛЦСАН ИРГЭД

9545



2016.10 сар:	7 удаа 21цаг 37 минут
2016.11 сар:	7 удаа 33 цаг 01 минут
2016.12 сар:	9 удаа 36 цаг 34 минут
2017.01 сар:	7 удаа 45 цаг 21 минут
2017.02 сар:	4 удаа 29 цаг 56 минут

- Чуулганы хугацаанд Байнгын хороодын **143** удаагийн, **220** цаг **45** минутын хуралдааны явцын талаар **727** хуудас гар тэмдэглэл хөтөлж, **3917** хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэв.
- Чуулганы нэгдсэн хуралдааны явцын талаар нийт **684** хуудас гар тэмдэглэлийг хөтөлж, **3060** хуудас дэлгэрэнгүй тэмдэглэлийг дууны бичлэгээс буулгав.



Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа



Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үеэр

ХОЁР

ҮЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН БОЛОН
ДЭД ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛАГАА

2.1. Байнгын болон дэд хороодын үйл ажиллагааны мэдээлэл

ХУРАЛДСАН ӨДӨР, ТОО

2016.10.03-2017.02.10 ХҮРТЭЛ

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ149
өдөр

БАЙНГЫН ХОРОО БОЛОН ДЭД ХОРООД

/давхардсан тоогоор/



ХУРАЛДСАН ТОО

ДЭД ХОРОО

2

удаа

Агаарын бохирдлыг бууруулах асуудлын
дэд хороо

3

удаа

Төсвийн зарлагын хяналтын
дэд хороо

1

удаа

Хүний эрхийн
дэд хороо

1

удаа

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн
дэд хороо

3

удаа

Тусгай хяналтын
дэд хороо

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

Байнгын хорооны **228** санал, дүгнэлт,
танилцуулга бэлтгэн чуулганы нэгдсэн
хуралдаанд оруулан шийдвэрлүүлжээ.



Байнгын хороонд иргэд **511** өргөдөл,
байгууллага, аж ахуйн нэгжээс **722** санал хүсэлт
ирснийг шийдвэрлэж, харуу өгөв.

ХОЁР. БАЙНГЫН БОЛОН ДЭД ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Байнгын хороодын бүрэлдэхүүн

(2017.02.10-ны байдлаар)

№	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	Өргөдлийн байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Төсвийн байнгын хороо	Хууль зүйн байнгын хороо	Эдийн засгийн байнгын хороо
1	Ж.Энхбаяр	Ц.Гарамжав	Л.Энх-Амгалан	Д.Сарангэрэл	Н.Энхболд	Ч.Хүрэлбаатар	Ш.Раднаасэд	Д.Тэрбишдагва
2	Т.Аюурсайхан	Х.Баделхан	О.Баасанхүү	Н.Амарзаяа	О.Баасанхүү	Н.Амарзаяа	Ж.Батзандан	Т.Аюурсайхан
3	О.Баасанхүү	Б.Батзориг	Ё.Баатарбилэг	Ё.Баатарбилэг	Ж.Батзандан	Х.Баделхан	О.Батнасан	Ж.Бат-Эрдэнэ
4	С.Батболд	Ж.Бат-Эрдэнэ	Г.Мөнхцэцэг	М.Билэгт	Б.Батзориг	Ж.Батзандан	С.Бямбацогт	Л.Болд
5	Л.Болд	Ж.Энхбаяр	М.Билэгт	Д.Гантулга	Б.Жавхлан	О.Батнасан	Л.Болд	Х.Болорчулуун
6	Г.Занданшатар	Х.Болорчулуун	Д.Ганболд	Ц.Гарамжав	Д.Лүндээжанцан	Б.Баттөмөр	Ж.Ганбаатар	Б.Баттөмөр
7	Д.Лүндээжанцан	С.Жавхлан	Д.Гантулга	Д.Дамба-Очир	Ж.Мөнхбат	Ц.Даваасурэн	Д.Ганболд	Ж.Ганбаатар
8	Б.Наранхүү	Л.Мөнхбаатар	С.Жавхлан	Г.Занданшатар	Г.Занданшатар	Ш.Раднаасэд	Б.Дэлгэрсайхан	Ц.Даваасурэн
9	Х.Нямбаатар	Г.Мөнхцэцэг	Н.Номтойбаяр	Г.Мөнхцэцэг	Б.Наранхүү	З.Нарантуяа	Л.Мөнхбаатар	Д.Дамба-Очир
10	Н.Оюундарь	Д.Мурат	М.Оюунчимэг	Д.Мурат	Д.Тогтохсүрэн	Б.Наранхүү	Ц.Мөнх-Оргил	Б.Дэлгэрсайхан
11	Л.Оюун-Эрдэнэ	Я.Санжмятав	Я.Санжмятав	М.Оюунчимэг	Л.Оюун-Эрдэнэ	Д.Сумъяабазар	Х.Нямбаатар	Б.Жавхлан
12	Я.Санжмятав	Б.Саранчимэг	Д.Сарангэрэл	Б.Пүрэвдорж	О.Содбилэг	Ц.Нямдорж	Ц.Нямдорж	З.Нарантуяа
13	О.Содбилэг	Я.Содбаатар	Б.Саранчимэг	Ш.Раднаасэд	Д.Сумъяабазар	Д.Оюунхорол	Н.Оюундарь	М.Оюунчимэг
14	Б.Бат-Эрдэнэ	Г.Солтан	А.Ундраа	Г.Солтан	Б.Ундармаа	Д.Тогтохсүрэн	Б.Пүрэвдорж	Б.Ундармаа
15	А.Ундраа	А.Сүхбат	Н.Учрал	А.Сүхбат	Д.Хаянхярваа	Ч.Улаан	Н.Учрал	Ч.Хүрэлбаатар
16	Ц.Цогзолмаа	Г.Тэмүүлэн	Ц.Цогзолмаа	Д.Тогтохсүрэн	Н.Цэрэнбат	Б.Чойжилсүрэн	Д.Цогтбаатар	С.Чинзориг
17	Д.Цогтбаатар	Д.Тэрбишдагва	С.Чинзориг	Н.Цэрэнбат	М.Энхболд	Г.Тэмүүлэн	Ц.Гарамжав	Л.Элдэв-Очир
18	Б.Энх-Амгалан	Л.Элдэв-Очир	Ө.Энхтүвшин	Б.Энх-Амгалан	Д.Эрдэнэбат	Ө.Энхтүвшин	Л.Энхболд	Л.Энх-Амгалан
19	Н.Энхболд	Д.Эрдэнэбат	С.Эрдэнэ	Л.Энхболд	Ж.Эрдэнэбат	С.Эрдэнэ	С.Эрдэнэ	Д.Эрдэнэбат

Улсын Их Хурлын дэд хороодын бүрэлдэхүүн

№	Тусгай хяналтын дэд хороо	Тусгай хяналтын дэд хороо	Нутгийн удирдлагын дэд хороо	Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо	Төсвийн зарлагын хяналтын дэд хороо	Хүний эрхийн дэд хороо	Жижиг, дунд үйлдвэрлэлийн нийгэмлэгийн дэд хороо	Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо	Сонгогчийн нэрийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо
1	С.Батболд	Д.Лүндээжанцан	Б.Жавхлан	Ц.Нямдорж	З.Нарантуяа	Д.Цогтбаатар	Ж.Ганбаатар	С.Чинзориг	О.Содбилэг	Б.Батзориг
2	Г.Занданшатар	Х.Баделхан	Б.Батзориг	Д.Лүндээжанцан	Н.Амарзаяа	Ж.Батзандан	Т.Аюурсайхан	Ё.Баатарбилэг	Ж.Батзандан	Д.Мурат
3	Я.Санжмятав	С.Бямбацогт	Ж.Мөнхбат	Ч.Улаан	О.Батнасан	Д.Ганболд	Ж.Бат-Эрдэнэ	Д.Гантулга	Д.Сумьяабаатар	Г.Мөнхцэцэг
4	Д.Цогтбаатар	Г.Тэмүүлэн	Б.Наранхүү	Н.Энхболд	Б.Баттөмөр	Б.Дэлгэрсайхан	Х.Болорчулуун	С.Жавхлан	Б.Ундармаа	Б.Саранчимэг
5	Н.Энхболд	Л.Мөнхбаатар	Д.Оюунхорол	Ө.Энхтүвшин	Ц.Даваасүрэн	Н.Оюундарь	Д.Дамба-Очир	М.Оюунчимэг	Д.Хаянхярваа	Я.Содбаатар
6		Б.Наранхүү	Л.Оюун-Эрдэнэ		Ч.Улаан	Ш.Раднаасэд	З.Нарантуяа	Б.Саранчимэг	Н.Цэрэнбат	Г.Солтан
7		Д.Сарангэрэл	Б.Ундармаа		Б.Наранхүү	Б.Пүрэвдорж	С.Чинзориг	Я.Санжмятав	Д.Эрдэнэбат	А.Сухбат
8		М.Энхболд	Н.Цэрэнбат		Д.Тогтохсүрэн	Н.Учрал	Л.Элдэв-Очир	Ц.Цогзолмаа		Д.Тэрбишдагва
9		Д.Эрдэнэбат	Д.Эрдэнэбат		Ч.Хүрэлбаатар	Л.Энхболд		С.Эрдэнэ		Д.Эрдэнэбат

Нэг. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО



АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

2016.10.03-2017.02.10 ХҮРТЭЛ



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ж.ЭНХБАЯР



19 ГИШҮҮН

21

удаа

ХУРАЛДААН

63,15

хувь

ХУРАЛДААНЫ
ИРЦ

АЖЛЫН ХЭСЭГ

7

удаа

БАЙГУУЛЖ

13

удаа

ХУРАЛДСАН
ТОО

ӨРГӨДӨЛ
ГОМДОЛ



4 -ийг авч

шийдвэрлэсэн- **3**

- Хуулийн төсөл - **16**
- Улсын Их Хурлын тогтоолын төсөл - **3**
- Зөвшилцөх асуудал - **3**
- Байнгын хорооны тогтоол - **12**
- Байнгын хорооны хуралдаанаас чиглэл, үүрэг өгсөн тэмдэглэл - **16**
- Яам, байгууллагын тайлан, илтгэл сонссон- **4**
- Санал, дүгнэлт - **31**
- Боловсруулсан лавлагаа мэдээлэл - **12**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **39**
явуулсан албан бичиг **25**

Байнгын хорооны 21 хуралдааны дараалал боловсруулж ажлын алба Байнгын хорооны дарга, гишүүдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажилласан.

Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 7 ажлын хэсэг нийт 13 удаа хуралдаж ажлын хэсгийн хуралдааны тойм боловсруулан дотоод сүлжээнд оруулж батлагдсан хууль, тогтоолоор бичгээр болон слайдаар 12 танилцуулга боловсруулан бэлтгэсэн. Тайлангийн хугацаанд 4 өргөдөл, гомдлыг хүлээн авч, 3 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн. Архивт 13 боть, 2044 хуудас материалыг хүлээлгэн өгсөн.

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Тус байнгын хороо намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Экспортыг дэмжих төсөл”-ийн Санхүүжилтийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг соёрхон батлах тухай, Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколд нэгдэн орох тухай, Олон улсын гэрээний тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн болон албаны нууцын тухай, Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга зэрэг 6 олон улсын гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлах, нэгдэн орох тухай хуулийн төслийг хэлэлцэж, чуулганы хуралдаанд оруулж батлууллаа.

Монгол Улс байнга төвийг сахих тухай, Олон улсын гэрээний тухай хуулийн хүчингүй болгох тухай хуулийн төслүүд Улсын Их Хурлын тогтоолоор буцаагдсан.

Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлөг худалдах тухай” олон талт хэлэлцээрийн төсөл, “Олон улсын тогтвортой аялал жуулчлал, ядуурлыг бууруулах байгууллагыг үүсгэн байгуулах тухай” хэлэлцээрийн төсөл, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын “Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээнд нэгдэн орох тухай” асуудал, “Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны институцийг үүсгэн байгуулах” хэлэлцээрийн төсөл, Монгол Улс Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орох тухай асуудал зэрэг гэрээ, хэлэлцээрийг зөвшилцсөн.

Хяналт шалгалтын ажлын талаар:

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүд, ажлын албаны ажилтнууд, Гадаад харилцааны

яам, Тагнуулын ерөнхий газрын үндсэн зорилго, зорилтууд, үйл ажиллагааны талаархи танилцуулга, мэдээлэлтэй танилцсан.

Мөн Гадаад харилцааны яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Тагнуулын ерөнхий газраас шинэ Засгийн газар байгуулагдсанаас хойш шийдвэрлэсэн гол асуудлууд болон шийдвэрлэхээр ажиллаж байгаа асуудлуудын талаархи товч мэдээлэл, салбарын бодлого, үйл ажиллагаа, ажиллах нөхцөлтэй танилцаж, салбарын хэмжээнд тулгамдсан асуудлуудын талаар харилцан санал солилцсон.

Бусад ажлын талаар:

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ажилтнууд “Монгол Улсын аюулгүй байдал-2016” судалгаа, шинжилгээний эмхэтгэлийн хамтран зохиогчоор оролцож, аюулгүй байдал дахь Улсын Их Хурал, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин гэсэн бүлгүүдийг боловсруулж хэвлүүлсэн.

- Монгол Улсын Гадаад харилцааны тухай хууль өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Сургуулийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуультай хамтран “Гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох нь” сэдэвт хэлэлцүүлгийг 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр амжилттай зохион байгуулсан.
- Ажлын албанаас Байнгын хорооны эрхлэх асуудлын чиглэлээр тайлант хугацаанд нийт нэг удаа Улсын Их Хурлын даргын захирамжийн төсөл, 12 удаа уулзалт, ярилцлага, дөрвөн удаа судалгаа, лавлагаа, мэдээлэл, танилцуулга боловсруулж, хоёр удаа семинар, хурал зөвлөлгөөнд илтгэл тавьсан.
- Мэдээллийн аюулгүй байдлын тухай, Төрийн болон албаны нууцын тухай, Олон улсын гэрээний тухай (шинэчилсэн найруулга), Монгол Улсын гадаад харилцааны тухай хуулийн төслүүд өргөн баригдсантай холбогдуулан АНУ, БНХАУ, Швейцарийн Холбооны Улс, ОХУ-ын хуулиудтай харьцуулсан судалгаа хийсэн.
- Мөн хуулиудын зарим зүйл, заалт, нэр томъёоны тайлбар, лавлагааг гаргаж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийг шинээр өргөн баригдсан хуулийн төсөлтэй харьцуулсан судалгаа, лавлагааг хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ.
- Байнгын хорооны дарга, гишүүд, ажлын албанаас тайлант хугацаанд нийт 12 удаа уулзалт, ярилцлага зохион байгуулсан.



Байнгын хорооны дарга Ж.Энхбаяр “Зүүн хойд Азийн аюулгүй байдал” сэдэвт уулзалтад үг хэллээ. 2016.11.14



Байнгын хорооны дарга Ж.Энхбаяр Мянганы сорилтын корпораци (МСК)-ийн Сонгон иалгаруулалт хариуцсан захирал Кристофер Мэлони тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. 2017.01.10



Байнгын хорооны дарга Ж.Энхбаяр Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төвийн дэд захирал Филипп Флори тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзсан. 2017.01.30



Байнгын хорооны дарга Ж.Энхбаяр ХБНГУ-ын Холбооны гюулгүй байдлын бодлогын академийн ерөнхийлөгч Карл-Хайнц Кампыг хүлээн авч уулзлаа. 2016.10.27



Байнгын хорооны дарга Ж.Энхбаяр АНУ-ын Элчин сайдыг хүлээн авч уулзав. 2017.01.10



Байнгын хорооны дарга Ж.Энхбаяр Батлан хамгаалах салбарын багц хуулиудыг гардуулж өгөв. 2016.10.06



“Гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох нь” хэлэлцүүлэг боллоо. 2016.11.17

Хоёр. БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО



БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2016 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ц.ГАРАМЖАВ



19 ГИШҮҮН

10
удаа

ХУРАЛДААН

63,15
хувь

**ХУРАЛДААНЫ
ИРЦ**

АЖЛЫН ХЭСЭГ

3
удаа

**ХУРАЛДААН
НИЙТ**

Улсын Их Хурлын
тогтоол батлуулсан **2**



- Хуулийн төсөл давхардсан тоогоор - **27**
- Улсын Их Хурлын тогтоолын төсөл - **5**
- Сайдын мэдээлэл - **3**
- Байнгын хорооны тогтоол - **3**
- Байнгын хорооны хуралдаанаас чиглэл, үүрэг өгсөн тэмдэглэл - **2**
- Яам, байгууллагын тайлан, шлтгэл мэдээлэл - **4**
- Санал, дүгнэлт - **11**
- Зарчмын зөрүүтэй санал - **19**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **76**
явуулсан албан бичиг **20**

Байнгын хорооны тогтоол 3, дэд хорооны тогтоол нэгийг батлан гаргаж, хуралдааны тэмдэглэлээр үүрэг чиглэл өгсөн тэмдэглэл 2 гарсан болно.

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 2016-2017 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хууль санаачлагчдаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах, Байнгын хорооны болон Нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллав.

Тухайлбал, Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2017 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг, Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын 2017 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг, Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг, “Хог хаягдлын тухай хууль (шинэчилсэн найруулга) болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ. Монгол Улсын Их Хурлаас дээрх хуулиудыг хууль санаачлагчид буцаах нь зүйтэй гэж үзэн Хог хаягдлын тухай (шинэчилсэн найруулга) болон холбогдох бусад хуулиудыг 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн Хууль буцаах тухай Улсын Их Хурлын 53 тоот тогтоол зэрэг Улсын Их Хурлын 12 тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэв.

Хууль, тогтоомжийн хэрэгжилтийн хяналт, шалгалтын ажлын талаар:

Байнгын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Баделхан болон ажлын албаны ажилтнууд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.11 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлаас 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол, 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр баталсан “Органик хүнсний тухай” хуулийг Увс

аймгийн Улаангом, Хяргас, Наранбулаг, Тариалан сумдад сурталчлах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Бусад ажлын талаар:

Байнгын хороо тайлант хугацаанд дараах тайлан, мэдээллийг хуралдаанаараа сонсож, тэдгээрийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч цаашид эрчимжүүлэх чиглэлээр тодорхой үүргийг өглөө. Үүнд:

2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар Байнгын хорооны 2015 оны 05, 07 тоот тогтоолын биелэлтийн талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын мэдээллийг сонсов.

2016 оны 12 дугаар сарын 27-ны хуралдаанаар Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын 2016 оны 46 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсож, хэлэлцээд Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээр Засгийн газарт үүрэг өгөв.

2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар “Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар” холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсч Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээр Засгийн газарт үүрэг өгөв.


Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны 3 тогтоол батлав.



“Төв цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал, хөрөнгө оруулалтын асуудал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. 2016.11.08



БОХХААБХ-ны гишүүд Хунс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ажиллав. 2017.01.30



Байнгын хорооны дарга Ц.Гарамжав тогтоолын төслийн талаар эрдэмтэн, судлаачидтай уулзав. 2017.01.12



УИХ дахь Монгол-Швейцарийн парламентын бүлгийн дарга Ц.Гарамжав ШХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Жан-Жак де Дардел тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. 2016.11.04



Байнгын хорооны дарга Ц.Гарамжав эрчим хүчнээс дулаан хуримтлуулж халаах эко төхөөрөмжийн төсөлтэй танилцав. 2016.10.06



Байнгын хорооны дарга Ц.Гарамжав НУБ-ын ХХААБ-ын суурин төлөөлөгчийг хүлээн авч уулзлаа. 2016.12.14



“Монгол орны бэлчээрийн төлөв байдал, тулгамдсан асуудал” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг боллоо. 2016.11.29

Гурав. НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРОО



НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2016 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Л.ЭНХ-АМГАЛАН



19 ГИШҮҮН

15
удаа

ХУРАЛДААН

63,15
хувь

ХУРАЛДААНЫ
ИРЦ

АЖЛЫН ХЭСЭГ

11
удаа

БАЙГУУЛЖ

12
удаа

ХУРАЛДСАН
ТОО

ӨРГӨДӨЛ
ГОМДОЛ **30**

- Хуулийн төсөл - **11**
- Байнгын хорооны тогтоол - **1**
- Санал, дүгнэлт - **26**
- Зарчмын зөрүүтэй санал - **65**



ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **90**
явуулсан албан бичиг **74**

Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг нийт 12 удаа хуралдаж, ажлын хэсгийн 2 танилцуулга, хуралдааны 12 тойм бэлтгэж, Улсын Их Хурлын мэдээллийн дотоод сүлжээнд байршуулав.

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэв.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэв.

Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд нийт зургаан багц хууль, Улсын Их Хурлын тогтоол хоёрыг батлууллаа. Үүнд: “Боловсролын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “Ахмад настны тухай” хуулийн шинэчилсэн найруулга, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуульд нэмэлт оруулах тухай хууль, “Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай” хуулийн шинэчилсэн найруулга, “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” хууль, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлууллаа.

Хяналт шалгалтын ажлын талаар:

2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Байнгын хорооны тогтоолоор нийт хяналт шалгалтын чиг үүрэг бүхий 11 ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдах байгууллагуудад холбогдох хууль тогтоомжийн биелэлт, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Тухайлбал, Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд “Инновацийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний талаар санал дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулж тус Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж, тайлангаа Байнгын хорооны хуралдаанд танилцуулж, Засгийн газарт хуулийн хэрэгжилтийг хангах тухай чиглэлийг Байнгын хорооны тогтоолоор өглөө.

“Эрүүл мэндийн бодлого, Эрүүл мэндийн тухай хууль, тогтоомжийг боловсронгуй болгох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний талаар санал боловсруулж тус Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж байна.

“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг шалгаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний талаар санал, шийдвэрийн төсөл боловсруулж, тус Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж байна.

“Боловсролын тухай” хууль, Ерөнхий боловсролын сургууль, тусгай хэрэгцээт сургууль, “Үдийн цай” хөтөлбөр, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын хүрээлэнгийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн хэрэгжилт, шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцан цаашид шинжлэх ухааны салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар санал дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулж, тус Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж, ажлын хэсгийн тайланг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэн Засгийн газарт хуулийн хэрэгжилтийг хангах тухай чиглэлийг Байнгын хорооны тогтоолоор өглөө.

Бусад асуудлын талаар:

- Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Л.Энх-Амгалан болон Байнгын хорооны гишүүд Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаатай танилцав. Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, ирэх жилүүдэд хийх ажлын тухай танилцуулга, мэдээллийг хийж, Байнгын хорооны дарга Л.Энх-Амгалан болон гишүүд асуулт асууж, харилцан санал бодлоо солилцов. Уулзалтад Эрүүл мэндийн яамны удирдлагууд, нийслэл, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн болон клиникийн дарга нар байв.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагаатай танилцлаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр Монгол Улсын нийгмийн хамгааллын салбарын шинэчлэлийн бодлого, нийгмийн даатгалын тогтолцоо, тэтгэврийн даатгалын сангийн өнөөгийн байдал зэрэг илтгэлүүдийг хэлэлцүүлж, Байнгын хорооны дарга Л.Энх-Амгалан болон гишүүд асуулт асууж, харилцан санал бодлоо солилцов.



Ажлын алба “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилт, цаашдын зорилт” сэдэвт хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгуулав. 2016.10.12



Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороотой хамтран “Ариун цэврийн байгууламж, нүхэн жорлон” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. 2016.11.08



“Бэлгийн замаар дамжих халдварын өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. 2016.11.15



“Инновацийн тухай хуулийн хэрэгжилтийн явц, цаашдын зорилт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. 2016.11.30



“Төрөөс эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. 2016.12.07

Дөрөв. ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ



ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2016 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Н.ЭНХБОЛД



19 ГИШҮҮН

17
удаа

ХУРАЛДААН

63,15
хувь

ХУРАЛДААНЫ
ИРЦ

АЖЛЫН ХЭСЭГ

2

удаа

БАЙГУУЛЖ

8

удаа

ХУРАЛДСАН
ТОО

5

удаа

ӨРГӨДӨЛ
ГОМДОЛ

- Хэлэлцсэн асуудал - **55**
- Хуулийн төсөл - **33**
- УИХ-ын тогтоолын төсөл - **12**
- Байнгын хорооны тогтоол - **8**
- Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт - **1**
- Тайлан танилцуулга - **2**
- Санал, дүгнэлт - **28**
- Тайлан танилцуулга - **8**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **35**

явуулсан албан бичиг **40**

Намрын ээлжит чуулганы хугацаанд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх болон боловсруулах үүрэг бүхий Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий хоёр ажлын хэсэг ажилласан ба тайлант хугацаанд ажлын хэсэг 18 удаа хуралдсан байна.

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Тус байнгын хороо бие даасан хууль 1, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 6, Улсын Их Хурлын тогтоол 11-ийг тус тус Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.

Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль

Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатар нарын нэр бүхий 30 гишүүнээс 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурал 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Энэ хуулиар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.3.3-т заасан асуудлыг Монгол Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх үндэслэл, шаардлагыг нарийвчлан тодорхойлж, орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, мөн хот, суурин газрын хэсэгчилсэн төлөвлөлт (нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж) зэрэг асуудлаар зөвлөлдөх санал асуулга явуулж байхаар тогтоолоо.

Зөвлөлдөх санал асуулгыг хоёр шаттайгаар явуулах бөгөөд нэг болон хоёр дахь шатны зөвлөлдөх санал асуулгын дүнг статистикийн байгууллага нэгтгэн гаргаж, үр дүнгийн тайланг Зөвлөлдөх зөвлөлд танилцуулах ба Зөвлөлдөх зөвлөл хэлэлцээд гаргасан зөвлөмжийг шийдвэр гаргах эрх бүхий этгээд харгалзан үзэхээр хуульд тусгасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, сонгуулийн санал авах өдрийг тогтоох тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай Улсын Их Хурлын тогтоол:

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.3, 16.6 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн

2017 оны ээлжит сонгуулийг 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс товлон зарлаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн санал авах ажиллагааг 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдөр явуулахаар, Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэний санал авах ажиллагааг 2017 оны 06 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд явуулахаар тус тус тогтоолоо.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмжийг тус тус хэрэглэхээр шийдвэрлэлээ.

Бусад ажлын талаар:

- Төрийн байгуулалтын байнгын хороо 2016 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 05 тоот тогтоолоор Олон нийтийн радио, телевизийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж Олон нийтийн радио, телевизийн хамт олон, Ерөнхий захирал, Захирлуудын зөвлөл, Үндэсний зөвлөлийн гишүүдтэй тусгайлан уулзалт зохион байгуулсан бөгөөд ажлын хэсгийн танилцуулгыг Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж Байнгын хорооны тогтоолоор чиглэл, зөвлөмж өгч ажиллалаа.
- Байнгын хорооны дарга Н.Энхболд тайлант хугацаанд гадаад, дотоодын болон олон улсын байгууллагуудын төлөөлөлтэй 10 удаагийн уулзалт, ярилцлага зохион байгуулж, ажил хэрэгч яриа өрнүүлж, санал солилцож ажиллав.
- Байнгын хорооноос Улсын Их Хурлын гишүүдэд зориулан Хууль зүйн яам, НҮБХХ-ийн “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөлтэй хамтран Хууль тогтоомжийн тухай хуулийн сургалт-мэдээллийг зохион байгуулав.
- ЖАЙКА-гийн “Монгол Улсын Хөгжлийн бодлого, улсын хөрөнгө оруулалтын салбарын суурь судалгаа”-ны судалгааны багтай хамтран “Хөгжлийн бодлого, улсын хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг бэхжүүлэх нь” семинарыг Төрийн ордонд зохион байгуулав. Семинарт дөрвөн илтгэл хэлэлцүүлж, судалгааны багийн болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ийн ажлын хэсгийн гишүүд, холбогдох яам, газрын дарга нар, Байнгын хорооны ажлын албаны албан хаагчид оролцлоо.




“Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ын төслийн хэлэлцүүлгийг “Ил тод байдлыг дэмжих түншлэл”, “Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд хөдөлгөөн” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулав. 2016.11.29



Байнгын хорооны дарга Н.Энхболд НУБ-ын төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. 2016.11.07



“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ийг хэрэгжүүлэхэд бодлогын зохицуулалтыг хэрхэн хийх вэ-институцийн оновчтой хувилбарууд” хэлэлцүүлэг зохион байгуулав. 2016.12.13



Байнгын хорооны дарга Н.Энхболд Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүнтэй уулзав. 2106.11.11



Байнгын хорооны дарга Н.Энхболд ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын бүрэлдэхүүнийг хүлээн авч уулзлаа. 2016.11.10

Тав. ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО



ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2016 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ч.ХУРЭЛБААТАР



19 ГИШҮҮН

22

удаа

ХУРАЛДААН

63,15

ХУВЬ

ХУРАЛДААНЫ
ИРЦ

БАТЛУУЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ

2

удаа

хууль

4

удаа

БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

33

удаа

НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛСАН

- Хуулийн төсөл - **35**
- УИХ-ын тогтоолын төсөл - **7**
- Тайлан, танилцуулга - **8**
- Санал, дүгнэлт - **43**
- Зарчмын зөрүүтэй санал - **36**
- Тайлан, танилцуулга - **1**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **83**

явуулсан албан бичиг **8**

Яам, агентлаг, аж ахуйн нэгжүүдээс төсвийн төсөлд тусгуулахаар ирүүлсэн 75 албан тоотыг нэгтгэж, Төсвийн ажлын хэсэгт танилцуулан Засгийн газарт төсвийн төсөлд тусгуулахаар хүргүүлэв.

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Тайлант хугацаанд бие даасан хууль 2, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 33, Улсын Их Хурлын 7 тогтоолыг тус тус хэлэлцүүлэгт бэлтгэн нэгдсэн хуралдаанаар батлууллаа. Хэлэлцэн баталсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрүүдийн талаар товч дурдвал:

- ***Монгол Улсын 2017 оны төсвийн тухай (2016.11.10-ны өдөр баталсан)***

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг 185.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 6,160.2 тэрбум төгрөгөөр, нийт зарлагыг 4.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 8,568.9 тэрбум төгрөгөөр батлан, нийт алдагдлыг 180.5 тэрбум төгрөгөөр буюу 0.8 хувиар сайжруулсан.

- ***Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2016.12.09-ний өдөр баталсан)***

Хөнгөлөлттэй тариф хэрэглэх улсын жагсаалтад орсон боловч Монгол Улсын олон улсын гэрээ, эсхүл нотлох баримт бичиггүй бараанд нэн тааламжтай тариф хэрэглэх, барааны гарал, үүслийг нотлох баримт бичигтэй холбоотой зохицуулалт болон барааны гарал үүслийн гэрчилгээ заавал шаардагдах барааны жагсаалтыг Засгийн газар батлахаар хуульчилсан.

- ***Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2017.02.02-ны өдөр баталсан)***

Жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, хүнсний бүтээгдэхүүн, нэхмэл, хувцас, барилгын материалын үйлдвэрлэл болон газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, түүнд холбогдох туслах үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн албан татварын 90 хувийг хөнгөлөхөөр баталсан. Татварын хөнгөлөлтийг дээрх 4 салбарын хүрээнд хэрэгжүүлэхдээ Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллыг баримтлахаар хуульчиллаа.

- ***Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон дагаж мөрдөх журмын тухай (2017.02.02-ны өдөр баталсан)***

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн хүчин төгөлдөр мөрдөх хугацаа 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсныг 2018 оны

12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгахаар хуульчилсан. Хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцаас шалтгаалан 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2017 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хуулийн үйлчлэл зогссон бөгөөд энэ хугацаанд татвар төлөлтөд хамрагдах бараанд ногдуулах татварыг иргэн, аж ахуйн нэгжид буцаан олгох асуудлыг дагаж мөрдөх журмын тухай хуулиар зохицууллаа.

- “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг батлах тухай”, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн төсвийн орлого, зарлагад өөрчлөлт орохтой холбоотой зүйл, заалтуудыг Төсвийн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж, гаргасан санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороодод хүргүүлэв.
- Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн газар, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх Олон улсын сангийн хооронд байгуулах “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын төсөл”-ийн нэмэлт санхүүжилтийн хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах нэг тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн төслүүдийн зөвшилцөх асуудлуудыг хэлэлцэж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлсэн.

Бусад ажлын талаар:

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд нэг тайлан хэлэлцэж, Байнгын хорооны дөрвөн тогтоол батлуулсан байна.

1. “Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн ерөнхий бүдүүвч, орон тооны дээд хязгаарыг батлах тухай” Байнгын хорооны тогтоол баталсан.

2. “Төрийн аудитын байгууллагаас 2017 онд хийх аудитын сэдэв батлах тухай” Байнгын хорооны тогтоол баталсан.

3. “Засгийн газрын зарим тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн Үндэсний аудитын газрын нийцлийн аудитын тайланг хэлэлцээд:

1/Улсын төсвийн нэгдмэл байдлыг хангах, тусгай сангуудын зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгох, үр дүнг дээшлүүлэх, хоорондын уялдаа холбоог сайжруулах, давхардлыг арилгах, сангуудын зохицуулалтыг нэг хуулиар зохицуулах зорилгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх;

2/тусгай сангийн үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй, санхүүгийн эх үүсвэрийг хуулиар тодорхойлсон заалт бүрээр бүрдүүлээгүй, сангийн хөрөнгийг хууль бусаар зарцуулсан албан тушаалтанд хариуцлага тооцох;

3/тусгай сангуудад үүссэн өр, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг улирал тутам тус Байнгын хороонд танилцуулж ажиллах талаар Засгийн газарт чиглэл өгөв.



Төсвийн байнгын хорооны дарга Ч.Хүрэлбаатар Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Масато Такаокаг өөрийнх нь хүсэлтээр хүлээн авч уулзлаа. 2017.02.09



Байнгын хорооны дарга Ч.Хүрэлбаатар ОУВС-гийн ажлын хэсгийн ахлагч Коши Матай, Монгол дахь ОУВС-гийн суурин төлөөлөгч Нейл Сакер нарыг хүлээн авч уулзлаа. 2016.11.02

Зургаа. ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ



ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2016 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ш.РАДНААСЭД



19 ГИШҮҮН

27
удаа

ХУРАЛДААН

63,15
ХУВЬ

ХУРАЛДААНЫ
ИРЦ

БАТЛУУЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ

8

удаа

ХУУЛЬ

12

удаа

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

66

удаа

НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛСАН

- Хуулийн төсөл - **80**
- УИХ-ын тогтоолын төсөл - **12**
- Танилцуулга - **8**
- Санал, дүгнэлт - **40**
- Зарчмын зөрүүтэй санал - **670**
- Өргөдөл, гомдол - **35**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **110**

явуулсан албан бичиг **102**

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Тус Байнгын хороо бие даасан 8 хууль, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 66, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 6, Улсын Их Хурлын тогтоолын төсөл 12-ыг тус тус хэлэлцэн, нэгдсэн хуралдаанаар батлууллаа.

Түүнчлэн Байнгын хорооны хуралдаанаар 18 асуудал хэлэлцсэн.

Тухайлбал, Үндсэн хуулийн цэцийн дунд болон их суудлын хуралдаанд оролцох Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох тухай асуудал, Оросын Холбооны Улсын Засгийн газар болон тус улсын “Ростех” корпорацийн “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Монголросцветмет” ХХК-ийн эзэмшиж байсан 49 хувийн энгийн хувьцааг худалдсан талаархи асуудлаар Засгийн газраас авсан арга хэмжээний тухай болон холбогдох ажлын хэсгийн дүгнэлт, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаархи Хүний эрхийн үндэсний комиссын 15 дахь илтгэл, Засгийн газраас Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн шалгалтын талаархи ажлын хэсгийн мэдээлэл, Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчийг танилцуулах тухай асуудал, “Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай” Хууль зүйн байнгын хорооны тогтоолын төсөл, Улсын ерөнхий прокурорын орлогчийг зөвшилцөх тухай асуудал, “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслүүд, “Зөрчлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төсөл, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай” хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл гэх мэт.

Бусад ажлын талаар:

Үндсэн хуулийн цэцэд итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай Улсын Их Хурлын даргын захирамжийн төсөл дөрвийг боловсруулан албажууллаа.

Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүх шийдвэрээ энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн, эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэх Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаан болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн, эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэх Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд холбогдох тайлбарыг бичиж хүргүүлсэн.

Түүнчлэн Хууль зүйн байнгын хорооноос Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хэлэлцүүлгийн шатанд байгаа хуулийн төслүүдийн талаар холбогдох байгууллагуудтай хамтран хэлэлцүүлэг, семинарыг, мөн батлагдсан хууль тогтоомжийг иргэд, нийслэлийн болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад таниулан сурталчлах ажлын хүрээнд сургалт, зөвлөлгөөнийг тус тус зохион байгуулсан.

Тухайлбал:

- 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Хуульчдын холбоотой хамтран “Арбитрын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг”-ийг Хууль зүйн үндэсний хүрээлэнд хийлээ.
- 2017 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яам болон Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран “Хууль төрөхийн өмнө” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэг хийв. 2017.01.23



Хууль зүйн байнгын хорооноос “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн асуудлаар мэдээлэл хийлээ. 2017.01.24



“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийн талаархи хэлэлцүүлэг”-ийг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран Төрийн ордонд зохион байгуулав. 2016.10.06



Байнгын хорооны гишүүд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилтай танилцаж, хороодын нийгмийн ажилтан, цагдаагийн хэлтсийн албан хаагчидтай уулзалт хийв. 2016.11.22



Байнгын хорооны дарга Ш.Раднаасэд Нидерланд Улсын “Хил хязгааргүй чөлөөт хэвлэл” байгууллагын мэргэжилтэн Марсел Ооменс тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. 2016.10.24

Долоо. ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО



ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2016 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Д.ТЭРБИШДАГВА



19 гишүүн

32

удаа

ХУРАЛДААН

63,15

хувь

ХУРАЛДААНЫ
ИРЦ

АЖЛЫН ХЭСЭГ

8

удаа

БАЙГУУЛЖ

10

удаа

НИЙТ
ХУРАЛДСАН

- Хэлэлцсэн асуудал - **60**
- Хуулийн төсөл - **2**
- УИХ-ын тогтоолын төсөл - **13**
- Байнгын хорооны тогтоол - **9**
- Гэрээ, хэлэлцээр зөвшилцөх - **4**
- Санал, дүгнэлт - **30**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **115**

явуулсан албан бичиг **40**

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд зохион байгуулсан ажлууд нь Эдийн засгийг сэргээх хөтөлбөр, Хөгжлийн банкны тухай хуулийг хэлэлцэн батлах, төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг тус тус тодорхойлох, Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээ сангийн зарлагын 2017 оны төсвийг батлах, “Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 64 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт оруулах, 2017 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Байнгын хорооны санал, дүгнэлт гаргаж, хэлэлцүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зарим яам, газруудын тайлан, мэдээлэл сонсож, үүрэг чиглэл өгөх зэрэгт чиглэгдлээ.

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Байнгын хороо давхардсан тоогоор 60 орчим асуудал хэлэлцэж, тэдгээр асуудлаар нийтдээ 30 санал дүгнэлт, танилцуулга бэлтгэн гаргаж, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсний зэрэгцээ хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы хэлэлцүүлэгт бэлтгэх чиглэлээр найман ажлын хэсэг байгуулан ажиллууллаа.

Ээлжит чуулганы хугацаанд нийт хоёр хууль, 13 тогтоолыг эцэслэн баталж, Олон улсын дөрвөн гэрээ, хэлэлцээрийн төслийг зөвшилцлөө.

Хяналт шалгалтын ажлын талаар:

Тайлант хугацаанд “Төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт, төмөр замын транзит тээврийн байдал, тулгамдсан асуудлууд”, “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын хэрэгжилт”, “Хөшигийн хөндийн шинэ нисэх буудлын ажлын явц, байдал, тулгамдсан асуудлууд”-ын талаар Зам, тээврийн хөгжлийн сайдын, “Монголын хөрөнгийн зах зээлийн байдал, цаашдын чиг хандлага” сэдвээр Санхүүгийн зохицуулах хорооны даргын, “Төрийн банкны үйл ажиллагаа, хувьчлах бэлтгэл ажлын явц”-ын талаархи Төрийн банкны ТУЗ-ийн даргын мэдээлэл, “Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт, эрчим хүчний чиглэлээр эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөрт туссан төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлын явц байдал, шийдвэрлэх асуудлууд”-ын талаар Эрчим хүчний сайдын мэдээллийг зохион байгуулав.

“Аялал, жуулчлалын салбарын өнөөгийн байдал болон эдийн засгийг сэргээх хөтөлбөрт аялал, жуулчлалын талаар тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын явц, тулгамдсан асуудлууд”-ын талаархи Байгаль

орчин, аялал жуулчлалын сайдын, “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт, “2017 оны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын явц байдлын талаархи Монголбанкны ерөнхийлөгчийн, “Хууль зүйн байнгын хорооны 2016 оны 06 дугаар тогтоолоор байгуулагдсан Оросын Холбооны Улсын Засгийн газар болон тус улсын өндөр технологийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн бүтээх, үйлдвэрлэх, экспортлох ажиллагааг дэмжих “Ростех” улсын корпорацийн “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Монголросцветмет” ХХК-д эзэмшиж байсан 49 хувийн энгийн хувьцааг Монголиан Коппер Корпорейшн ХХК худалдан авсантай холбогдох асуудал”-ыг иж бүрнээр нь шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг тус тус сонсох ажлыг зохион байгуулж, үүрэг чиглэл, зөвлөмжүүдийг Байнгын хорооны тогтоол болон хуралдааны тэмдэглэл хэлбэрээр хүргүүлэх арга хэмжээ авлаа.

Бусад ажлын талаар:

Намрын ээлжит чуулганы хугацаанд Санхүүгийн зохицуулах хороотой хамтарсан “Санхүүгийн зах зээлийн үндэсний форум-2016” сэдэвт нийт 600 гаруй хүн оролцсон үндэсний форумыг зохион байгуулсан.

Намрын ээлжит чуулганы хугацаанд тус Байнгын хороо Монголбанкт хамтран банк, санхүүгийн чиглэлээр төрийн бус байгууллагууд, мэргэжлийн эрдэмтэн, судлаачдыг оролцуулсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл-хэлэлцүүлэг”-ийг зохион байгууллаа.

Ээлжит чуулганы хугацаанд тус Байнгын хороо Бүртгэл, статистикийн ерөнхий газарт “Үндэсний тооцооны мэдээллийн тогтолцоо, мэдээлэл гаргаж байгаа байдал, цаашид авч хэрэгжүүлэх ажил”, “2015 оны мөнгөний бодлогын хэрэгжилт, инфляцийн өсөлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” сэдэвт танилцах уулзалт, ярилцлагыг Монголбанкинд зохион байгуулав.

Мөн хугацаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн болон Эрчим хүчний яамны үйл ажиллагаатай Байнгын хорооны гишүүдийн танилцах хоёр удаагийн уулзалтыг зохион байгуулав.

Тайлант хугацаанд тус Байнгын хорооноос хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл болон бусад материалыг 400 гаруй удаа олшруулж тараав.

Ээлжит чуулганы хугацаанд батлагдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хувийн хэрэг есөн нэгж, хуралдааны тэмдэглэл гурван нэгж, албан бичиг таван нэгжийг тус тус бүрдүүлж, архивт хүлээлгэн өгөөд байна.



“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2018-2019 оны хандлага” болон “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах Үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг иргэдэд тайлбарлан сурталчлахад зориулан арга зүйн хялбарцуулсан гарын авлага, танилцуулгыг боловсруулж, хэвлүүлэх ажлыг зохион байгууллаа. 2016.11.01



“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах Үндсэн чиглэл”-ийн төслийн талаархи хэлэлцүүлэг болов. 2016.10.25



Эдийн засгийн байнгын хорооны гишүүд Санхүүгийн зохицуулах хорооны ажилтай танилцлаа. 2017.01.17

Найм. ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО



ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2016 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Д.САРАНГЭРЭЛ



19 гишүүн

7

удаа

ХУРАЛДААН

63,15

хувь

ХУРАЛДААНЫ

ИРЦ

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ

17232

УИХ-д иргэнээс

1874

өргөдөл

9056

Байнгын хороонд

435

өргөдөл

- Хэлэлцсэн асуудал - **11**
- Байнгын хорооны тогтоол - **7**
- Засгийн газарт өгсөн чиглэл - **4**
- Сайдын мэдээлэл - **2**
- Санал, дүгнэлт - **30**
- Зөвлөмж - **1**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **174**

явуулсан албан бичиг **133**

Улсын Их Хуралд 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд 17232 иргэнээс 14492 хуудас бүхий 1874 өргөдөл /нийслэлийн иргэдээс 1324 буюу 70,6 хувь, хөдөө орон нутгийн иргэдээс 550 буюу 29,3 хувь/ ирүүлсэн байна. Үүнээс 220 буюу 11,7 хувь нь нийтийн эрх ашгийг төлөөлсөн, 1365 буюу 72,8 хувь нь хувийн асуудлаар хандсан өргөдөл байна. Улсын Их Хурлын гишүүний нэр дээр гарт нь хаягласан өргөдөл 289 байна.

Байнгын хороогоор хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлын талаар:

Өргөдлийн байнгын хороо нийт 7 удаа хуралдаж, 11 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж 7 тогтоол, 1 зөвлөмж, 2 албан бичгээр Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгч, иргэдийн өргөдлөөр тавигдсан асуудлыг шийдвэрлэсэн байна.

Тухайлбал, Туул голын бохирдлын асуудлаар ирүүлсэн өргөдлийг Улсын Их Хурлын гишүүн А.Сүхбатаар ахлуулсан Улсын Их Хурлын гишүүн Ц.Гарамжав, Д.Дамба-Очир, Г.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Б.Энх-Амгалан нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж Туул голыг хамгаалах, бохирдлыг бууруулах, Туул голын сав газрыг тусгай хамгаалалтад авах тухай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барьж эхлэх, шийдлийг гаргах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтад оруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар Байнгын хорооны 3 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл болгов.

Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн асуудлаар ирүүлсэн өргөдлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, М.Оюунчимэг нар хянан үзээд Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, сонгон шалгаруулалтын журамд өөрчлөлт оруулах, сурагчдад эрүүл ахуйн шаардлага хангахгүй, чанаргүй бүтээгдэхүүн өгч байгаа зөрчлүүдийг арилгах арга хэмжээний талаар 7/6587 тоот албан бичгийг Засгийн газар болон Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлэв.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ур чадвар олгох, хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр иргэдийн саналыг нэгтгэн “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 7/5106 тоот албан бичгээр нийт есөн санал хүргүүлснээс таван санал батлагдсан.

Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр болон гамшгийн үед авах хойшлуулшгүй арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, аймаг, нийслэлд эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглалтад оруулах ажлыг шуурхайлах, утааны эсрэг сургалт, сурталчилгаа явуулах, аж ахуйн нэгжүүдийн санал санаачилгыг дэмжих, төрийн байгууллага, албан тушаалтан, иргэдийн хариуцлагыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээ авахыг Байнгын хорооны 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Засгийн газарт чиглэл болгов.

Хяналт шалгалтын ажлын талаар:

Туул голын бохирдлын асуудлаар ирүүлсэн өргөдлийн дагуу холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, шийдвэрийн төсөл боловсруулан Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг 2016 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Усны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, Туул голын бохирдол, Төв цэвэрлэх байгууламж болон "Харгиа" цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, шинэчлэлийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцан, шалгаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Туул голын сав газрын захиргаа, нийслэлийн Засаг даргад тодорхой үүрэг, чиглэл өгч ажиллалаа.

Бусад ажлын талаар:

Иргэдээс Улсын Их Хуралд өргөдөл гаргах боломжийг бүрдүүлэх, хөнгөвчлөх, төрийн байгууллагуудын өргөдөл шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, олон нийтэд нээлттэй, ил тод байх, иргэдээс өргөдөл шийдвэрлэлтийн ажиллагаанд хяналт тавих, олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг хийх боломжийг бүрдүүлсэн Өргөдлийн байнгын хорооны мэдээллийн удирдлагын систем буюу вебсайт, дотоод программ хангамжийн системийг хөгжүүлж байна.

Өргөдлийн байнгын хорооны мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах зорилгоор иргэдэд өргөдөл гаргах зөвлөмж болон Байнгын хорооны үйл ажиллагааны товч танилцуулга бүхий гарын авлага, нугалбарыг шинэчлэн хэвлүүлж нийслэлийн болон орон нутгийн иргэдэд тарааж, мэдээллээр хангаж ажилласан.



Байнгын хорооны гишүүд “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцлаа. 2017.01.17



Өргөдлийн байнгын хорооны дарга Д.Сарангэрэл эцэг, эхчүүдийн төлөөллийг хүлээн авч уулзлаа. 2016.12.27



“Агаарын бохирдол ба Улаанбаатарын утаа” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг холбогдох яамд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан хийв. 2016.12.26



Байнгын хорооны дарга Д.Сарангэрэл болон УИХ-ын гишүүн Б.Саранчимэг, М.Билэгт нар Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн Хүүхдийн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцлаа. 2016.11.08



Байнгын хорооны дарга Д.Сарангэрэл, УИХ-ын гишүүн М.Оюунчимэг, Б.Саранчимэг нар нийслэлийн зарим ерөнхий боловсролын сургуулиудаар орж “Үдийн цай” хөтөлбөрийн чанар, хүртээмжтэй танилцлаа. 2016.12.12


ГУРАВ

ҮЛСЫН ИХ ХҮРЛЫН ХЯНАН ШАЛГАХ
ҮЙЛ АЖИЛААГАА

ГУРАВ.УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.Хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах ажлын талаар

Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд



ХЯНАЛТ ХИЙЖ АЖИЛЛАСАН

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО

Туул голын бохирдлын асуудлаарх өргөдлийн дагуу хяналт шалгалт хийж, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг зарим компанийн үйл ажиллагаатай танилцаж, санал, дүгнэлтээ Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, 03 дугаар тогтоолоор Засгийн газарт 13 заалт бүхий үүргийг өгсөн.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРОО

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн явц, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах талаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, Ерөнхий боловсролын тусгай хэрэгцээт сургуулиудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсэг газар дээр нь очиж танилцан, санал дүгнэлтээ боловсруулж Улсын Их Хурлын тогтоол гаргах нь зүйтэй гэж үзсэн байна.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

Олон нийтийн радио, телевизийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж, санал дүгнэлтээ Байнгын хорооны 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, 06 дугаар тогтоол гаргасан байна.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн эдийн засаг, санхүүгийн байдлыг хянан шалгах, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, санал, дүгнэлтээ Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО

Оросын Холбооны Улсын Засгийн газар болон тус улсын өндөр технологийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн бүтээх, үйлдвэрлэх, экспортлох ажиллагааг дэмжих “Ростех” улсын корпорацийн “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Монголросцветмет” ХХК-д эзэмшиж байсан 49 хувийн энгийн хувьцааг “Монголиан Коппер Корпорейшн” ХХК худалдан авсантай холбогдох асуудлыг иж бүрнээр нь шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, Улсын Их Хурлын тогтоолыг чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж батлуулав.

3.2. Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан асуулга, асуултын талаар

Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 16 гишүүн Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Монголбанкны ерөнхийлөгчид хандан 15 удаагийн асуулга тавьж, түүнд 45 асуудлыг тусгажээ. Дараах асуулгын хариуг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар сонссон байна.




Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг “Бүх шатны боловсролын байгууллагын хүртээмж, орчин нөхцөл, хамрагдалтын байдал, цаашид авах арга хэмжээний талаар”, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр “1995-2015 оны Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө, түүний зарцуулалт, Нийгмийн даатгалын сангийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар”, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал “Инновацийн тухай хууль”, “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль”-ийн хэрэгжилт, хуулийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан болон батлагдан гарах журмууд, Засгийн газрын 2014 оны 374 дүгээр тогтоолын хэрэгжилт болон Үндэсний инновацийн тогтолцоо, инновацийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар” Монгол Улсын Ерөнхий сайдад, Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва “Мал аж ахуйн салбарын хөгжлийг шинэ шатанд гаргах, биологийн онцгой шинж бүхий монгол малын ашиг шимийг бүрэн ашиглах чиглэлээр цаашид баримтлах бодлого, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээ болон төр, Засгийн газар, салбарын түвшинд ямар бодлого шийдвэр, дэмжлэг шаардлагатай байгаа талаар” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар “Хууль тогтоомжийн тухай хууль 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжих нөхцөл байдал хангагдсан эсэх асуудлаар” Хууль зүй, дотоод хэргийн сайдад, Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан “Эрчим хүчний зохицуулах хорооны 2015 оны 07 дугаар 06-ны өдрийн “Тариф батлах тухай” 199 дүгээр тогтоолын хэрэгжилт нь барилгын салбарыг дэмжих төрийн бодлоготой хэрхэн нийцэж байгаа талаар болон дотоодын аж ахуйн нэгжүүдийг дэмжих чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” Эрчим хүчний сайдад тус тус тавьсан 6 асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонссон байна.

Нэгдсэн хуралдаанд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 47 гишүүн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 50 дугаар

зүйлд заасны дагуу амаар 149 асуулт тавьж, хариулт авч, санал хэлсэн байна.
/Дэлгэрэнгүйг "Мэдээ-1" хүснэгтээс үзнэ үү/

3.3.Монгол Улсын Ерөнхий сайдын нэгдсэн хуралдаанд хийсэн мэдээллийн талаар

Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат “Эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар”, “Ургац хураалтын дүн мэдээ, мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар”, “Нийгмийн халамжийн чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар”, “Дээд боловсролын сургалтын тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар”, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар” зэрэг улс орны тулгамдсан асуудлаар нийт таван удаа мэдээлэл хийж, мэдээллийн үеэр давхардсан тоогоор Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн 11 гишүүн 34 асуулт тавьж, хариулт авсан байна.



/Дэлгэрэнгүйг "Мэдээ-2" хүснэгтээс үзнэ үү/

Ээлжит чуулганы хугацаанд Байнгын хорооны хуралдаанд Засгийн газрын гишүүд болон холбогдох бусад байгууллагаас нийтдээ 35 удаагийн мэдээлэл хийсэн бөгөөд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 166 гишүүн 688 асуулт асууж, хариулт авч санал хэлсэн байна.

/Дэлгэрэнгүйг "Мэдээ-3" хүснэгтээс үзнэ үү/

Мэдээ-1

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН ТАВЬСАН АСУУЛГЫН ТАЛААРХИ МЭДЭЭ

№	Улсын Их Хурлын гишүүний нэр	Хэнд, ямар байгууллагад хандаж тавьсан	Асуулгын агуулга	Хамрагдсан асуудлын тоо	Албан бичгийн огноо			Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан			Тайлбар
					Хүргэсэн	Ирүүлсэн	Хугацаа хэтэрсэн эсэх	Асуулгын харууг сонсох гишүүний санал	Нэгдсэн хуралдаанд сонссон огноо	Аман асуулт тавьсан гишүүний тоо, асуулт	
1	М.Оюунчимэг	Монгол Улсын Ерөнхий сайд	Бүх шатны боловсролын байгууллагын хүртээмж, орчин нөхцөл, хамрагдалтын байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар	4	2016.07.22 №01	2016.08.18 ХЭГ/1345	-	2016.10.07 №3182	2016.10.28	15/52	Сонссон
2	Д.Тэрбишдагва	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Мал аж ахуйн салбарын хөгжлийг шинэ шатанд гаргах, биологийн онцгой шинж бүхий монгол малын ашиг шимийг бүрэн ашиглах чиглэлээр цаашид баримтлах бодлого, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээ болон төр, засгийн газар, салбарын түвшинд ямар бодлого шийдвэр, дэмжлэг шаардлагатай байгаа талаар	2	2016.09.16 №02	2016.10.18 01/790	5	2016.11.02 №4222	2016.11.11	13/34	Сонссон

	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	Монгол Улсын Засгийн газраас Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих болон төслийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, гэрээний талуудын үүргийн биелэлт, далд уурхайн бүтээн байгуулалтын явц байдлын талаар	3	2016.09.19 №03	2016.10.20 01/565	6	2016.11.02 №4222	2016.12.09- ний өдрийн нэгдсэн хралдаанаар сонсох хуваарьт орсон.	Хойшилсон
3 Д.Тэрбишдагва Ч.Улаан			4	2016.10.06 №04	2016.10.18 А-1/1176	-	2016.11.14 №4776		Хүлээгдэж байна
5 Н.Учрал	Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат	"Иновацийн тухай хууль", "Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль"- ийн хэрэгжилт, хуулийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан болон батлагдан гарах журмууд, Засгийн газрын 2014 оны 374-р толголын хэрэгжилт болон Үндэсний инновацийн тогтолцоо, инновацийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар	4	2016.11.04 №05	2016.12.05 ХЭГ/2052	2	2016.12.14 №6260	2017.01.27	7/18 Сонссон

6	Х.Нямбаатар	Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт	"Хууль тогтоомжийн тухай хууль" 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжих нөхцөл байдал бүрэн хангалдсан гэж үзэж байгаа эсэх талаар	1	2016.11.07 №06	2016.12.02 1-1/1762	4	2016.12.14 №6300	2016.12.23	5/14	Сонссон
7	Н.Амарзана	Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат	Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутай орших Тост, Тосон Бумбын нуруу орчмын газар нутгийн хилийн заагийг тогтоох ажлын явц, Засгийн газрын 2015 оны тогтоолоор нөөцөд авсан Тост, Тосон Бумбын нуруу орчимд олгогдсон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүртгэлийг цэгцлэх талаар	2	2016.11.08 №07						2016.11.22- ны өдрийн 5234 тоот албан бичгээр асуулгын хариуг хойшуулах хүсэлт явуулсан.
8	З.Нарантуяа	Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат	Шилэн дансын тухай хуулийн хэрэгжилтийн талаар одоогийн нөхцөл байдал, шилэн данс хөтөлдөг хэдэн төрийн байгууллага, төсөв захирагч байгаа талаар, үүнтэй холбоотой хийгдэж буй ажлууд болоод цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар	1	2016.11.11 №08	2016.12.15 ХЭГ/2139	5				Сонсох санал ирээгүй

9	Б.Баттөмөр	Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат	1995-2015 оны Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө, түүний зарцуулалт, Нийгмийн даатгалын сангийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар	4	2016.11.11 №09	2016.12.08 ХЭГ/2092	-	2016.12.13 №6131	2017.01.27	2/5	Сонссон
10	Т.Аюурсайхан	Эрчим хүчний сайд П.Ганхүү	Эрчим хүчний зохицуулах хорооны 2015.07.06-ны өдрийн “Тариф батлах тухай” 199 дүгээр тогтоолын хэрэгжилт, барилгын салбарыг дэмжих төрийн бодлоготой хэрхэн нийцэж байгаа талаар болон дотоодын аж ахуйн нэгжүүдийг дэмжих чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар	3	2016.11.18 №10	2016.12.02 А/3127	-	2016.12.16 №6493	2017.02.03	7/24	Сонссон
11	Г.Занданшатар	Хууль зүй, дотоод хэргийн хэргийн сайд С.Бямбацогт	Монгол Улсын хэмжээнд хар тамхи, мансууруулах бодисын эргэлтэд өнөөгийн нөхцөл байдал, гэмт хэргийн гаралт, түүний шалтгаан, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар	4	2016.11.18 №11	2016.12.28 №1-1/2266	6	2017.01.04 №88			Хүлээгдэж байна

12	Л.Энхболд	Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат	"Эрдэнэс таван толгой" ХК-ийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар	5	2016.12.20 №12	2017.01.19 ХЭГ/96	-	2017.01.27 №992	Хүлээгдэж байна	
13	С.Эрдэнэ	Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат	Нийслэлийн агаарын бохирдлын хэмжээг бууруулах чиглэлээр хийж буй ажлууд болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар	1	2016.12.22 №13	2017.01.20 ХЭГ/102	-	2017.02.03 №01/06	Хүлээгдэж байна	
14	Д.Сарангэрэл	Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Цэвэр агаар сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаар	3	2016.12.22 №14	2017.01.23 ХЭГ/116	-	2017.01.25 №792	Хүлээгдэж байна	
15	Д.Сумъяабазар	Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар	4	2017.01.03 №01	2017.02.02 01/342	-	2017.02.03 №1309	Хүлээгдэж байна	
ДҮН-16				45	-	-	4,6	13	6	49/147

Мэдээ-2

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД СОНССОН
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ

№	Сэдэв	Мэдээлэл хийсэн сайд	Мэдээллийг сонссон огноо	Асуулт асууж, санал хэлсэн УИХ-ын гишүүдийн тоо	Нийт асуулт, саналын тоо
1.	Эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат	2016.11.04	4	11
2.	Ургац хураалтын дүн мэдээ, мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат	2016.11.18	1	4
3.	Нийгмийн халамжийн чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат	2016.12.02	3	9
4.	Дээд боловсролын сургалтын тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат	2016.12.16	1	4
5.	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат	2017.01.06	2	6
Дүн - 5				11	34

Мэдээ-3

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ

№	Байнгын хорооны нэр, огноо	Мэдээлэл хийсэн байгууллага, албан тушаалтны нэр	Мэдээллийн Сэдэв	Асуулт асууж, санал хэлсэн УИХ-ын гишүүдийн тоо	Нийт асуулт, саналын тоо
1	Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо 2016.11.15	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч Биата Транкман	НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн талаар	4	5
2	Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо 2016.11.15	Засгийн газар, Үндэсний хөгжлийн газрын судалгаа, шинжилгээний албаны дарга А.Мөнхболд	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 хөтөлбөрийн талаар	4	10
3	Эдийн засгийн байнгын хороо 2016.11.02	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж	Ашигт малтмалын лиценз олголт, газрын тосны хайгуулын зөвшөөрөл бүхий компаниудын хайгуулын болон олборлолтын үйл ажиллагааны явц, Тавантолгой болон стратегийн ач холбогдол бүхий бусад ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр хийгдэж байгаа ажлын явц, Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн явц байдал, цаашдын чиг хандлагын талаар	5	22
4	Эдийн засгийн байнгын хороо 2016.11.08	Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат	Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын хэрэгжилт, Хөшигийн хөндийн шинэ нисэх буудлын ажлын явц, байдал, тулгамдсан асуудлын талаар	9	52

5	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2016.11.09	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр	Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааны талаар	4	11
6	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2016.11.09	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр	Хүүхэд харах үйлчилгээний талаар	3	9
7	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2016.11.15	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол	Нийслэл хот болон томоохон суурин газрын агаарын бохирдлын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замын талаар	4	20
8	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2016.11.15	“Любрикон Монголиа” ХХК-ийн захирал Э.Эрдэнэбаатар, “Монватт” ХХК-ийн захирал Т.Пүрэвдорж, “Эко Ресурс” ХХК-ийн ТУЗ-ын дарга Ш.Цогтбаатар	Агаарын бохирдол бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зарим аж ахуйн нэгжийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний танилцуулгын талаар	3	10
9	Эдийн засгийн байнгын хороо 2016.11.16	Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл	Төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт, төмөр замын транзит тээврийн байдал, тулгамдсан асуудлуудын талаар	7	38
10	Төрийн байгуулалтын байнгын хороо 2016.11.16	Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн	Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн дүнгийн талаар	2	4
11	Хууль зүйн байнгын хороо 2016.11.16	Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж	Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаархи Хүний эрхийн үндэсний комиссын 15 дахь илтгэл	1	1

12	Эдийн засгийн байнгын хороо 2016.11.22	Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн	Монголын хөрөнгийн зах зээлийн байдал, цаашдын чиг хандлагын талаар	7	34
13	Эдийн засгийн байнгын хороо 2016.11.22	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Нямаа	Төрийн банкны үйл ажиллагаа, хувьчлах бэлтгэл ажлын явц, байдлын талаар	5	14
14	Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо 2016.11.23	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулга	Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн хэрэгжилт болон жижиг, дунд үйлдвэрийн салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд, тулгамдсан бусад асуудлуудын талаар	5	33
15	Эдийн засгийн байнгын хороо 2016.11.29	Эрчим хүчний сайд П.Ганхүү	Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт, эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөрт эрчим хүчний чиглэлээр туссан зорилт, арга хэмжээний бэлтгэл ажлын явц байдал, тулгамдсан асуудлын талаар	7	45
16	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2016.11.30	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол	Байнгын хорооны 2015 оны 05, 07 тоот тогтоолын биелэлтийн талаар	1	2
17	Эдийн засгийн байнгын хороо 2016.12.20	Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр	Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилт, барилгын салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудын талаар	3	20
18	Эдийн засгийн байнгын хороо 2016.12.14	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын өр, зээлийг барагдуулж, ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн болон 2017 онд хувьчлагдах объектуудын хувьчлалын бэлтгэл ажлын явц, байдал, тулгамдсан асуудлуудын талаар	9	39

19	Эдийн засгийн байнгын хороо 2016.12.27	Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан	Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагаа, гадаадын хөрөнгө оруулалтын байдал, Концессийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар	7	32
20	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хөдөө аж ахуйн байнгын хороо 2016.12.27	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн	Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын 2016 оны 46 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар	6	19
21	Эдийн засгийн байнгын хороо 2017.01.04	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн	Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн хэрэгжилт, хүнс хөнгөн аж үйлдвэрийн хөгжлийн талаар	8	30
22	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2017.01.10	Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Г.Манлайжав	Цөмийн энергийн салбарын өнөөгийн байдлын талаар	4	17
23	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2017.01.18	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат	Төрийн ордны барилгын өнөөгийн байдлын дүгнэлт, чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангах зарим арга хэмжээний талаар	3	7
24	Өргөдлийн байнгын хороо 2017.01.24	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр	“Ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах арга зам” сэдэвт хэлэлцүүлэгт оролцогчдоос гаргасан саналын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар	7	27
25	Төрийн байгуулалтын байнгын хороо 2017.01.31	МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн дарга Б.Энхмандах	Байнгын хорооны 2016 оны 07 тоот тогтоолын хэрэгжилтийн талаар	2	2
26	Эдийн засгийн байнгын хороо 2017.02.01	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол	Аялал, жуулчлалын салбарын өнөөгийн байдал болон эдийн засгийг сэргээх хөтөлбөрт аялал, жуулчлалын талаар тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын явц, тулгамдсан асуудлуудын талаар	8	24

27	Өргөдлийн байнгын хороо 2017.02.01	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж	Өргөдлийн байнгын хорооноос “Туул голын бохирдлын асуудлаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2016 оны 03 дугаар тогтоолын биелэлт, явцын талаар	4	15
28	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2017.02.01	Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил	Гадаад харилцааны яамны 2016 оны тайлан	Хаалттай хуралдаан	
29	Төсвийн байнгын хороо 2017.02.01	Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга Б.Алтанзул	Үндэсний аудитын газраас Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлан	4	7
30	Эдийн засгийн байнгын хороо 2017.02.07	Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайхан	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт, 2017 оны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын явц байдлын талаар	9	31
31	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2017.02.08	Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр	Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар	9	51
32	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2017.02.08	Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг	Эрүүл мэндийн салбарын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор хийж байгаа ажлын явц байдлын талаар	7	22

33	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2017.02.08	Байгаль орчин, аялал жуучлалын сайд Д.Оюунхорол	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03-03 тоот зөвлөмжийн дагуу агаарын бохирдлыг бууруулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний талаар	5	35
34	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2017.02.08	Эрчим хүчний сайд П.Ганхүү	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 12/5391 албан тоотын 6, 7, 8 дахь заалтын биелэлтийн явц, үр дүнгийн талаар		
35	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2017.02.08	Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ	Батлан хамгаалах яамны 2016 оны үйл ажиллагааны тайлан		
				166	688

ДҮН-35

ДӨРӨВ

ҮЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛААГАА

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Мэдээлэл, сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаа

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс нь Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хууль тогтоох үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд бодитой, шуурхай, дэлгэрэнгүй мэдээлэл түгээн ажиллалаа.

Ээлжит чуулганы хугацаанд “Төрийн мэдээлэл” хууль тогтоомжийн эмхэтгэлийн 18 дугаарыг бэлтгэн хэвлүүлж, уншигч, захиалагчдад хүргэв. Эмхэтгэлийн 18 дугаарт нийт 72 хууль, Улсын Их Хурлын тогтоол 48, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 30, Засгийн газрын тогтоол 22, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт зургаа нийтлэгдсэн байна. Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд нийт 95300 ширхэг хууль тогтоомжийн эмхэтгэлийг уншигч, захиалагчдад түгээжээ.

УИХ-ын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор “Монгол Улсын Их Хурал” танилцуулга товхимлыг хэвлүүлж, олон нийтэд түгээх ажлыг хэрэгжүүлж байна.

БЭЛТГЭЖ ТҮГЭЭСЭН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ



Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, чуулган болон Байнгын хороодын хуралдааны тойм, Улсын Их Хурлын дарга, гишүүд, Тамгын газраас зохион байгуулсан хэвлэлийн бага хурал, Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны талаар нийт 363 мэдээллийг текст хэлбэрээр бэлтгэн 1500 орчим гэрэл зургийн хамт www.parliament.mn цахим хуудсанд байршуулан түгээв. Түүнчлэн энэ хугацаанд Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаархи 15 мэдээ, мэдээллийг англи хэл рүү хөрвүүлж, дөрвөн удаа фото нийтлэл бэлтгэн олон нийтэд шуурхай хүргэлээ.

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойн хүрээнд www.parliament.mn цахим хуудсанд тусгай цэс үүсгэн түүхэн баримт бичиг, нийтлэл, архивын лавлагааны материалууд нийтэлж, ойн хүрээнд болсон бүх арга хэмжээний мэдээ, мэдээллийг багцлан хэвлэл мэдээллийн байгууллагууд, олон нийтэд хүргэлээ. Мөн Үндсэн хуулийн үзэл баримтлал, ач холбогдлыг сурталчлах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, энэ хүрээнд Улсын Их Хурлын гишүүд, Ардын Их Хурлын депутатуудыг телевиз, радио, сонин, сайтын ярилцлагад оролцуулах ажлыг зохион байгууллаа.

Ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын долоо хоног тутмын үйл ажиллагааг тоймлон хүргэдэг “Улсын Их Хурал-Энэ долоо хоног” тойм нэвтрүүлгийн 16 дугаар, Улсын Их Хурлаар хэлэлцэж буй хууль, тогтоомжийн төслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэх, хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагаа болон цаг үеийн асуудлын талаархи Улсын Их Хурлын гишүүдийн байр суурийг олон нийтэд хүргэх “Улсын Их Хурлын гишүүнтэй ярилцах цаг” нэвтрүүлгийн 14 дугаар, Улсын Их Хурлын даргын гадаад, дотоод томилолтын гурван нэвтрүүлгийг бэлтгэж хамтран ажилладаг найман телевизээр хуваарийн дагуу нэвтрүүллээ. Үүний зэрэгцээ youtube.com, facebook.com, twitter.com цахим хуудаснаа нээлттэй байршуулсан. Түүнчлэн Улсын Их Хуралд хуулийн төслүүд өргөн мэдүүлсэн, Улсын Их Хурлын дарга болон гишүүд гадаад, дотоодын зочид төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан, Байнгын хороодоос зохион байгуулсан хэлэлцүүлэг, семинар, нээлттэй сонсгол, тэмдэглэлт үйл явдал болон Тамгын газрын үйл ажиллагааны талаар 215 дүрст мэдээг бэлтгэж www.parliament.mn цахим хуудсанд байршуулсны зэрэгцээ youtube.com, facebook.com, twitter.com олон нийтийн сүлжээнд нээлттэй байршуулав.

Улсын Их Хурлын Байнгын болон дэд хороод, Улсын Их Хурлын Тамгын газраас зохион байгуулсан нээлттэй сонсгол, хэлэлцүүлэг, уулзалт, семинар, ярилцлагад сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг өргөнөөр оролцуулах ажлыг зохион байгуулж ажиллав.



Үүнд, Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын удирдлагын зүгээс хийсэн 23 удаагийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, хэвлэлийн бага хурал, бусад үйл ажиллагааны талаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудад мэдээлэл хүргэн ажилласан. Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилт, цаашдын зорилт”, “Ажлын байрны бэлгийн дарамтыг устгах, эрх зүйн орчныг сайжруулах нь”, “Залуучуудын хөгжлийг дэмжих нь”, “Ариун цэврийн байгууламж-Нүхэн жорлон”, “Төв цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал, Хөрөнгө оруулалтын асуудал”, “Бэлгийн замаар дамжих халдварын өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ”, “Ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах арга зам”, “Эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, цаашид баримтлах бодлого”, “Инноваци-боловсрол, хөдөө аж ахуйн салбарт”, “Бэлчээрийн төлөв байдал тулгамдсан асуудал” зэрэг Байнгын хороодоос зохион байгуулсан хэлэлцүүлгүүдтэй холбогдогдуулж албан тушаалтнаас мэдээлэл бэлтгэн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлав.

Монгол Улсын Их Хурлын олон нийтийн сүлжээн дэх албан ёсны хуудсуудаар хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагааны талаархи мэдээ, мэдээллийг текст, фото, видео хэлбэрээр, мөн батлагдсан хууль, тогтоолын танилцуулга бүхий инфографикууд бэлтгэж олон нийтэд түгээв. Өнөөдрийн байдлаар facebook.com, parliament.mn цахим сүлжээн дэх Монгол Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсаар мэдээлэл хүлээн авах хэрэглэгчийн тоо 20,442-д хүрсэн бол twitter.com Монгол Улсын Их Хурал сүлжээгээр мэдээлэл хүлээн авах хэрэглэгчийн тоо 23400 болж нэмэгдсэн байна.

Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд facebook.com, twitter.com олон нийтийн сүлжээн дэх албан ёсны хуудсаар нийт 436 мэдээ, мэдээллийг давхардсан тоогоор 936 удаа түгээжээ. Мөн Улсын Их Хурлын албан ёсны Instagram хуудсыг шинээр үүсгэж, 2016 оны долдугаар сараас хойшхи бүх үйл ажиллагааг гэрэл зураг, тайлбарын хамтаар түгээж байна. Үүний зэрэгцээ Улсын Их Хурлын www.parliament.mn цахим хуудас шинэчлэгдэж, боловсронгуй болгох ажлыг холбогдох хэлтэс, мэргэжилтнүүдийн хамтаар гүйцэтгэж байна.

Олон нийттэй харилцах үйл ажиллагааны хүрээнд иргэдийг Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаатай танилцуулах аяллыг 380 гаруй удаа зохион байгуулж, 9545 гадаад, дотоодын зочдод үйлчиллээ. Мөн 70 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын 210 гаруй ажилтны парламентын үйл ажиллагааг сурвалжлах эрхийн үнэмлэхийг шинэчлэн олголоо. Мөн сэтгүүлчдэд зориулсан “Парламентын сурвалжлагчдын гарын авлага” номыг шинэчлэн хэвлүүлж, Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран “Улсын Их Хурлын үйл ажиллагаа, парламентын сэтгүүлчид” нэг өдрийн сургалтыг зохион байгууллаа.

4.2. Улсын Их Хуралд иргэд, сонгогчдоос ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт

2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороодод ирсэн өргөдөл, хүсэлтийн тоог доорхи зургаас харна уу.



Энэ хугацаанд Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороо хамтран 1220 буюу өргөдөл, гомдлын 65,2 хувийг бүрэн шийдвэрлэж, 654 буюу 34,8 хувийг судалж, шийдвэрлэх шатандаа байна.

Иргэдээс энэ хугацаанд 1874 өргөдөл ирүүлснээс 1324 буюу 70,6 хувь нь нийслэлийн иргэдээс, 550 буюу 29,3 хувь нь хөдөө орон нутгийн иргэдээс тус тус ирүүлсэн байна.

Иргэдийг хүлээн авах байраар нийт 762 иргэнийг биечлэн хүлээн авч уулзсанаас Улсын Их Хурлын бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хэлэлцэж буй хууль тогтоомжийн төслүүдтэй холбогдсон болон нийтэд тулгарч буй асуудлын талаар 30 хүн саналаа илэрхийлж, 732 хүний тавьсан хувийн хүсэлтийг Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслах нартай холбогдож, танилцуулан, зөвлөгөө өгөх, өргөдөл, гомдлын хариуг нь лавлах, шаардлагатай албан тушаалтантай нь холбогдож хариуг өгүүлэх зэргээр шийдвэрлэсэн болно.

4.3. Мэдээллийн технологи, техник ашиглалтын мэдээ

Хуралдааны цахим системийн үйлчилгээ:

Программ хангамж

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааны цахим системийг ашиглан Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд нэгдсэн хуралдаанд 34 удаагийн нийт 156,7 цагийн 1437 удаагийн санал хураалт явуулж, давхардсан тоогоор 292 удаа гишүүдийн болон ажлын хэсгийн микрофоныг нээж, үг хэлэх, асуулт асуух, асуултад хариулах боломжийг олгосон байна. Харин Байнгын болон дэд хороодын 149 удаагийн нийт 236,1 цагийн хуралдаанд 1940 удаа санал хураалт явуулж, давхардсан тоогоор 597 удаа микрофон нээж ажиллуулсан байна.



Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний ирцийн мэдээг нэгдсэн хуралдаантай өдөр бүр нарийвчлан гаргаж www.parliament.mn цахим хуудсанд 31 удаа байршуулсан.

Хуралдааны дүрсний систем

Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд 34 удаагийн нэгдсэн хуралдаан, 149 удаагийн Байнгын болон дэд хороодын хуралдаан, 23 удаагийн ажлын хэсэг, мэдээллийн цаг, сургалт семинар, уулзалтын дүрс бичлэгийг хийсэн байна. Мөн хуралдааны бүх дүрс бичлэгүүдийг хөрвүүлэн компьютерийн дотоод сүлжээний сервер компьютерт байршуулан хэрэглэгчид ашиглах боломжийг бүрдүүлсэн. Намрын чуулганы завсарлагааны хугацаанд дээрх хуралдааны дүрс бичлэгүүдийг Blu-ray (BD) дискэнд бичин архивт шилжүүлэв.

Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаануудыг Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн 2-р суваг, ТМ телевиз, Сансар, Юнивишн, Скаймедиа кабелийн телевизүүд, Төрийн ордны теле сүлжээ болон www.parliament.mn цахим хуудсаар шууд дамжуулсан.

Мөн Төрийн ордонд чуулганы нэгдсэн хуралдаан, байнгын хороодын хуралдаан, нээлттэй сонсголыг шууд дамжуулах Скаймедиа IPTV-ийн дотоод сувгийн үйлчилгээг өргөтгөн нийт 120 орчим хэрэглэгчтэй болсон.

Хуралдааны дууны систем

Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд 34 удаагийн нэгдсэн хуралдаан, 149 удаагийн Байнгын болон дэд хороодын хуралдаан, 87 удаагийн ажлын хэсэг, мэдээллийн цаг, сургалт семинар, уулзалтын дууны бичлэгийг хийсэн байна. Мөн хуралдааны дууны бичлэгүүдийг компьютерийн дотоод сүлжээний сервер компьютерт байрлуулан хуралдааны тэмдэглэл хөтлөгчид болон эрх бүхий бусад хэрэглэгчид ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Программ хангамжийн үйлчилгээ:

Хууль тогтоох үйл ажиллагааг иргэд, сонгогчдод ил тод, нээлттэй болгох зорилгоор iOS, Android системийн хөдөлгөөнт төхөөрөмж, ухаалаг утсанд зориулсан ParliamentMN, ТМ эмхэтгэл, LawsMN аппликейшн программуудын шинэчлэлийг нэг удаа хийж сайжруулан хууль тогтоох үйл ажиллагааны мэдээ мэдээлэл, хууль эрх зүйн актыг үнэ төлбөргүйгээр цахим хэлбэрээр шуурхай түгээж байна.

Мөн Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулагддаг багш, оюутны эрдэм шинжилгээний бага хурлын “Эврика” аппликейшн, сургалтын ном, гарын авлагыг үнэ төлбөргүй түгээх “ШУТИС контент” аппликейшн, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд бүтээгдсэн портал цахим хуудасны “KhuralMN” аппликейшнуудын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.

Хөдөлгөөнт оффисийн MyParliament системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж хууль тогтоогчдыг хэрэгцээт мэдээ, мэдээллээр шуурхай хангаж байна.


4.4. Судалгаа шинжилгээ, мэдээлэл, лавлагаа

Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурлын Байнгын хороодоос Улсын Их Хурлын гишүүний санаачлан боловсруулж буй хуулийн төсөл болон Улсын Их Хурлаар хэлэлцэн баталж буй хууль, тогтоолын төсөлтэй холбоотой нийт 22 судалгааны захиалга ирүүлснийг гүйцэтгэн захиалагчид хүргүүлэв.

Судалгааны ангилал /төрлөөр/:

Нийт бүтээгдэхүүн: 24

Ном гарын авлага - 2



Судалгааны ангилал /захиалагчаар/:



Эдгээр судалгааны тайлангуудыг Улсын Их Хурлын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудын албан хэрэгцээнд зориулан Улсын Их Хурлын intra.parliament.mn дотоод сүлжээ, хөдөлгөөнт оффисын сүлжээний MY Parliament цэст цахим хэлбэрээр, мөн Улсын Их Хурлын Номын сан, Архивт хэвлэмэл хэлбэрээр байршуулав. Улсын Их Хурлын www.parliament.mn цахим хуудсанд судалгааны ажлын жагсаалт болон судалгааны тойм мэдээллийг тогтмол байршуулж ажиллалаа.

2016 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлуудад хамааралтай судалгааны бусад байгууллага, судлаачдын хийсэн судалгаа, шинжилгээний мэдээ материал, өдөр тутмын хэвлэлийн нийтлэл, статистик тоо баримт зэрэг 190 орчим мэдээллийг цуглуулан судалж, асуудал тус бүрээр ангилж Улсын Их Хурлын гишүүдийн хэрэгцээнд зориулан дотоод сүлжээнд байршуулав.

Тайлант хугацаанд “Судалгааны эмхэтгэл” 23-р боть, “Монгол Улсын Үндсэн хууль 25 жил” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл зэрэг ном, товхимлыг эмхэтгэн гаргав.

4.5. Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы үеэр Улсын Их Хурал, Монголын Парламентын Бүлгэм, Улсын Их Хурлын Тамгын газрын түвшинд дараах гадаад арга хэмжээ, айлчлалуудыг хэрэгжүүлээ.

Дотоодод:

2016.10.01-05

Бүгд Найрамдах Итали Улсын Төлөөлөгчдийн танхимын гишүүн Гуидо Гальперти тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчлав. Айлчлалын үеэр төлөөлөгчид Улсын Их Хурлын дарга М.Энхболдод бараалхаж, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Италийн парламентын бүлгийн дарга А.Ундраа болон бүлгийн гишүүдтэй уулзлаа. Мөн ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэнтэй ажлын уулзалт хийж, МҮХАҮТ-ын үйл ажиллагаатай танилцан албан болон бизнес уулзалтууд хийв.

2016.10.25-29

Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их Хурлын гишүүн, Үндэсний Их Хурал дахь Турк-Монголын парламентын бүлгийн дарга Мехмет Эрдоган тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр төлөөлөгчид Улсын Их Хурлын дарга М.Энхболдод бараалхан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Туркийн парламентын бүлгийн дарга Т.Аюурсайхан болон бүлгийн гишүүдтэй уулзаж, хоёр орны харилцаа, түүний дотор хууль тогтоох байгууллагууд хоорондын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцлоо.



2016.10.30-11.01

БНХАУ-ын БХАТИХ-ын гишүүн, Төвдийн Өөртөө Засах Орны АТИХ-ын төлөөлөгч, Төвдийн Өөртөө Засах Орны дэд дарга Бямбажаш тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчлав. Айлчлалын үеэр төлөөлөгчид Улсын Их Хурлын дарга М.Энхболдод бараалхаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны талаар ярилцлаа.

Гадаадад:

Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд УИХ-ын дарга, дэд дарга, Байнгын хороодын дарга, УИХ дахь парламентын бүлгэмийн дарга, гишүүн зэрэг давхардсан тоогоор 47 гишүүн гадаад орнуудад хэрэгжүүлсэн 32 арга хэмжээнд оролцов.

Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Оросын парламентын бүлгийн дэд дарга Б.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны дарга Д.Сарангэрэл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Д.Гантулга нар 2016 оны 10 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд ОХУ-ын Новосибирск хотноо зохиогдсон “Монгол-Оросын хамтын ажиллагаа 2016” эдийн засгийн чуулга уулзалтад, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ц.Цогзолмаа нар 2016 оны 11 дүгээр сарын 03-07-ны өдрүүдэд Тайландын Вант Улсын нийслэл Бангкок хотноо зохиогдсон Эмэгтэй сайд, парламентын гишүүдийн 11 дүгээр их хуралд, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Г.Мөнхцэцэг, З.Нарантуяа, М.Оюунчимэг, Б.Ундармаа, Ч.Хүрэлбаатар, Ц.Цогзолмаа нар 2016 оны 11 дүгээр сарын 16-26-ны өдрүүдэд Мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан төрийн үйлчилгээний ил тод байдал, үр өгөөжийг дээшлүүлэх “Ухаалаг засаг” төслийн хүрээнд Герман, Финланд, Эстони Улсуудад танилцах айлчлал хийж, төрийн мэдээллийн нээлттэй байдал, Засгийн газрын байгууллагууд хоорондын мэдээллийн солилцоо, албан ёсны статистикт захиргааны мэдээлэл болон уламжлалт бус мэдээллийн эх үүсвэрийн ашиглалт, үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтыг бэхжүүлэх чиглэлээр туршлага судласан байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон Швейцарийн Холбооны Улсын Женев хотноо зохиогдсон Олон Улсын Парламентын Холбооны 135 дугаар Ассамблейн Ерөнхий нарийн бичгийн дарга нарын нийгэмлэгийн хуралд оролцов. Хурлын үеэр Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон БНЧУ-ын парламентын Төлөөлөгчдийн танхимын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Петр Кинштетртэй уулзаж хоёр орны парламентын Тамгын газрууд хоорондын харилцааны талаар товч санал солилцож, ноён Петр Кинштетрийг Монгол Улсад айлчлах урилгатай байгааг дахин нотоллоо.

Улсын Их Хурлын даргын гадаад улсад хийсэн айлчлал



Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд ОХУ-д ажлын айлчлал хийж, Төрийн Думын дарга В.В.Володинтой уулзав. 2016.12.14



ОХУ-ын Холбооны хурлын Холбооны зөвлөлийн дарга, хатагтай В.И.Матвиенкотой хууль тогтоох байгууллага хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх асуудлаар санал солилцлоо. 2016.12.15



Монгол Улсын Их Хурлын дарга Миеэгомбын Энхболд Арабын Нэгдсэн Эмират Улсын Холбооны үндэсний зөвлөлийн (парламент) дарга, доктор Амал Абдулла Аль Кубаиситой хоёр улсын парламент хоорондын хамтын ажиллагааны Санамж бичигт Абу Даби хотноо гарын үсэг зурав. 2016.12.18



Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд Саудын Арабын Вант Улсад ажлын айлчлал хийж, Эль-Рияд хотноо Хунтайж Абдулла бин Абдулрахман бин Абдулазиз Аль-Саудтай уулзаж, хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. 2016.12.20



Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд Кувейт Улсад албан ёсны айлчлал хийж, Кувейтийн Үндэсний Ассамблейн (парламент) дарга, Эрхэмсэг ноён Марзук Али Аль-Ганимтай парламент хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар ярилцлаа. 2016.12.21



Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд албан ёсны айлчлалынхаа үеэр Кувейт улсын Эрхэм дээд Эмир Шейх Сабах Аль-Ахмед Аль-Жабер Аль-Сабахт бараалхлаа. Эрхэм дээд Эмир эдийн засгийн хүндрэлтэй байгаа Монгол Улсад тусламж дэмжлэг үзүүлнэ гэдгээ амлалаа. 2016.12.22

Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаа



Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Суреш Бабу тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. 2016.09.20



Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ивана Гролловаг хүлээн авч уулзлаа. 2016.10.04



Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойд зориулсан архивын баримтын үзэсгэлэнгийн нээлтийн ёслол Төрийн ордон дахь Төрийн түүхийн музейн үзэсгэлэнгийн танхимд боллоо. 2017.01.13



“Монгол Улс дахь Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн нээлтийн ажиллагаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд болов. 2016.10.05



Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон УИХ-ын Тамгын газар үр бүтээлтэй ажиллаж, ажил хөдөлмөрөө үнэлүүлэн Монгол Улсын гавьяат цол хүртсэн Р.Хатанбаатар, Ш.Ринчин нарыг хүлээн авч уулзаж, хүндэтгэл үзүүлэв. 2017.01.12



УИХ-ын гишүүн Г.Занданшатарын санаачилгаар УИХ-ын Тамгын газар, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнтэй хамтарч “Нийтийн сонгол хэрхэн зохион байгуулах вэ” сэдэвт семинар зохион байгуулав. 2016.11.22



УИХ-ын Тамгын газар Швейцарийн Хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн "Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих" төслийнхөнтэй хамтран "Захиргааны ерөнхий хуулийн тухай нарийвчилсан сургалт"-ыг Төрийн оронд зохион байгууллаа. 2016.10.14



МУИС-ийн Хууль зүйн сургуулиас санаачлан Улсын Их Хурлын Тамгын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын Хуульчдын холбоо, Ханнс Зайделийн сантай хамтран "Монгол Улсын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал Иргэний болон худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг" сэдэвт олон улсын симпозиум зохион байгууллаа. 2016.10.21



УИХ-ын Тамгын газар, Үндэсний статистикийн хороотой хамтран "Статистикийн мэдээллийн хэрэглээ, ач холбогдол" сэдвийн дор сургалт зохион байгууллаа. 2016.12.10

ТАВ

ХАВСРАЛТ

Хавсралт -1

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНААР БАТАЛСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ

Хавсралт -2

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНААР БАТАЛСАН ХУУЛЬ, ТОГТООЛЫН
ТАНИЛЦУУЛГА

Хавсралт-1

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР
БАТАЛСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ****2017.02.10****Нэг. Бие даасан хууль**

1. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай /2016.11.10/;
2. Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай /2016.11.10/;
3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай /2016.11.10/;
4. Олон улсын гэрээний тухай /шинэчилсэн найруулга/ /2016.12.01/;
5. Төрийн болон албаны нууцын тухай /2016.12.01/;
6. Төрийн болон албаны нууцын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2016.12.01/;
7. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /2016.12.22/;
8. Монгол Улсын хилийн тухай /шинэчилсэн найруулга/ /2016.12.28/;
9. Монгол Улсын хилийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2016.12.28/;
10. Арбитрын тухай /шинэчилсэн найруулга/ /2017.01.26/;
11. Ахмад настны тухай /шинэчилсэн найруулга/ /2017.01.26/;
12. Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай /шинэчилсэн найруулга/ /2017.02.02/;
13. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай /2017.02.02/;
14. Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ /2017.02.02/;
15. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2017.02.02/;
16. Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ /2017.02.09/
17. Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2017.02.09/;
18. Зөвлөлдөх санал асуулгын тухай /2017.02.09/
19. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2017.02.09/;
20. Дотоодын цэргийн тухай /2017.02.09/;
21. Дотоодын цэргийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2017.02.09/;
22. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай /шинэчилсэн найруулга/ /2017.02.10/.

Хоёр. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.11.18/;
2. Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.11.18/;
3. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.11.10/;
4. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.11.10/;
5. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.11.10/;
6. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.11.10/;
7. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.11.10/;
8. Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.11.10/;
9. Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.11.03/;
10. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.11.10/;
11. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.11.03/;
12. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.11.03/;
13. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.11.03/;
14. Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.11.10/;
15. Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.11.10/;
16. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.11.10/;
17. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.11.10/;
18. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.11.10/;
19. Шүүхийн захиргааны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.11.10/;
20. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.11.10/;
21. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.11.10/;
22. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.11.10/;
23. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.11.10/;
24. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.11.10/;

25. Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.11.10/;
26. Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.11.10/;
27. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.12.09/;
28. Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.12.09/;
29. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.15/;
30. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
31. Архивын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
32. Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
33. Байгууллагын нууцын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.12.01/;
34. Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
35. Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
36. Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
37. Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
38. Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
39. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
40. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
41. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
42. Патентийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
43. Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
44. Терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
45. Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
46. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
47. Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
48. Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
49. Цахим гарын үсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
50. Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.01/;
51. Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.12.22/;
52. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.12.22/;

53. Дээд боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.12.22/;
54. Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.12.22/;
55. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.12.22/;
56. Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай /2016.12.22/;
57. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.12.22/;
58. Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.12.22/;
59. Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.12.22/;
60. Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.22/;
61. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2016.12.28/;
62. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.28/;
63. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд нэмэлт оруулах тухай /2016.12.28/;
64. Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.28/;
65. Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.28/;
66. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.28/;
67. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.28/;
68. Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2016.12.28/;
69. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай /2016.12.28/;
70. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.01.12/;
71. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.01.19/;
72. Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.01.19/;
73. Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.01.26/;
74. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.01.26/;
75. Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.01.26/;
76. Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.01.26/;
77. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.01.26/;
78. Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.01.26/;

79. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.01.26/;
80. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.01.26/;
81. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.01.26/;
82. Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.01.26/;
83. Векселийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.01.26/;
84. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.01.26/;
85. Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай /2017.01.26/;
86. Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.01.26/;
87. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.01.26/;
88. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.01.26/;
89. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.01.26/;
90. Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.01.26/;
91. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.01.26/;
92. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.01.26/;
93. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.01.26/;
94. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
95. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
96. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.02/;
97. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.02/;
98. Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
99. Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
100. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
101. Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
102. Архивын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
103. Бага, дунд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
104. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;

105. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
106. Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
107. Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
108. Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
109. Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
110. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
111. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
112. Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
113. Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
114. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
115. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
116. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
117. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
118. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
119. Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
120. Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
121. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
122. Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
123. Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
124. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
125. /2017.02.02/;
126. Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
127. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
128. Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
129. Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
130. Ус цаг уур, орчны хяналтын шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;

131. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
132. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
133. Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
134. Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
135. Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
136. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
137. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
138. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
139. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
140. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
141. Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.02/;
142. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
143. Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;
144. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
145. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
146. Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
147. Усны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
148. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
149. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
150. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;
151. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
152. Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
153. Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;
154. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;
155. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;

156. Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;
157. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
158. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
159. Терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
160. Галт зэвсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
161. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
162. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;
163. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;
164. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;
165. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
166. Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;
167. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;
168. Төрийн нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
169. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;
170. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;
171. Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
172. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2017.02.09/;
173. Галт зэвсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
174. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.09/;
175. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.10/;
176. Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2017.02.10/.

Гурав. Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль

1. Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай /Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Экспортыг дэмжих төсөл”-ийн Санхүүжилтийн хэлэлцээр/, /2016.11.04/;
2. Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр соёрхон батлах тухай /Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр/, /2016.11.04/;
3. Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколд нэгдэн орох тухай /2016.11.24/.

Дөрөв.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль

1. Сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай /2016.10.07/;
2. Дээд боловсролын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай /2016.12.09/;
3. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай /2016.12.01/;
4. Төрийн нууцын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай /2016.12.01/;
5. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай /2016.12.01/;
6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай /2016.12.22/;
7. Монгол Улсын хилийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай /2016.12.28/;
8. Хилийн боомтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай /2016.12.28/;
9. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай /2017.01.26/;
10. Арбитрын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай /2017.01.26/;
11. Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай /2017.02.02/;
12. Гамшгаас хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай /2017.02.02/;
13. Цагдаагийн албаны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай /2017.02.09/;
14. Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай /2017.02.09/;
15. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай /2017.02.10/.

Тав. Улсын Их Хурлын тогтоол

1. Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 09 дүгээр дүгнэлтийн тухай /2016.10.06, дугаар 49/;
2. Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 10 дугаар дүгнэлтийн тухай /2016.10.06, дугаар 50/;
3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай /2016.11.03, дугаар 51/;
4. Хуулийн төсөл буцаах тухай /Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл/, /2016.11.03, дугаар 52/;
5. Хог хаягдлын тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг буцаах тухай /2016.11.17, дугаар 53/;
6. Хууль, тогтоолын төслүүдийг буцаах тухай /Монгол Улс байнга төвийг сахих тухай хуулийн төсөл болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай, “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай, “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд/, /2016.11.17, дугаар 54/;
7. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай /2016.11.17, дугаар 55/;
8. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай /2016.11.17, дугаар 56/;
9. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр томилох тухай /2016.11.17, дугаар 57/;
10. Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай /2016.11.17, дугаар 58/;
11. Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилох тухай /2016.11.17, дугаар 59/;
12. Монгол Улсын иргэний харьяаллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон холбогдох бусад хуулийн төсөл буцаах тухай /2016.11.17, дугаар 60/;
13. Санхүүгийн зохицуулах хорооны зарим гишүүнийг томилох тухай /2016.11.18, дугаар 61/;
14. Санхүүгийн зохицуулах хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай /2016.11.18, дугаар 62/;
15. Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох талаар авах зарим арга хэмжээний тухай /2016.11.10, дугаар 63/;

16. “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай /2016.11.10, дугаар 64/;
17. Прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай /2016.11.10, дугаар 65/;
18. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай /2016.11.10, дугаар 66/;
19. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай /2016.11.10, дугаар 67/;
20. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2016.11.17, дугаар 68/;
21. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2016.11.17, дугаар 69/;
22. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” батлах тухай /2016.11.24, дугаар 70/;
23. “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” батлах тухай /2016.11.24, дугаар 71/;
24. Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнийг томилох тухай /2016.12.01, дугаар 72/;
25. Санхүүгийн зохицуулах хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай /2016.12.01, дугаар 73/;
26. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох тухай /2016.12.01, дугаар 74/;
27. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай /2016.12.01, дугаар 75/;
28. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай /2016.12.08, дугаар 76/;
29. Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 12 дугаар дүгнэлтийн тухай /2016.12.09, дугаар 77/;
30. Монгол Улсын Их Хурлын 2012 оны 50 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай /2016.12.09, дугаар 78/;
31. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай /2016.12.15, дугаар 79/;
32. Хуулийн төсөл буцаах тухай /2016.12.23, дугаар 80/;
33. Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай /2016.12.28, дугаар 81/;
34. Хуулийн төсөл буцаах тухай /2016.12.28, дугаар 82/;
35. Төрийн болон албаны нууцын тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2016.12.01, дугаар 83/;

36. Хуулийн төсөл буцаах тухай /Зэвсэгт хүчний тухай хууль/, /2016.12.01, дугаар 84/;
37. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай /2017.01.05, дугаар 01/;
38. Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг чөлөөлөх тухай /2017.01.12, дугаар 02/;
39. Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилох тухай /2017.01.12, дугаар 03/;
40. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай /2017.01.12, дугаар 04/;
41. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох тухай /2017.01.12, дугаар 05/;
42. Монгол Улсын Ерөнхий аудиторыг чөлөөлөх тухай /2017.01.12, дугаар 06/;
43. Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай /2017.01.12, дугаар 07/;
44. Хуулийн төсөл буцаах тухай /Олон Улсын гэрээний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл/, /2017.01.12, дугаар 08/;
45. Хуулийн төсөл буцаах тухай /Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөл/, /2017.01.12, дугаар 09/;
46. Хуулийн төсөл буцаах тухай /Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд/, /2017.01.20, дугаар 10/;
47. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай /2017.01.12, дугаар 11/;
48. Нийтийн сонсгол зохион байгуулах журам батлах тухай /2017.01.12, дугаар 12/;
49. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн санал авах өдрийг тогтоох, сонгуулийг товлон зарлах тухай /2017.01.26, дугаар 13/;
50. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай /2017.01.26, дугаар 14/;
51. Хуулийн төсөл буцаах тухай /Иргэний улс төрийн эрхийг хэрэгжүүлэх тухай хуулийн төсөл/, /2017.01.26, дугаар 15/;
52. Хуулийн төсөл буцаах тухай /Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай/, /2017.01.26, дугаар 16/;

53. Нууц /2017.02.02, дугаар 17/;
54. Монгол Улсын Их Хурлын 1999 оны 64 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай /2017.02.02, дугаар 18/;
55. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай /2017.02.03, дугаар 19/;
56. Хэнтий Хаан уулын нэрийг өөрчлөх тухай /2017.02.09, дугаар 20/;
57. Монгол Улсын Их Хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай /2017.02.09, дугаар 21/;
58. “Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай /2017.02.09, дугаар 22/;
59. “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай /2017.02.10, дугаар 23/.

Хавсралт 2

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР
БАТАЛСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

А) Төрийн байгуулалтын болон хууль зүйн чиглэлээр:

**МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТАНИЛЦУУЛГА**

БАТАЛСАН ОГНОО 2016.12.28	<b style="color: #e67e22;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ Засгийн газраас 2016. 11.17-ны өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2017.02.01
---	--	---

Энэхүү хууль нь 8 бүлэг, 58 зүйлтэй.

ХУУЛИЙН ЗОРИЛГО


Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, улсын хил хамгаалах байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, улсын хил хамгаалалтад иргэн, байгууллагын оролцоог тодорхойлж, хилийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байна.

Шинэчлэн баталсан хуульд Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хилийн халдашгүй дархан байдлыг баталгаажуулж, улсын хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийн биелэлтийг хангах, үйл ажиллагааг боловсронгуй болгох, хилчний нийгэм, эрх зүйн баталгааг тодорхой болгосон зэрэг дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг нарийвчлан тусгасан.

ХУУЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Хууль батлагдсанаар улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, Монгол Улсын хил болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалтын үйл ажиллагаа, хил дээр гарсан аливаа асуудлыг хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах зэрэг асуудлын эрх зүйн зохицуулалт боловсронгуй болсноос гадна хилчний цалин хөлс, шагнал урамшуулал зэрэг нийгмийн баталгааг сайжруулж, галт зэвсэг хэрэглэх эрх зүйн нарийвчилсан зохицуулалтуудыг тодорхой болгож, хил хамгаалалтад туслах хүч, иргэн, эрх зүйн баталгаагаар хангагдаж байгаагаараа ач холбогдолтой юм.

ХУУЛИЙН ЗАРЧМЫН ШИНЖТЭЙ ЗОХИЦУУЛАЛТ



АРБИТРЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2017.01.26	ХУУЛЬ САНААЧЛАГЧ Засгийн газраас 2016.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАН МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
---	---	--

Хуулийн зорилт:

Эрх зүйн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг олон улсын стандартад нийцүүлэн зохицуулахад оршино



Шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ /түр арга хэмжээ/



Арбитрын тухай хуулийг өөрийн орны онцлог болон бусад улсын туршлагыг судлан Нэгдсэн Үндэстний Байгууллагын загвар хуульд нийцүүлэх зорилгоор дараах шинэ зохицуулалтыг тусгасан. Үүнд:

1. Маргаан шийдвэрлэх үр дүнтэй бөгөөд найдвартай механизмаар хангах, дотоод, гадаадын арбитрын шийдвэрийг Монгол Улсад хүлээн зөвшөөрөх, биелүүлэх явдлыг хангаснаар Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь гадаадын хөрөнгө оруулагчдад ээлтэй хууль зүйн орчин бий болгоход чухал хувь нэмэр оруулна.

2. 2003 оны хуульд тусгасан арбитрын хуралдаан болох газар гэсэн томъёоллыг арбитрын ажиллагааны харьяалал гэж өөрчилсөн. Учир нь арбитрын ажиллагаанд үйлчлэх эрх зүйн хүрээг тодорхойлдог гэсэн агуулга илэрхийлж байгаа юм. Тухайлбал, арбитрын ажиллагааны харьяалал нь Монгол Улс байна гэж талууд тохиролцсон ч хуралдаан, уулзалт хийх, гэрч асуух, шинжээч томилох, үзлэг хийх зэрэг тодорхой ажиллагааг Монгол Улсаас өөр улсад явуулж болно. Харин арбитрын үндсэн шийдвэр гаргах газар нь Монгол Улс байх бөгөөд уг шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх, гүйцэтгэхээс татгалзах зэрэг асуудлыг Монгол Улсын эрх бүхий шүүх хэлэлцэж шийдвэрлэх юм.
3. “Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ, урьдчилсан тогтоол” гэсэн шинэ зохицуулалтыг хуульд тусгасан. Арбитрын шийдвэр бодит байдал дээр хэрэгждэг байх нөхцөлийг хангах үүднээс цаг хугацааны хувьд эцсийн шийдвэр гарахаас өмнө цаг хожиж хамгаалалтын шинжтэй арга хэмжээ авах бүрэн эрхийг арбитрын бүрэлдэхүүн эдэлдэг байх боломжийг хангахад түр арга хэмжээний ач холбогдол оршино.
4. Зардал хохирол гаргуулахтай холбоотойгоор түр арга хэмжээ авах, урьдчилсан тогтоол гаргуулах тухай хүсэлт гаргасан тал хариуцлага хүлээх нөхцөлийг тодорхойлсон зохицуулалт шинээр тусгалаа. Тухайн нөхцөл байдалд урьдчилсан тогтоол гаргах шаардлагагүй байсныг арбитрын бүрэлдэхүүн хожим тогтоосон бол уг арга хэмжээ авах бололцоотой.
5. Арбитрын хэлэлцээрийг бичгээр байгуулах хэлбэрийн шаардлагыг илүү дэлгэрэнгүй зохицуулж тусгалаа.



ЗӨВЛӨЛДӨХ САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН
ОГНОО

2017.02.09

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

УИХ-ын гишүүн Г.Занданшатар 2016.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн

ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА

Ердийн
журмаар



Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.3.3-т заасан асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх үндэслэл, шаардлагыг тодорхойлох



Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ



Хот, суурин газрын хэсэгчилсэн төлөвлөлт /нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж/

Дараах шийдвэрийг гаргахад зөвлөлдөх санал асуулга явуулна: Баримтлах зарчим

Зөвлөлдөх санал асуулга явуулахдаа хууль дээдлэх, иргэдийн бодитой, шууд оролцоог хангах, иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах, олон талт мэдээллээр тэгш хангах, ил тод, нээлттэй, хараат бус байх, харилцан зөвлөлдөх, үр нөлөөтэй байх зэрэг зарчим баримтлана.


Зөвлөлдөх зөвлөл

- Зөвлөлдөх санал асуулгыг олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх бүрэлдэхүүн бүхий Зөвлөлдөх зөвлөл удирдан зохион байгуулна.
- Уг зөвлөлийг зөвлөлдөх санал асуулга явуулах тухайн асуудлаар мэргэшсэн, хараат бус, өндөр мэдлэг, туршлага бүхий хорин нэгэн насанд хүрсэн, Монгол Улсын иргэн, эрдэмтэн, судлаач, хувийн хэвшлийн болон тухайн чиглэлийн төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 5-11 хүний бүрэлдэхүүнтэйгээр шийдвэр гаргах эрх бүхий этгээд байгуулна.
- Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагч, улс төрийн намын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг томилохгүй байх хязгаарлалтыг тусгасан.
- Зөвлөлдөх зөвлөл нь зөвлөлдөх санал асуулгын асуултыг боловсруулах, хамрах хүрээ, тухайн зөвлөлдөх санал асуулгын үе

шат бүрийн санал авах өдрийг тогтоох, зөвлөлдөх санал асуулгын дүнг хэлэлцэж, зөвлөмж гаргах, тухайн зөвлөлдөх санал асуулгын явц, үр дүнгийн талаархи мэдээллийг олон нийтэд хүргэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- Зөвлөлдөх санал асуулгын асуулт нь нэг сэдвээр, хоёрдмол утгагүй, товч, тодорхой, ойлгомжтой томъёологдсон байх бөгөөд тухайн асуултад гадаад үг хэрэглэхгүй.

САНАЛ АВАХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГА



ЗӨВЛӨЛДӨХ САНАЛ АСУУЛГА

Нэг дэх шат

Зөвлөлдөх санал асуулгын нэг дэх шатанд иргэдэд зөвлөлдөх санал асуулгын сэдвээр урьдчилсан мэдлэг, мэдээлэл өгөхгүйгээр санал асуулгын хуудсаар саналыг нь авна.

Монгол Улсын арван найман насанд хүрсэн иргэн оролцох эрхтэй бөгөөд хамгийн сүүлийн удаа явагдсан Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулиар гаргасан сонгогчдын нэрийн жагсаалтаас тохиолдлын зарчмаар сонгож авна.

Сонгогдсон иргэн тухайн санал асуулгад оролцохоос татгалзах эрхтэй.

Хоёр дахь шат

Зөвлөлдөх санал асуулгын хоёр дахь шатанд нэг дэх шатанд оролцсон иргэдийн 50-аас доошгүй хувийг тохиолдлын зарчмаар сонгон авна.

Зөвлөлдөх санал асуулгын хоёр дахь шатанд шийдвэр гаргах эрх бүхий этгээд санал авах ажлыг зөвлөлдөх үүлзалт хэлбэрээр зохион байгуулах бөгөөд зөвлөлдөх үүлзалтыг зохион байгуулах журмыг тогтооно.

Зөвлөлдөх санал асуулгын хамрах хүрээ, сэдвээс хамааран нэг дэх шатныг алгасан хоёр дахь шатыг зохион байгуулж болно.

Зөвлөлдөх санал асуулгаар санал авах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр төсөлд тусгасан байсныг статистикийн байгууллага зохион байгуулж явуулахаар өөрчлөн хуульчилсан.

Зөвлөлдөх санал асуулгын санхүүжилтийг төсөлд улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт, хувь хүн, хуулийн этгээдийн хандиваас бүрдэхээр тусгасан байсныг нөлөөллөөс ангид, хараат бус санал асуулга явуулах үүднээс зөвхөн улсын төсөв болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгалаа.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хамтад нь баталсан болно.

САНАЛ АСУУЛГЫН САНХҮҮЖИЛТ



~~Олон улсын
байгууллагын дэмжлэг~~



~~Хувь хүн, хуулийн
этгээдийн хандив~~

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН
ОГНОО

2016.12.22

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

Засгийн газраас 2016.09.09-ний өдөр өргөн мэдүүлсэн

ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА

2017.02.01

ХУУЛИЙН ЗОРИЛТ:

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ
ИЛРҮҮЛЭХ,
ТАСЛАН ЗОГСООХ,
ХОХИРОГЧ, ТҮҮНИЙ ГЭР БҮЛИЙН
БУСАД ГИШҮҮНИЙ АМЬ НАС,
ЭРҮҮЛ МЭНД,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ,
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ,
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЭРХ ЗҮЙН ҮНДСИЙГ ТОГТООХООР
ТОДОРХОЙЛСОН.

6 БҮЛЭГ, 47 ЗҮЙЛТЭЙ



Хуулийн үйлчлэлд хамаарах хүний хүрээг өргөтгөж гэр бүлийн гишүүдээс гадна тусдаа амьдарч байгаа төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, хүүхэд, мөн тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа хүн, өмнө нь хамт амьдарч байсан, эсхүл хамтран амьдраагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй хүмүүсийг нэмж хамруулсан.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭЛБЭР



Бие махбодийн
хүчирхийлэл



Сэтгэл санааны
хүчирхийлэл



Эдийн засгийн
хүчирхийлэл



Бэлгийн
хүчирхийлэл

2017 ОНЫ 02 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДРӨӨС
ЭХЛЭН ДАГАЖ МӨРДӨНӨ



Сум, багийн
Засаг дарга



Эмч



Багш



Төрийн болон ТББ-ын
ажилтан



Нийгмийн ажилтан

Цагдаагийн мэргэшсэн албан хаагчдаас
бүрдсэн нэгж хүчирхийлэл үйлдэгч,
хохирогчийн талаархи мэдээллийн нэгдсэн
сан бүрдүүлэх, **24 цагийн утас**
ажиллуулах шинэ зохицуулалтыг тусгасан



Хохирогчид аюулгүй байдлын хамгаалалт,
эмнэлгийн тусламж, үйлчилгээ,
сэтгэл зүйн, нийгмийн халамжийн,
хүүхэд хамгааллын үйлчилгээ,
эрх зүйн туслалцаа, холбон зуучлах **үйлчилгээг**
холбогдох байгууллага **үзүүлнэ.**

Гэр бүлийн **хүчирхийллийн**
талаар мэдсэн бол цагдаагийн
байгууллагад **мэдээлэхээр** хуульд
тусгаж, үүнтэй холбоотойгоор уг
үүргээ биелүүлээгүй тохиолдолд
хуулийн хариуцлага хүлээнэ.

Нэг цэгийн үйлчилгээний төв нь
24 цагийн турш хохирогчид
харьяалал харгалзахгүйгээр
цогц үйлчилгээг үзүүлнэ

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ
ИЛРҮҮЛЭХ, МЭДЭЭЛЭХ, ХҮҮХДИЙГ
ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС
ХАМГААЛАХААР ТУСГАЙЛАН
ЗААСАН.

ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАЖ БАЙГАА
ХҮН БҮР ХҮҮХДИЙН БИЕ МАХБОДЬ,
СЭТГЭЛ САНАА, ЗАН ҮЙЛД ГАРЧ БАЙГАА
СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ нь ХҮЧИРХИЙЛЛЭЭС
ҮҮДЭЛТЭЙ ЭСЭХИЙГ **ШАЛГАХ ҮҮРЭГТЭЙ**



ХҮҮХЭД ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД
ӨРТСӨН, ӨРТСӨН БАЙЖ БОЛЗОШГҮЙ ГЭЖ
ҮЗВЭЛ **ИРГЭН БҮР** ЦАГДААГИЙН
БАЙГУУЛЛАГАД **МЭДЭЭЛЭХ**
ҮҮРЭГТЭЙ.

МЭДЭЭЛЭХ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ
ТОХИОЛДОЛД **ХУУЛИЙН ХАРИУЦЛАГА**
ХҮЛЭЭЛГЭН, ТОРГОХ ШИЙТГЭЛ
ОНОГДУУЛНА



ХАМТАРСАН БАГ-ХАМТЫН ХАРИУЦЛАГА



ЗӨРЧИЛ БА ГЭМТ ХЭРГИЙГ ЗААГЛАСАН.



ЗӨРЧИЛ



Зодох;



Хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадах;



Мөрдөн мөшгих;



Заналхийлэх;



Бусадтай харилцахыг хязгаарлах;



Гутаан доромжлох;



Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах;



ГЭМТ ХЭРЭГ



Байнга зодох;



Харгис хэрцгийг харилцах;



Догшин авирлах;



Тарчлаах;



Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах;

Хүний амь нас, аюулгүй байдлаар холбоотой асуудлыг иргэний хэрэгт тооцдог байсныг халсан.

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2017.02.09	<h3 style="color: #e91e63;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ</h3> <p>Засгийн газраас 2016.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн</p>	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
---	---	--

Уг хууль 10 бүлэг, 97 зүйлтэй.

Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн албаны үндсэн чиг үүргийг гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахаар тусгаж, цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааг хуулиар журамлаж өгсөн.

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЧИГ ҮҮРЭГ

- Цагдаагийн алба хаагч бичиг баримт шалгах, тээврийн хэрэгслийг зогсоох зэрэг нийтлэг хэрэгжүүлэх;
- Хүний эрх, эрх чөлөөнд хамгийн бага хэлбэрээр халддаг арга хэмжээг тодорхой үндэслэл байгаа тохиолдолд хэрэгжүүлэх;
- Хүний бие, эд зүйл, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, эд зүйл хураан авах, баривчлах, түр саатуулах;
- Хүний эрх, эрх чөлөөнд илүү халдсан үйл ажиллагааг зөвхөн тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх.

Цагдаагийн төв байгууллагын даргыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар, дэд даргыг дотоод хэргийн сайд, орон нутгийн цагдаагийн байгууллагын даргыг Засаг даргатай зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга тус тус томилж, чөлөөлж байхаар тусгаж, цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас бүрдэхээр тусгасан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг дээшлүүлэх, үйл ажиллагаагаа иргэдийн хэрэгцээ, шаардлагатай уялдуулах, олон нийтийн итгэлийг хүлээх шаардлагын үүднээс цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ иргэнд хүндэтгэлтэй хандаж, иргэд олон нийтийн дэмжлэгийг авах, итгэлийг хүлээхийг эрмэлзэх үүргийг хуульчилсан.

Цагдаагийн алба хаагчид цагдаагийн дээд, дунд, бага цол олгохоор тусгаж цагдаагийн алба хаагчийн тэтгэвэр тогтоолгох насыг цолны байдлаас хамааруулан 47, 52, 55, 57 нас байхаар, бага цолтойгоос бусад эмэгтэй алба хаагчийн хувьд 47 нас байхаар тус тус заасан.

Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар Тахарын албыг татан буулгасантай холбогдуулан уг байгууллагын хэрэгжүүлж байсан зарим чиг үүргийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн бөгөөд Тахарын албанд ажиллаж байсан алба хаагчдын цол, ажилласан жилийг цагдаагийн албанд ажиллаж байсан хугацаанд тооцохоор, мөн 2013 онд батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу комиссар цолтой алба хаагчид цагдаагийн хурандаа цол олгох асуудлыг тус тус зохицуулсан.



Албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа улс төрийн зорилгоор ашиглах, бусад ажилтан, алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулахыг хориглосон.

Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааны үед хүний эрхийг хамгаалах зохицуулалтыг бий болгож, зөвхөн тунхаглалын шинжтэй бус, хэм хэмжээ тогтоож үүрэг болгосон бөгөөд түүнийг зөрчсөн бол цагдаагийн алба хаагчид хариуцлага тооцдог


ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2017.02.09	<h3 style="color: #e91e63;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ</h3> <p>Засгийн газраас 2016.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн</p>	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2017.09.01
--	---	--

Дотоодын цэргийн тухай хууль 5 бүлэг 40 зүйлтэй бөгөөд хуулийн зорилт Монгол Улсын дотоодын цэргийн тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдсэн болно.

Дотоодын цэргийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

Тус хуулийн хоёрдугаар бүлэгт дотоодын цэргийн бүтэц зохион байгуулалт, удирдлагын эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн байна.



ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУХАЙ ХУУЛЬ

2017 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 01-НИЙ ӨДРӨӨС ДАГАЖ МӨРДӨНӨ

ЭНЭ ХУУЛИЙН ЗОРИЛТ НЬ МОНГОЛ УЛСЫН ДОТООДЫН ЦЭРГИЙН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРЭГ, БҮРЭН ЭРХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ҮНДСИЙГ ТОДОРХОЙЛОХТОЙ ХОЛБОГДСОН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХАД ОРШИНО

ДОТООДЫН ЦЭРГИЙН ЧИГ ҮҮРЭГ:

- Улсын онц чухал объектыг хамгаалах
- Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсоход дэмжлэг үзүүлэх
- Гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
- Шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх
- Террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох
- Хуулиар тогтоосон бусад чиг үүрэг

ДОТООДЫН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭХДЭЭ ДАРААХ ЭРХ ЭДЭЛНЭ

- Узлэг хийх
- Шаардлага тавих
- Мөрдөн хөөх
- Санал тавих
- Тээврийн хэрэгсэлд үзлэг хийх
- Гэмт хэргийн ул мөрийг хураан авах, шилжүүлэх
- Бичиг баримт шалгах
- Хуульд заасан бусад

ДОТООДЫН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАТАЛГАА

Дотоодын цэргийн алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу **тэтгэвэр** тогтоолгож, тэтгэмж авна.

Дотоодын цэргийн алба хаагчдын ажилласан хугацааг тооцоход улсын онц чухал объектын харуул хамгаалалтад ажилласан **1 жилийг 1 жил 3 сараар** тооцно.

Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж буй дотоодын цэргийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг **иргэн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.**

Дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объектын захиргаа дотоодын цэргийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэх **нөхцлөөр хангах** үүрэгтэй.

Дотоодын цэргийн алба хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ


Дотоодын цэрэг, түүний үйл ажиллагааг удирдах Засгийн газрын бүрэн эрх, Дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх, Дотоодын цэргийн бүтэц, удирдлага зэрэг харилцааг тус бүлэгт хамааруулж дотоодын цэргийн командлагч, штабын даргын хэрэгжүүлэх бүрэн эрх, дотоодын цэргийн туг, бэлгэ тэмдэг зэргийг хуульчилж өгсөн. Дотоодын цэргийн удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлсон. Дотоодын цэрэг нь дотоодын цэргийн штаб, анги, салбараас бүрдэх бөгөөд Цагдаагийн төв байгууллагын дарга нь дотоодын цэргийн командлагч байхаар зааж, дотоодын цэргийн анги, салбарыг эрх бүхий дээд шатны байгууллагаас томилсон захирагч удирдана гэж удирдлага зохион байгуулалтыг нь тогтоож өгсөн.

Дотоодын цэргийн алба хаагч хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэх үндэслэлийг тодорхойлж өглөө. Дотоодын цэргийн байгууллага, алба хаагч үүрэг гүйцэтгэхдээ нэг бүрийн, олон хүнд нөлөөлөх, бусад тусгай хэрэгслийг хэрэглэж болохоос гадна дотоодын цэргийн үйл ажиллагаанд нисдэг тэрэг, тусгай зориулалтын хуягт тээвэрлэгч, хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл, газар уснаа явагч, тусгай хэрэгслээр тоноглогдсон бусад тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгсэл албадан зогсоогч, галт хэрэглэл, гэрэл, дууны хэрэгсэл, тусгай будагч, тэмдэглэгч хэрэгсэл болон бусад тусгай хэрэгсэл, албаны нохой ашиглаж болохоор заасан.

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААРХИ ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2017.02.09	<b style="color: #e67e22;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ УИХ-ын гишүүн О.Баасанхүү 2016.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
---	---	--

Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгээс 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.



ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн заалт Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 12 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурал 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч Улсын Их Хурлын 77 дугаар тогтоолыг баталсан.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.5, 32.3.7 дахь заалтад заасны дагуу Хууль зүйн байнгын хороо Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд оруулж, батлуулсан.

ХУУЛЬД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ:

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар нэг удаа томилно гэсэн заалтын “нэг удаа” гэснийг хасаж, хуульд ийм өөрчлөлт оруулснаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг улируулан томилж болохоор болж байна.



ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН
ОГНОО
2017.01.19

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

Засгийн газраас 2016.12.16-ны өдөр өргөн мэдүүлсэн

ДАГАН МӨРДӨХ
ХУГАЦАА
Ердийн
журмаар

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зорчсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дараах эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулна

ЦАГДААГИЙН
БАЙГУУЛЛАГЫН
ЭРХ БҮХИЙ
АЖИЛТАН



ШҮҮГЧ



Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй буюу уг эрхээ хасуулсан этгээд согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон бол

~~ТОРГОВУЛ~~

7-30 ХОНОГ ХҮРТЭЛ
ХУГАЦААГААР
БАРИВЧЛАХ
ШИЙТГЭЛ
ОНОГДУУЛНА.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН “НИЙТИЙН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН
ОГНОО

2017.01.12

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

УИХ-ын гишүүд 2016.10.27-ний өдөр
өргөн мэдүүлсэнДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦААЕрдийн
журмаар

“Нийтийн сонсголын зохион байгуулах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг дагаж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Улсын Их Хурал, Байнгын болон дэд, түр хороодод хууль тогтоомжийн, томилгооны, ерөнхий болон төсвийн хяналтын сонсголыг хэрхэн зохион байгуулах, сонсголын хуралдааны журам, дэгийг зохицуулсан бүлэг шинээр нэмэхтэй холбоотой өөрчлөлт оруулсан.

51¹ дүгээр зүйл.Нийтийн сонсгол

51⁴ дүгээр зүйл.Нийтийн сонсгол даргалагчийг томилох

51² дугаар зүйл.Нийтийн сонсголын бэлтгэл хангах

51⁵ дугаар зүйл.Нийтийн сонсгол явуулах зохион байгуулах журам

51³ дугаар зүйл.Нийтийн сонсголд ажиглагчийг оролцуулах

51⁶ дугаар зүйл.Нийтийн сонсголыг хаалттай явуулах

ИРГЭД

Иргэн, хуулийн этгээдээс хууль тогтоомжийн төслийн, ерөнхий хяналтын болон төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлт гаргаж болно.

Мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг заавал оролцуулна.

Сонсголын тэмдэглэлийг тухайн байгууллагын цахим хуудсанд байршуулна.

Сонсгол даргалагч сонсголын сэдэв, хүсэлт, сонсгол зарласан огноо, сонсголд дуудагдсан албан тушаалтан, холбогдох этгээд, шинжээч, тайлбар хийх хүний нэр, сонсголд оролцогчдын тоо, сонсголын дэг зэргийг 10 минутад багтаан танилцуулна.

Сонсгол зохион байгуулах хүсэлт гаргасан этгээд, эсхүл тэдгээрийн төлөөлөгч хүсэлтийнхээ үндэслэл, шаардлагын талаар 10 минутад багтаан танилцуулна.

Сонсголд оролцогчийн үг хэлэх хугацааг 3-10 минутаар тогтооно.

-Хөгжлийн бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст үг хэлэх хугацааг шаардлагатай хэмжээгээр сунгаж олгоно.

Санал, тайлбар, дүгнэлттэй холбогдуулан оролцогчоос асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байна.

Асуулт, хариулт дууссаны дараа сонсголд оролцогчид болон хүсэлт гаргасан төлөөлөл санал, дүгнэлтээ оролцогчдын тооноос хамааран 1-3 минутын хугацаанд хэлнэ.

АЧ ХОЛБОГДОЛ

Эдгээр хууль, тогтоолын төслүүд батлагдсанаар Нийтийн сонсголын тухай хууль хэрэгжих нөхцөл бүрдэж, хууль хоорондын уялдаа холбоо хангагдаж нийтийн сонсгол зохион байгуулах үүрэг бүхий этгээдүүд сонсгол зохион байгуулах нэгдсэн журам, дэгтэй болж, нийтийн сонсголын ач холбогдол, үр нөлөө хангагдана.

“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН
ОГНОО

2016.11.03

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

Ерөнхийлөгчөөс 2015.11.18-ны өдөр
өргөн мэдүүлсэн

ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА

Ердийн
журмаар

Монгол Улсын
Ерөнхийлөгчөөс 2015 оны
арваннэгдүгээр сарын 19-ний
өдөр өргөн мэдүүлсэн.

Улсын Их Хурал 2016 оны
арваннэгдүгээр сарын 3-ны
өдөр 51 тоот тогтоолоороо
баталсан.

Хөтөлбөрийг зургаан
жилийн хугацаанд
хэрэгжүүлнэ.

ЗОРИЛГО: Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх.

ЗОРИЛТ:

- Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх,
- Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх,
- Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх,
- Худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх,
- Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах,
- Хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх,
- Иргэний нийгмийн байгууллагын идэвх санаачилга, оролцоог дэмжих,
- Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх,
- Улс төрийн хүрээнд шударга ёсыг бэхжүүлэх,
- Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх,
- Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх.

ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖСЭНЭЭР ХҮРЭХ ҮР ДҮН:

- Авлигатай тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нийтийн албанд цогц шинэтгэл хийх үйл ажиллагаа эрчимжсэн байх;
- Төрийн байгууллагын авлигын эрсдэлийг үнэлэх ажиллагаа хэвшсэн байх;
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ ахисан байх;
- Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн байх;
- Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын авлигын эсрэг хамтын ажиллагаа сайжирсан байх;
- Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлж эхэлсэн байх;
- Хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагаа сайжирсан байх;
- Шударга ёсны үзэл санаа нийгэмд төлөвшиж, иргэн өөрт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлдэг байх нийгмийн сэтгэлгээ, хандлага өөрчлөгдсөн байх
- Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлага дээшилсэн байх;
- “Транспарэнси Интернэшнл” байгууллагын судалгаагаар Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт сайжирсан байх;
- Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ сайжирсан байх;
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын төсөөлөлд эерэг өөрчлөлт гарсан байх.
- “Транспарэнси Интернэшнл” байгууллагын судалгаагаар Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт өмнөх үзүүлэлтээс сайжирсан байх;
- Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ өмнөх үзүүлэлтээс өссөн байх;
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын төсөөллийн судалгааны дүн сайжирсан байх;
- Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдал хангагдсан байх;
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг шалгах, мэдээлэгчийг хамгаалахад иргэн хяналт тавих бололцоо бүрдсэн байх;
- Авлигад илүү өртсөн салбаруудын болон өндөр түвшний авлигын гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан нөхцөлийг бууруулсан байх;
- Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналт сайжирсан байх;
- Төрийн байгууллагад итгэх иргэний итгэл нэмэгдсэн байх.

**“МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2017 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙГ
ТОВЛОН ЗАРЛАХ, СОНГУУЛИЙН САНАЛ АВАХ ӨДРИЙГ ТОГТООХ ТУХАЙ”,
“МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2017 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ТЕХНИК ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛУУДЫН ТАНИЛЦУУЛГА**

Сонгуулийн ерөнхий хороо “Сонгуулийн төв байгууллагын тухай” хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн санал авах өдрийг тогтоох, Сонгуулийг товлон зарлах тухай саналаа 2017 оны 01 дүгээр сарын 18-нд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.3, 16.6 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс товлон зарлаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн санал авах ажиллагааг 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдөр явуулахаар, Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэний санал авах ажиллагааг 2017 оны 06 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд явуулахаар тус тус тогтоолоо.

2. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмжийг тус тус хэрэглэхээр шийдвэрлэлээ.

“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2017 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаархи Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулж, Улсын Их Хурлын 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан.

Тогтоолын төслийн талаар хууль санаачлагчид болон Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Байнгын хороодоос урьдчилан санал авахад Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тав, Улсын Их Хурал дахь намын бүлгүүдээс 61, Улсын Их Хурлын Байнгын хороодоос 33, нийт давхардсан тоогоор 99 хууль тогтоомжийн төслийг чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар саналаа ирүүлсэн.

“Монгол Улсын Их Хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан болно. Үүнд:

1. Хаврын ээлжит чуулганаар хэлэлцэн батлахаар хуульд тусгайлан заасан хууль тогтоомжийн төслүүд;
2. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлгийн шатанд байгаа төслүүдээс холбогдох Байнгын хороод нь эхний ээлжинд хэлэлцүүлэхээр санал болгосон хууль тогтоомжийн төслүүд;
3. Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд заасан болон Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр тэргүүн ээлжинд хэлэлцэх хууль тогтоомжийн төслүүдийг нэр заан тусгасан болно.

Түүнчлэн тогтоолын төсөлд тусгайлан заагаагүй боловч нийгэм, улс төр, эдийн засгийн зайлшгүй харилцааг зохицуулах хууль тогтоомжийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж байхаар тогтоолын төсөлд тусгав.

Дээрх үндэслэл, шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганаар 33 хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэхээр Улсын Их Хурлын тогтоолыг баталсан болно.

Б) Төсөв, санхүүгийн чиглэлээр:

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2018-2019 ОНЫ ТӨСВИЙН
ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**



Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдах үзүүлэлтүүдийг тодорхойлж өгсөн бөгөөд эдгээр үзүүлэлт тус бүрийг төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн баталлаа.

Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал:

№	Төсвийн тусгай шаардлагын үзүүлэлтүүд	Төсвийн тусгай шаардлага хангасан эсэх
1	Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;	Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн тухай хуульд цэвэр зэсийн үнийг 2017 онд 4,599.4 ам.доллар/тн, 2018 онд 4,658.9 ам.доллар/тн, 2019 онд 4,725.5 ам.доллар/тн байхаар төлөвлөсөн. Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.1.3.а заалтын дагуу зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тооцоход 1 тонн зэсийн сүүлийн 18, 19, 20 жилийн дундаж үнэ 4,598.9 ам.доллар орчим байгаа нь төлөвлөсөн үнэтэй тэнцэж байна. Нэгдсэн төсвийн орлогыг тэнвэржүүлсэн журмаар тооцоолсон байна. Олон улсын зах зээлийн үнэтэй уялдуулан зэсийн үнийг тооцоолж төсвийн тогтворжуулалтын санд 2017 онд 8.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.
2	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь 2017 онд тухайн жилийн ДНБ-ий 9.9 хувиас, 2018 онд тухайн жилийн ДНБ-ий 7.5 хувиас, 2019 онд 5.5 хувиас тус тус хэтрүүлэхгүй байх	Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2017 онд 2,408.7 тэрбум төгрөг буюу 9.1 хувийн алдагдалтай байхаар тооцоолсон нь хуулийн шаардлагыг хангаж байна.
3	Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунжийн аль ихээс хэтрэхгүй байх;	Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн төсөлд 2017 оны хүлээгдэж байгаа нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2017 онд 8,568.9 тэрбум төгрөг болж 2016 оны тодотголоос 1,125.5 тэрбум төгрөгөөр буурахаар байна. Энэхүү аргачлалаар тооцсон эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж 22.5 хувь байгаатай харьцуулахад хуулийн тусгай шаардлагыг хангасан байна.
4	Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь 2017 оны төсвийн жилд тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 85.0 хувиас, 2018 оны төсвийн жилд 80.0 хувиас, 2019 оны төсвийн жилд 75.0 хувиас тус тус хэтрүүлэхгүй байх	Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл 2017 онд 22,197.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 84.8 хувь, 2018 онд 22,818.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 79.9 хувь, 2019 онд 23,798.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 74.8 хувьтай тэнцэхээр байгаа нь төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.

Засгийн газрын өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тусгагдсан эдийн засгийн үзүүлэлтүүдэд дор дурдсан өөрчлөлтүүд орлоо.

Үндсэн үзүүлэлтүүд

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2017 он	2018 он	2019 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	3.0	5.1	7.1
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин /хувь/	6.5	7.6	8.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	6,160.2	6,822.6	7,561.3
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	23.3	23.8	23.7
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	8,568.9	8,971.2	9,316.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.3	31.3	29.2
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	-1,125.5	402.3	345.3
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-4.2	1.4	1.1
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,408.7	-2,148.6	-1,755.2
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-9.1	-7.5	-5.5
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,483.9	1,517.6	1,540.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	5.6	5.3	4.8
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	22,363.7	22,889.5	23,903.1
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	84.4	79.9	74.9
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	467.3	490.7	623.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.8	1.7	2.0

Хууль батлагдсанаар дунд хугацаанд баримтлах төсвийн чиг хандлага тодорхойлогдох юм.

МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2016.11.10	<h3 style="color: #e67e22;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ</h3> <p>Засгийн газраас 2016.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн</p>	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2017.01.01
---	---	---

1. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн талаар:

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийг баталснаар Монгол Улсын төсөвт 2017 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, Ирээдүйн өв сангаас улсын төсөвт олгох шилжүүлэг болон улсын төсөвт төлөх өглөг барагдуулалтын хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн.



Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 6,160.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 23.3 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 8,568.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 32.3 хувь болж, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн алдагдал 2,408.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 9.1 хувьтай тэнцэж байна.

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт орлого 6,390.2 тэрбум төгрөгт хүрч, үүнээс Тогтворжуулалтын санд 8.4 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 221.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 6,160.2 тэрбум төгрөг болж, 2016 оны тодотгосон төсвийн дүнгээс 812.0 тэрбум төгрөг буюу 15.2 хувиар нэмэгдсэний 473.1 тэрбум төгрөг буюу 58.3 хувийг татварын орлого, 338.8 тэрбум төгрөг буюу 41.7 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зардлыг 250.6 тэрбум төгрөгөөр, “Барих-Шилжүүлэх” концессийн төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зардлыг 71.5 тэрбум төгрөгөөр, Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зардлыг 172.8 тэрбум төгрөгөөр баталлаа.

Мөн Засгийн газрын 2017 оны төсвийн жилд нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээг 2,336.2 тэрбум төгрөг байхаар баталж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3 дахь хэсэгт заасан Засгийн газрын өрийн хязгаарт багтаан өрийн зохицуулалт хийх чиглэл өгсөн.

Орон нутгийн төсөв

Монгол Улсын 2017 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 15 аймагт 131.3 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 132.6 тэрбум төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг Улаанбаатар хот болон 21 аймагт 74.5 тэрбум төгрөгөөр баталсан.

2017 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

/сая төгрөг/

Д/д	Аймаг	Санхүүгийн дэмжлэг	Тусгай зориулалтын шилжүүлэг	Аймаг, нийслэлийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээ
1	Архангай Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	11,875.4	38,111.7	1,892.0 627.8
2	Баян-Өлгий Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	10,252.9	47,777.2	2,052.0 443.1
3	Баянхонгор Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	11,088.8	37,579.5	2,980.0 734.9
4	Булган Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	0.0	29,075.4	1,977.0 603.6
5	Говь-Алтай Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	8,172.4	32,635.5	3,768.0 603.2
6	Дорноговь Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	0.0	28,888.2	4,947.6 341.9
7	Дорнод Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	2,499.3	29,441.7	2,630.6 557.1
8	Дундговь Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	5,722.6	22,490.8	2,635.1 353.6
9	Завхан Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	9,359.3	35,782.1	1,996.3 432.5
10	Өвөрхангай Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	11,418.4	44,229.2	2,132.2 672.1
11	Өмнөговь Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	0.0	27,850.5	10,307.6 443.8
12	Сүхбаатар Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	5,086.5	28,023.6	4,086.8 536.0
13	Сэлэнгэ Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	3,044.2	44,665.7	3,175.6 725.2
14	Төв Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	7,577.1	41,703.5	3,547.9 631.3
15	Увс Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	11,074.6	38,648.0	2,026.2 542.8
16	Ховд Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	7,726.4	39,251.9	2,387.5 690.8
17	Хөвсгөл Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	17,963.8	54,636.8	2,189.4 1,150.6
18	Хэнтий Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	8,437.1	32,987.8	2,900.5 601.1
19	Дархан-Уул Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	0.0	32,923.3	1,946.4 1,275.3
20	Улаанбаатар Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	0.0	314,486.8	12,135.1 319.0
21	Орхон Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	0.0	32,788.9	1,606.6 1,006.3
22	Говьсүмбэр Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	0.0	7,662.0	1,185.4 170.2
	Нийт дүн	131,300.7	1,041,640.0	74,505.9

2. Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн талаар:

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хууль баталснаар Нийгмийн даатгалын санд 2017 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн.

2017 оны төсвийн жилд Нийгмийн даатгалын санг бүрдүүлэх тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний, ажилгүйдлийн, эрүүл мэндийн даатгалын гэсэн таван сангийн орлогыг 1,390.8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2016 оны тодотгосон дүнгээс 133.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тус сангаас 2017 онд тэтгэвэр, тэтгэмж, эмчилгээ үйлчилгээг давхардсан тоогоор 4.5 сая иргэдэд хүргэж, нийт 1,887.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг зарцуулахаар төлөвлөсөн нь 2016 оны тодотгосон дүнгээс 123.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

Мөн Нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох санхүүжилтийг 587.3 тэрбум төгрөгөөр буюу 2016 оны тодотгосон дүнгээс 92.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, тус сангийн нийт орлого 1,978.0 тэрбум төгрөгөөр батлагдсан нь ДНБ-ний 7.4 хувьтай тэнцэж байна.

2017 онд Нийгмийн даатгалын сангийн хуримтлалын сангаас Засгийн газрын урт хугацаат /нэг жил болон түүнээс дээш/ бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 100.0 тэрбум төгрөгөөр баталлаа.

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2017.02.02	<h3 style="color: #e67e22;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ</h3> <p>Засгийн газраас 2016.12.22,28-ны өдөр өргөн мэдүүлсэн</p>	ДАГАН МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
---	--	--

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах хоёр хуулийн төслийг Улсын Их Хурал нэгтгэн, нэг төсөл болгон хэлэлцэж баталлаа.



Энэ нь сангийн үйл ажиллагаа өргөжин, Олон улсын байгууллагаас санхүүжилт авч, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх зэрэг арга хэмжээ авахад санхүү, эдийн засгийн хүндрэл тулгардаг бэрхшээл тодорхой хэмжээгээр багасч, энэ салбарт бодитой үр дүн гарах ач холбогдолтой гэж Улсын Их Хурал үзлээ.

Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай, Усны тухай, Усны төлбөрийн тухай хуулиудад тусгагдсан Байгаль хамгаалах сангийн нэрийг тус бүр Байгаль орчин, уур амьсгалын сан гэж өөрчиллөө.

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2017.02.02	ХУУЛЬ САНААЧЛАГЧ УИХ-ын гишүүдээс 2016.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2017.03.01
---	--	---

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар нарын нэр бүхий найман гишүүн дээрх хуулийн үйлчлэлийг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгах нь зүйтэй гэж үзэж хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн юм.

2016.06.06-ны өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн үйлчлэл 2016.12.31-ний өдрөөр дуусгавар болсон.

Хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцаас шалтгаалан 2017.01.01-2017.03.01-ний өдөр хүртэлх хугацаанд хуулийн үйлчлэл зогссон бөгөөд энэ хугацаанд татвар чөлөөлөлтөд амрагдах бараанд ногдуулах татварыг иргэн, аж ахуйн нэгжид буцаан олгох асуудлыг дагаж мөрдөх журмын тухай хуулиар зохицууллаа.



УИХ-ын гишүүн Ж.Ганбаатар нарын нэр бүхий 8 гишүүн уг хуулийн үйлчлэлийг 2018.12.31-ний өдөр хүртэл сунгах хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, хуулийн үйлчлэлийн хугацааг сунгахаар баталсан.

Хууль батлагдсанаар жижиг, дунд үйлдвэрийн хүрээнд ажлын байр нэмэгдэх, иргэдийн бизнес эрхлэх хүсэл эрмэлзэл дээшилж, дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэн, улмаар экспортлох, татварын чөлөөлтөд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн бүтээмж нэмэгдэнэ гэж УИХ үзлээ.

Энэ хууль батлагдсанаар жижиг, дунд үйлдвэрийн хүрээнд ажлын байр нэмэгдэх, иргэдийн бизнес эрхлэх хүсэл эрмэлзэл дээшилж, дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэн, улмаар экспортлох, татварын чөлөөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн бүтээмж нэмэгдэнэ.

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2017.02.02	<h3 style="color: #e67e22;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ</h3> <p>Засгийн газраас 2016.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн</p>	ДАГАЖ МӨРДӨК ХУГАЦАА Ердийн журмаар
---	---	--

Жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэхмэлийн болон хувцас үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн албан татварынх нь 90 хувийг нь хөнгөлөхөөр боллоо.

ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ



Жилийн борлуулалтын орлого 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй дөрвөн салбарын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг албан татвар төлөгчийн албан татварынх нь 90 хувийг нь хөнгөлсөн.



ХУУЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ:

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл



Нэхмэлийн болон хувцас үйлдвэрлэл



Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа



Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлийн үйл ажиллагаа



ХУУЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ




Энэ хууль батлагдсанаар эдийн засгийн өсөлт удааширсан, ажилгүйдлийн түвшин буурсан өнөөгийн нөхцөл байдалд бизнесийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, хөрөнгө оруулалтыг татахад жижиг, дунд бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд тодорхой хувь нэмэр болох арга хэмжээ гэж УИХ үзлээ

Татварын хөнгөлөлтийг дээрх дөрвөн салбарын хүрээнд хэрэгжүүлэхдээ эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллыг баримтлах юм.

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2016.12.09	<h3 style="color: #e67e22;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ</h3> <p>Засгийн газраас 2016.11.04-ний өдөр өргөн мэдүүлсэн</p>	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	--	--

Дэлхийн худалдааны байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрт манай улсын Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, “Импортын барааны гарал үүслийн дүрэм”-ийг нийцүүлэх, гадаад худалдаа эрхлэгчдэд тулгарч байгаа хүндрэлийг багасгах зорилгоор Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.



Хуулийн ач холбогдол:

Хууль батлагдсанаар дотоодын хууль, эрх зүйн орчныг олон улсын гэрээ хэлэлцээр, Дэлхийн худалдааны байгууллагын дүрэм, журам, Олон улсын гаалийн байгууллагаас гаргасан зөвлөмжид нийцүүлэх, гадаад худалдаа эрхлэгчдэд нэн тааламжтай, хөнгөлөлттэй, ердийн тариф хэрэглэх хуулийн заалт, дүрмийн зохицуулалтыг эмх цэгцтэй болгох боломж бүрдэж байна.

В) Эдийн засгийн чиглэлээр:

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТАНИЛЦУУЛГА**

БАТАЛСАН ОГНОО 2017.02.10	ХУУЛЬ САНААЧЛАГЧ УИХ-ын гишүүдээс 2016.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАН МӨРДӨХ ХУГАЦАА 2017.04.01
---	--	---

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль 7 бүлэг, 32 зүйлтэй.

ХӨГЖЛИЙН БАНК

- Үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилготой
- Импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой
- Хуульд заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд

1 Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн, хуульд заасан болон Хөгжлийн банкны журмаар тогтоох шалгуурууд, эдийн засгийн болон санхүүгийн үр ашигтай байх шаардлагыг төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ

Монголбанк тогтмол хяналт тавьж, шалгалт хийнэ

Засгийн газраас 2 жил тутамд шалгалт явуулна

Хөндлөнгийн аудитын компаниар аудит хийлгэнэ

ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭГ ӨРГӨТГӨСӨН

Монгол Улсын Хөгжлийн банкны компанийн засаглалын тогтолцоог сайжруулах зохицуулалтыг хуульчлав

Монгол Улсын Хөгжлийн Банк хараат бус, бие даасан байдал, ашигтай ажиллах зарчмыг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэв

Монгол Улсын Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлж ирсэн хэдий ч улс төрөөс хэт хараат байдал, банкны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн боловсронгуй бус байдал нь уг банкны үр ашигтай ажиллах боломжийг бууруулж, төсөв, санхүүгийн салбарт багагүй хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байсныг шийдвэрлэх зорилгоор Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд уг хуулийн төслийг санаачилжээ.

Хөгжлийн банк нь үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой, хуульд заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд байна. Хөгжлийн банкийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргах юм.

ХУУЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ:

Хөгжлийн банк тогтвортой, үр ашигтай ажиллах, үйл ажиллагааны эрсдэл буурах, зээл олгох үйл ажиллагааны шуурхай байдал хангагдах, банкны үйл ажиллагааны хүрээ өргөжих, компанийн засаглал бэхжих бөгөөд банкны үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо боловсронгуй болсноор олон нийтийн банкинд итгэх итгэл өсөж, цаашид банкны нэр хүнд, зээлжих зэрэглэл өсөх боломж нэмэгдэнэ.

Банкны бүтэц, зохион байгуулалт, засаглалын бодлого, стратеги төлөвлөлт, эрсдэлийн удирдлага, бизнес төлөвлөгөө, санхүүгийн болон бусад үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах үйл явц бэхжиж, хараат бус, шуурхай болох ач холбогдолтой гэж үзэж байна.

Тус банк нь Монгол Улсын хөгжлийн бодлогод нийцүүлэн хөрөнгө оруулалт хийж, улс төрөөс хараат бусаар, бие даан ажиллах, ингэхдээ оновчтой, зүй зохистой хяналтан дор үйл ажиллагаагаа эрхлэх, хариуцлагатай, ил тод байх зарчмыг удирдлага болгон ажиллана.

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТАЛААР АВАХ ЗАРИМ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

БАТАЛСАН ОГНОО 2017.12.28	<h2 style="color: #e91e63;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ</h2> <p>УИХ-ын гишүүдээс 2016.02.14-ны өдөр өргөн мэдүүлсэн</p>	ДАГАН МӨРДӨХ ХУГАЦАА ЕРДИЙН ЖУРМААР
--	--	--

Хөгжлийн банкныг 2011 онд үүсгэн байгуулсан. Тус банкны дүрмийн санг 16.7 тэрбум төгрөгөөр анх бүрдүүлж, улмаар үе шаттайгаар нэмэгдүүлсээр банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 245.3 тэрбум төгрөгт хүрээд байна. 2016 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар долоон их наяд төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна.

Түүнчлэн Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон 5,9 их наяд төгрөгийн зээлийн багцын 54.5 хувийг буюу 3,2 их наяд төгрөгийг улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлд олгосон бөгөөд үүнтэй холбогдон Засгийн газар,

ЗАСГИЙН ГАЗАР	ХӨГЖЛИЙН БАНК
<p><i>Засгийн газар, Хөгжлийн банк хооронд хүү, үндсэн төлбөр, ханшийн зөрүүний өр, авлагын тооцоо үүссэн байсныг шийдвэрлэх эрх зүйн орчныг бий болгов</i></p> 	<p>Хөгжлийн банкны санхүүгийн чадавхи, зохистой харьцааны үзүүлэлтүүд сайжирна.</p>  <p>Нэмэлт эх үүсвэр татан төвлөрүүлэх боломж нэмэгдэнэ.</p> 
<p>Засгийн газар, Хөгжлийн банк хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн өр, авлагын тооцоог 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон харилцан суутгах замаар эцэслэн</p> 	<p>Монгол Улсын Хөгжлийн банкны зохистой харьцааны холбогдох шалгуур үзүүлэлтийг сайжруулна</p> <p>Монгол Улсын Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийг 1.0 их наяд хүртэлх төгрөгийн Засгийн газрын мэт цаас гагаж</p> <p>Банкны өөрийн хөрөнгө нэмэгдсэнээр зээлжих зэрэглэл тогтоогч байгууллага, хөрөнгө оруулагчид болон зээлдүүлэгч нарын өмнө банкны санхүүгийн үзүүлэлтүүд эрс сайжирна.</p> 

Хөгжлийн банк хооронд хүү, үндсэн төлбөр, ханшийн зөрүүний өр, авлагын тооцоо үүссэн байсныг шийдвэрлэх эрх зүйн орчныг бий болгов.

Энэхүү тогтоол батлагдсанаар Хөгжлийн банкны санхүүгийн чадавхи, зохистой харьцааны үзүүлэлтүүд сайжирч, улмаар нэмэлт эх үүсвэр татан төвлөрүүлэх боломж нэмэгдэнэ.

“ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2017 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2016.11.17	<h3 style="color: #e91e63; margin: 0;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ</h3> <p style="color: #e91e63; font-weight: bold; margin: 0;">Монголбанкнаас 2016.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн</p>	ДАГАЖ МӨРДӨХ КУГАЦАА ЕРДИЙН ЖУРМААР
--	---	--

Тогтоолоор эдийн засгийн хүндрэлийг даван туулах, банкны тогтолцооны эрсдэл даах чадварыг сайжруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанкинд даалгалаа.

ЗОРИЛГО:

Эдийн засгийн хүндрэлийг **хохирол багатайгаар** даван туулж, макро эдийн засгийг **богино хугацаанд** тогтворжуулан эдийн засгийн дунд, урт хугацааны **тогтвортой өсөлтийг** хангах нөхцөлийг **бүрдүүлэхэд чиглэгдэнэ.**

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Инфляцийг 2017-2019 онд жилийн **8 хувиас дээшгүй** түвшинд байлгана.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн **суурь** нөхцөлтэй нийцэн, **уян хатан** тогтох зарчмыг баримтална.

Эдийн засгийн гадаад орчинд гарч болзошгүй огцом өөрчлөлтийг төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн уян хатан бодлого, мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг ашиглан зохицуулж, гадаад валютын улсын нөөцийг зохих түвшинд хүргэн нэмэгдүүлнэ.

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

Санхүүгийн салбарын **эрсдэлийг бууруулах**, санхүүгийн **тогтвортой** байдлыг хангах зорилгоор системийн тогтвортой байдлын үнэлгээг олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран гүйцэтгэж, макро зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.

Банкны салбарын төлбөр **түргэн гүйцэтгэх** болон эрсдэл даах чадварыг хадгалах, **болзошгүй эрсдэлээс** урьдчилан **сэргийлэх** арга хэмжээ авна.

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд **даван туулах** үүднээс Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг **идэвхижүүлж**, зөвлөлийн гишүүдийн **хамтын ажиллагааг** өргөжүүлнэ.

Монголбанкны **бие даасан**, хараат бус байдал, валют, үндэсний төлбөр тооцооны системийн **зохицуулалтыг** боловсронгуй болгоно.

Монголбанк системийн хэмжээнд чанаргүй зээлийн хэмжээг бууруулах, банкны салбарын эрсдэл даах чадварыг хадгалах зорилгоор санхүүгийн салбарын чанаргүй зээлийг хоёрдогч зах зээлд борлуулах, цаашид тэдгээрийг зөв зохистой удирдах боломжийг бүрдүүлж, урт хугацаанд уг үйл ажиллагааны оновчтой тогтолцоог хөгжүүлэх суурийг бүрдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран эхлүүлнэ.

Монгол Улсын зээлжих зэрэглэл, эдийн засгийн орчныг сайжруулах бодлогын арга хэмжээг 2017 онд авч хэрэгжүүлэх нь нийт эдийн засгийн эрсдэлийг бууруулж, эдийн засагт итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна. Үүний зэрэгцээ олон улсын санхүүгийн зах зээлээс шинээр эх үүсвэр татах, хөрөнгө босгох, өмнөх өрийг дахин санхүүжүүлэх өртгийг бууруулах, гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх зэрэг нөлөөллүүд бий болно.

**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

БАТАЛСАН ОГНОО 2016.11.24	ХУУЛЬ САНААЧЛАГЧ Засгийн газраас 2016.10.27-ны өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	---	--

Засгийн газар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүд, яамд, агентлагаас ирүүлсэн саналд үндэслэн, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулан боловсруулжээ.

Нийт 5 бүлэг, 17 зорилт, 118 бодлогын арга хэмжээ тусгагдсан.

Нэг. Макро эдийн засгийн бодлого	Хоёр. Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	Эдийн засгийн нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	Бүс орчны бодлого	Дөрөв. Хүнний хөгжлийг дэмжих нийгмийн салбарын бодлого	Хүний Тав. Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад харилцаа, баглан хамгаалах салбарын бодлого
12 арга хэмжээ	31 арга хэмжээ	17 арга хэмжээ	38 арга хэмжээ	20 арга хэмжээ	

Нийт 118 арга хэмжээнд 5.38 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдэнэ. Үүнээс:

- Улсын төсөв – 353.9 тэрбум төгрөг
- Гадаад эх үүсвэр – 825.2 тэрбум төгрөг
- Төр, хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалт – 4.1 их наяд төгрөг
- Бусад эх үүсвэр – 104.0 тэрбум төгрөг тус тус байна.

Макро эдийн засгийн бодлогын хүрээнд 2017 онд эдийн засгийг сэргээх, үйлдвэрлэл, дэд бүтцийн томоохон төслүүдийг эрчимжүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, инфляцийг зорилтот түвшинд байлгах, ажлын байрыг нэмэгдүүлж ажилгүйдлийн түвшинг бууруулах, нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг өмнөх оны түвшнээс бууруулж дунд хугацаанд төсвийн үндсэн тэнцлийг эерэг болгох нөхцөлийг бүрдүүлэх, Засгийн газар, Хөгжлийн банкны гадаад бондыг эргүүлэн төлөх эх үүсвэрийг шийдвэрлэж, дунд хугацаанд өрийн дарамтыг бууруулах бодлого хэрэгжүүлэн, валютын орох урсгал түр зуур нэмэгдэх үед төгрөгийн нийлүүлэлтийг огцом нэмэгдүүлэхгүй, валютын нөөцийг хамгаалах зарчим баримтлахаар тогтоолд тусгалаа.

Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлогын хүрээнд хууль сахиулах байгууллагуудын эрх зүйн орчныг сайжруулж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгох, энхийг эрхэмлэсэн, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулж, хилийн чанадад амьдарч буй монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулан, хөрш орнуудад хийх худалдааг өргөжүүлэх бодлого баримтлах, батлан хамгаалах салбарын эрх зүйн орчныг сайжруулж, улс орныг батлан хамгаалах чадавхийг бэхжүүлэх чиглэлээр тодорхой зорилт тавин ажиллана.

Тогтоолын үр дүн



Салбарын яамд, агентлагуудаас ирүүлсэн арга хэмжээний саналуудыг үндсэн чиглэлийн төсөлд тусгахдаа бодлогын зорилт, арга хэмжээг улсын төсөв болон бусад хөрөнгийн эх үүсвэрийн боломжтой уялдуулан 104 арга хэмжээний хүрээнд нийтдээ 5.3 их наяд төгрөгийг санхүүжүүлэхээс улсын төсвийн хөрөнгөөр 327.6 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 825.2 тэрбум төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалтаар 4.1 их наяд төгрөг, бусад эх үүсвэрээс 104 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөн тусгасан болно.

**“ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

БАТАЛСАН ОГНОО 2016.11.24	<h2 style="color: #e67e22; margin: 0;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ</h2> <p style="color: #34495e; font-weight: bold; margin: 0;">Засгийн газраас 2016.10.27-ны өдөр өргөн мэдүүлсэн</p>	ДАГАН МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	--	--

Монгол Улсын макро эдийн засгийг тогтворжуулах бодлого хэрэгжүүлэх, дунд хугацаанд эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийж, тогтвортой өсөлтийг хангах, өрийн дарамтыг бууруулах гэсэн үндсэн хоёр стратегитай 66 бодлогын арга хэмжээ бүхий бодлогын баримт бичгийг боловсруулжээ.

Хөтөлбөрийн зорилго:

Эдийн засагт үүссэн хүндрэлийн богино хугацаанд даван туулж, макро эдийн засгийг тогтворжуулах, дунд хугацаанд өрийн дарамтыг багасгах, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, эдийн бүтцийг төгөлдөржүүлж, иргэд бизнес эрхлэгчдийн ашиг, орлогыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.



ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ



-Төсвийн сахилга батыг сайжруулах, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлэх, үр дүнгээр санхүүжүүлэх, төсвийн норм, нормативыг баримтлан хэмнэлтийн горимд шилжих;



-“Үндэсний хэмнэлт”-ийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, дотоодын зах зээлийг тарифийн болон тарифийн бус аргаар хамгаалах;



-Дотоодын худалдан авалтыг бодлогоор дэмжиж хууль эрх зүйн орчинг сайжруулах;



-Байнгын болон түр ажлын байрыг тогтвортой хадгалж байгаа аж ахуйн нэгжүүдийг татвар, зээлийн бодлогоор дэмжих;



-Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татаж гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалтыг татах хууль, эрх зүйн орчинг сайжруулах;



-Хөрөнгө оруулагчид урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөл бүрдүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл байгуулах;



-Бодит салбарын өсөлтийг дэмжих чиглэлээр Таван толгой-Гашуун сухайт, Нарийн сухайт-Шивээхүрэн, Зүүнбаян-Ханги, Эрдэнэт-Овоот, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дэмжиж, Богд хан төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх;



-Цахилгаан станц, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудыг шинээр барих, өргөтгөх ажлыг хэрэгжүүлэх;



-Томоохон үйлдвэрлэлээ дагасан жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжиж, төрөлжсөн кластерыг бий болгох замаар өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг богино хугацаанд үр дүнтэй хэрэгжих олон төсөл арга хэмжээнүүдийг тусгалаа.

Г) Нийгэм, боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр:

**АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТАНИЛЦУУЛГА**

БАТАЛСАН ОГНОО 2017.01.26	<h2 style="color: #e91e63;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ</h2> <p>Засгийн газраас 2016.11.11-ний өдөр өргөн мэдүүлсэн</p>	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	--	--



- ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ
- ЗӨВЛӨГӨӨ ЕГӨХ
- ЯВУУЛЫН
- ӨДРИЙН
- САЙН ДУРЫН
- ӨДРӨӨР ЭМЧЛЭХ, АСРАН СУВИЛАХ
- ХҮНСНИЙ ДЭМЖЛЭГ
- АСРАМЖ
- ХҮЧИРХИЙЛЭЭС ХАМГААЛАХ

**АХМАД НАСТАНД ҮЗҮҮЛЭХ
ШИНЭ ТӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

АХМАД НАСТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ



ХӨНГӨЛӨЛТТЭЙ
ҮНЭЭР ЭМ ОЛГОХ
ЖУРМЫГ ШИНЭЧИЛНЭ.

СҮМ, ТОСГОН, ӨРХИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ
АХМАД НАСТНЫ ЭМЧ,
ЭСХҮЛ МЭРГЭШСЭН
ЭМЧ АЖИЛЛУУЛНА.

АЙМАГ, ДҮҮРГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ
АХМАД НАСТНЫ
КАБИНЕТ АЖИЛЛУУЛНА

АХМАД НАСТАНД РАШААН
СУВИЛАТД АМАРЧ
СУВИЛУУЛАХ ТОХИОЛДОЛД
ЗАМЫН ЗАРДАЛ, ЭРХИЙН
БИЧГИЙН ҮНИЙН 50 ХУВИЙГ,
ХҮНДЭТ ДОНОР АХМАД
НАСТАНД 100 ХУВИЙГ ЖИЛД
НЭГ УДАА НӨХӨН ОЛГОНО.

АХМАДЫН ӨРГӨӨ



НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА НЬ СҮМ,
ТОСГОН, ХОРОО, БАГТ "АХМАДЫН
ӨРГӨӨ" БАЙГУУЛАН АЖИЛЛУУЛНА.



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЗҮГЭЭС
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГАА ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХҮРЭЭНД АХМАД НАСТНЫ ҮЙЛЧИЛГЭЭ, АРГА
ХЭМЖЭЭНД ЧИЛГЭСЭН ХАНДИВ, ТУСЛАМЖ
ҮЗҮҮЛЭХЭД НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГА ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛНЭ.

АХМАДЫН ОРДОН, ӨРГӨӨ, ТАНХИМ, ТӨВ
АЖИЛЛУУЛАХАД ШААРДАГДАХ ХӨРӨНГӨ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫГ ТУХАЙН
ОРОН НУТГИЙН ЖИЛ БҮРИЙН ТӨСӨВТ
ТУСГАНА.



АХМАД НАСТНЫ АМЬЖИРГААГ ДЭМЖИХ



ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИН
ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСНИЙ ДООД ХЭМЖЭЭ
ИНФЛЯЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХАРГАЛЗАН
ТЭТГЭВРИЙН НЭМЭГДҮҮЛНЭ.



ШУДНИЙ ПРОТЕЗИЙН ҮНИЙН
ХӨНГӨЛӨЛТИЙГ 3 ЖИЛД НЭГ УДАА
ОЛГОНО.




АХМАД НАСТАНД АМРАЛТ,
СУВИЛТЫН ГАЗАРТ АМРАХ ЭРХИЙН
БИЧГИЙГ ЖИЛД НЭГ УДАА
ХӨНГӨЛӨЛТТЭЙ ҮНЭЭР ОЛГОНО.



АХМАД НАСТАН НИЙСЛЭЛ, АЙМГИЙН
ТӨВИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЭЛ ЭЭР ОРОН
НУТГИЙН ХАРЬЯАЛАЛ ХАРГАЛЗАХГҮЙ
ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ЗОРЧИНО.

**АХМАД НАСТНЫ ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ**

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ХҮСЭЛТЭЙ
АХМАД НАСТНЫГ БҮРТГЭЖ,
МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ



АЖИЛД ЗУУЦЛАХ, НӨХӨРЛӨЛ, ХОРШООНЫ
ХЭЛБЭРЭЭР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХИЙГ ДЭМЖИХ,
БИЗНЕС ИНКУБАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, ЖИЖИГ
ЗЭЭЛ ОЛГОХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТАД
ХАМРУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

ЗАЛУУЧУДАД АМЬДРАХ УХААН, АЖ АХУЙ
ЭРХЛЭХ БОЛОН БУСАД ЧИЛГЭЛЭЭР
ТАНХИМЫН, ЗАЙНЫ, ШАВЬ СУРГАЛТ
ЯВУУЛАХЫГ ДЭМЖИЖ АЖИЛЛАХ

АХМАД НАСТНЫ ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙГ
БАТАЛЖ, ХЭРЭГЖҮҮЛНЭ



ХҮНДЭТГЭЛ, АРГА ХЭМЖЭЭ

- ХАРЬЯАЛАХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА БАИХГҮЙ
АХМАД НАСТНЫГ ОРОН НУТГИЙН УДИРЛАГА, НИЙГМИЙН
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА ЦАГААН САР,
АХМАДЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН ХҮЛЭЭН АВЧ
ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛНЭ.
- ХУДАЛДАА, ТЭЭВЭР ХОЛБОО, ЭРҮҮЛ МЭНД, НИЙТИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР АХМАД НАСТАНД ТЭРГҮҮН
ЭЭЛЖИНД ҮЙЛЧИЛНЭ.
- АВТОБУСНЫ ЗОГСООЛ, ТӨМӨР ЗАМЫН ӨРТӨӨ, ХУДАЛДАА,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ, ЗЭРЭГТ АХМАД НАСТАНД
ЗОРИУЛСАН ТУСГАЙЛАН ТОНОГЛОСОН СУУДАЛ, ТАВЦАН,
ГАРЦ, ШАТ, УГААГУУР, СУУЛУУР ЗЭРГИЙГ ХҮРЭЛЦЭЭТЭЙ
ХЭМЖЭЭГЭЭР БАЙРУУЛНА.



АЛДАР ЦОЛТОН АХМАД НАСТАНД ТӨРӨӨС НЭМЭГДЭЛ, ХӨНГӨЛӨЛТ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН
ОГНОО

2017.02.02

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

Засгийн газраас 2016.11.11-ний өдөр өргөн мэдүүлсэн

ДАГАЖ МӨРДӨХ
КУГАЦАА


2018.01.01

ӨМНӨ НЬ:

Монгол Улсын баатар,
Хөдөлмөрийн баатар, Ардын
болон Гавьяат цолтон ахмад
настанд төрөөс нэмэгдэл
олгодог байсан.

ОДОУ:

Монгол Улсын баатар,
Хөдөлмөрийн баатар, Ардын
болон Гавьяат цолтон, Төрийн
шагналт, Төрийн соёрхолт,
Ахмад дайчин, Улсын ударник,
Хувьсгалт тэмцлийн ахмад
зүтгэлтэн, Монгол Улсын
Үндсэн хууль баталсан /1990-
1992/ Ардын Их Хурлын
депутат, Улсын Бага Хурлын
 гишүүн ахмад настанд төрөөс
нэмэгдэл, хөнгөлөлт олгоно.



Ахмад настанд хөнгөлөлт олгох журам:

Нийслэлээс аймагт, аймгаас нийслэлд
ирэх, буцах замын зардлыг жилд нэг
удаа олгоно.

Дотоодын рашаан сувилалд ирэх,
буцах замын зардал, эрхийн бичгийн
үнийг жилд нэг удаа нөхөн олгоно.

Орон сууцны хөлс төлөхөд, хэрэв
нийтийн халаалтгүй сууц, гэрт
амьдардаг бол түлш худалдан авахад
зориулж жилд нэг удаа мөнгөн тусламж
олгоно.

Бүрдүүлэх материал:

- Өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Депутат, гишүүний үнэмлэх

Ахмад настанд сар бүр

150,000

төгрөг олгох:

Нэмэгдэл авах эрх



Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт



Нэмэгдэл, хөнгөлөлтийг зогсоох, нөхөн төлүүлэх:

Нэмэгдлийг нас барсны дараачийн сар
дуустал олгоно.

Байгууллага, албан тушаалтны
буруугаас дутуу олгогдсон нэмэгдэл,
хөнгөлөлтийг ахмад настанд нөхөн
олгоно.

Хуурамч баримт бичиг бүрдүүлж,
нэмэгдэл хөнгөлөлт авбал олголтыг
зогсоож олгогдсон нэмэгдэл,
хөнгөлөлтийг нөхөн төлүүлнэ.

Ажилтны буруугаас илүү нэмэгдэл,
хөнгөлөлтийг буцаан суутгахгүй бөгөөд
хохирлыг шүүхийн шийдвэрээр
буруутай албан тушаалтнаар нөхөн
төлүүлнэ.

Алдар цолтон ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хууль баталсан Ардын Их Хурлын депутат 230 хүн, Улсын Бага Хурлын гишүүн 8, нийт 238 хүнд сар бүр нэмэгдэл олгох асуудал нэмж тусгагдсан бөгөөд эдгээр ахмад настанд сар бүр 150,0 мянган төгрөг олгоход жилд 428,4 сая төгрөг зарцуулах юм.

МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН
ОГНОО

2017.02.02

УИХ-ын гишүүн С.Чинзориг 2016.10.07-ны өдөр өргөн мэдүүлсэн

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА

2018.01.01



- 300 мянга гаруй малчин ДНБ-ий 10% -ийг үйлдвэрлэж байна.
 - Малчит нийт ажиллагсдын 47.5%-ийг эзэлж байна.
- Үйл ажиллагаа улирлын чанартай, орлого бага
- байдгаас олонхи нь нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй.

ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

- 1995 оноос энэ хууль хүчин төгөлдөр болсон өдөр хүртэл хугацаанд малчнаар ажилласан болон хувиараа хөдөлмөр эрхэлж байсан 15-60 насны иргэн хамаарна.
- ЕБС, их, дээд сургууль, коллежийн өдрийн ангид суралцсан хугацаа малчнаар ажилласан жилд хамаарахгүй.
- Өөр ажил эрхэлсэн хугацаа малчнаар ажилласан болон хувиараа хөдөлмөр эрхлэгч байсан хугацаанд хамаарахгүй.



ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ХУВЬ, ХЭМЖЭЭ

- Иргэний сард нөхөн төлбөл зохих тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ нь тухайн үед Засгийн газар болон эрх бүхий этгээдээс батлан мөрдүүлсэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10 хувьтай тэнцүү байна.

ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА

- Иргэн нь малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч байсан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх хүсэлтээ өөрийн харьяалах сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагад гаргана.



МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО	ХУУЛЬ САНААЧЛАГЧ	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА
2017.02.02	УИХ-ын гишүүдээс 2016.10.07-ны өдөр өргөн мэдүүлсэн	2018.01.01

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь 5 зүйлтэй.

ЭХЧҮҮДЭД ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГ	МАЛЧДАД ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГ
<p>Төр, аж ахуйн нэгж, байгууллага хүүхдээ гурван нас хүртэл асрах чөлөөтэй байсан хугацааны шимтгэлийг тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын санд төлсөн тохиолдолд эдгээр хугацааг шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно.</p> <p>Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн эхэд тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож, 4 сарын хугацаанд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно.</p>	<p>Нийт 20-иос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн;</p> <p>Нийт 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.</p> <p>Малчнаар ажилласан 1 жилийг 1 жил 6 сараар нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласнаар тооцох боллоо.</p>
<p>Хүүхэд төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авч зургаан нас хүртэл өсгөсөн эх Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаанд дээр төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор НЭГ ЖИЛ ЗУРГААН САРЫГ нэмж тооцно.</p> <p>Мөн даатгуулсан хэлбэрээс нь хамаарч жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг хөдөлмөрийн хөлснөөс ялгаатай хувь хэмжээгээр бодож байсныг өөрчлөв.</p> <p>Өмнө нь хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд зөвхөн хоёр удаа хүүхэд төрүүлсэн эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгодог байсан бол хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаандаа дахин хүүхэд төрүүлэхэд хязгаарлалт байхгүй боллоо.</p>	<p>Эхчүүдийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг даатгуулсан хэлбэрээс нь хамааралгүй адил хувь хэмжээгээр бодож, хүүхдээ асарч хөдөлмөр эрхлээгүй хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тасалдуулахгүй төлж, хүүхэд төрүүлж өсгөсөн хугацааг нь нэмэгдүүлж тооцоноор тэдний тэтгэврийн хэмжээ харьцангуй нэмэгдэж, нийгмийн баталгаа нь сайжирна.</p> <p>Малчдын тэтгэвэрт гарах насыг наашлуулж, малчнаар ажиллаж шимтгэл төлсөн хугацааг нь нэмэгдүүлж тооцоноор малчдын нийгмийн баталгаа сайжирна.</p>
ХУУЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ	

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалтыг “хүүхдээ гурван нас хүртэл асрах чөлөөтэй байсан хугацаа” гэж, 19² дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Энэ хуулийн 19¹ дүгээр зүйлд заасан тэтгэмж авах эрх үүссэн эхэд тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож, дөрвөн сарын хугацаанд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно” гэж өөрчлөн найруулсан. Энэ нь даатгуулсан хэлбэрээс нь хамааруулан жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг хөдөлмөрийн хөлснөөс ялгаатай хувь хэмжээгээр бодож байгааг өөрчлөхтэй холбоотой харилцааг зохицуулах ач холбогдолтой.

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2017.01.26	ХУУЛЬ САНААЧЛАГЧ Засгийн газраас 2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
---	---	--

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь 4 зүйлтэй.

Хуулийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага:

- 2010 онд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, цэргийн алба хаагчийн иргэний байгууллагад ажилласан нэг жилийг 6 сар цэргийн байгууллагад ажиллан шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцохоор болсон ч тэтгэвэр олгох сангийн нэрийг буруу бичсэнээс хуулийг хэрэглэх боломжгүй болж, ойлгомжгүй байдал үүссэн юм.
- Дээрх хуулийн зохицуулалтыг нэг мөр хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлага бий болсон.
- Тэтгэвэр тогтоолгох болон тогтоосны дараа илүү ажилласан хугацааны сарын нэмэгдлийн хувь хэмжээг тооцох.

Цэргийн алба хаагчийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр




Цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээ

9.2.Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан хугацаанаас илүү алба хаасан жил тутамд тэтгэвэр тогтоолгосон дундаж цалин хөлснөөс 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон цалин хөлснөөс тооцож нэмэгдэл олгоно.


Энгийн тэтгэвэр авагчийн хувьд ийм заалт хэрэгжиж байгаа бөгөөд цэргийн тэтгэвэр авагчид мөн адил зохицуулалт хийснээр 20, 25 жилээс дээш ажилласан сард ногдох тэтгэврийн нэмэгдлийг авах боломж бүрдлээ.

Энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд нэмэлт хөрөнгө шаардагдахгүй


Цэргийн алба хаасан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцох



Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх



Тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хугацаа



Хуулийн ач холбогдол:

- Тухайн цэргийн байгууллагад алба хаах насны дээд хязгаарыг ямар хуулийг баримтлан мөрдөж, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоохыг тодорхой болгосноор хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх давуу тал үүснэ.
- Цэргийн гэр бүлийн албан хаагчид нас барсан тохиолдолд тэдний асрамжид байсан бүтэн өнчин хүүхдэд олгох тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээ нэмэгдэж, хүүхдийн нийгмийн баталгаа сайжирна.
- Цэргийн тэтгэвэр тогтоох, олгох ажлыг гэрээгээр гүйцэтгэсэн тохиолдолд гарах үйл ажиллагааны зардлыг олгохоор тусгав.
- Цэргийн алба хаасны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгож, нийгмийн баталгаа хангагдах боломж бүрдлээ.
- Иргэний байгууллагад ажилласан жилээ цэргийн байгууллагад ажилласан жилд шилжүүлж, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох боломж бүрдлээ.
- Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч энгийн тэтгэвэр авагчийн нэгэн адилаар илүү алба хаасан сар тутамд ногдох тэтгэврийн нэмэгдлийг авахаар болов.

Д) Байгаль орчин, хөдөө аж ахуйн чиглэлээр:**“ХЭНТИЙ ХААН УУЛЫН НЭРИЙГ ӨӨРЧЛӨХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

БАТАЛСАН ОГНОО 2017.02.09	<b style="color: #e67e22;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ Засгийн газраас 2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
---	---	--

“Бурхан Халдун уул”, “Хэнтий Хаан уул” гэсэн нэршлүүд нэг уулын нэр болохын тухайд: Тогтоолын төслийг Улсын Их Хурал болон Байнгын хороогоор хэлэлцүүлэх явцад Шинжлэх ухааны академийн Түүх, археологи, газар зүйн хүрээлэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас ирсэн лавлагаа мэдээлэлд Бурхан Халдун уулыг XII зууны үед Монголын эртний хууль цаазын бичиг болох “Халх журам”-д дархан цаазтай болгон Их Монгол улсыг үндэслэгч Чингис хаан “Бурхан Халдуныг өглөө бүр мялаасугай, өдөр бүхэн тахисугай, үрийн үрд үүрд тахиж, үе удам үргэлж шүтэж, ургийн ураг минь ухан мэдтүгэй” гэж андгайлж, тахин шүтэж ирсэн уламжлал нь XIII-XVII зуун хүртэл үргэлжилсэн байна.

Харин XVII зууны сүүлчээс улс төрийн хямрал, харийн эрхшээлд орсон тодорхой цаг үед Бурхан Халдун уулын төр ёсны тахилга түр тасарч, 1800-аад оны эхэн үеэс сэргэхдээ Хэнтий Хаан уулын тайлга нэртэйгээр уг тахилгыг хийдэг болсон байна. Энэ нь Монголд бурханы шашин дэлгэрч уул овооны тахилгад шашны төлөөлөл голлох үүрэг гүйцэтгэх болж уул, усны нэрийг хэлэхгүй цээрлэн оронд нь Богд, Хайрхан, Хан, Хаан, Хатан, Гүн, Эрдэнэ гэх зэргээр хүндэтгэлийн нэр өгч шүтдэг болсонтой холбоотой. Бурхан халдун нэрийг хэрэглэхгүй болсон нь Хэнтийн нурууны нэг ноён оргил тахилга шүтлэгт “Хэнтийн нурууны Хаан” гэсэн утгаар “Хэнтий Хаан уул” гэж нэрлэж тахиж ирсэн бөгөөд Монгол Улсад анх газрын зураг хийх үед энэ нэрээр тэмдэглэгдэж, түүнээс хойш энэ нэрийг газрын зурагт хэрэглэдэг уламжлал тогтсон байна.

Бурхан Халдун уул Монголын нууц товчоонд үндсэн нэрээрээ 27 удаа бүртгэгдсэн, монголын ард түмний зан заншлыг тэр чигээр нь тусгасан, археологийн ямар нэгэн ул мөр илрээгүй, судалгаа хийгдээгүй, онгон дагшин хайрхан гэдэг үзүүлэлтээр ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд бүртгэгджээ.

“Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг” нэрээр Дэлхийн соёлын өвд бүртгэгдэн батлагдсан энэхүү газар нутаг нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт орших Хэнтийн нурууны салбар уулсын нэг болох 109°00'30”, 48°45'43”-ын солбицолд байрлах “Хэнтий Хаан уул” нэрээр газрын зурагт тэмдэглэгдсэн 2361.5 тоот өндөрлөг юм.

Тогтоолын төслийг хэлэлцэх явцад “Хэнтий Хаан уулын нэрийг Бурхан Халдун уул гэж өөрчлөх тухай” гэснийг “Хэнтий Хаан уулын нэрийг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол гэж өөрчилсөн болно.

“Хэнтий Хаан уулын нэрийг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолоор

ТОГТООЛ ГАРАХ ҮНДЭСЛЭЛ:




ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хорооны 2015 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 39 дүгээр чуулганы хуралдаанаар “Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг” гэсэн өвийг хэлэлцэн баталж, Дэлхийн соёлын өвд бүртгүүлэхэд “Бурхан Халдун уул” гэж Монгол Улсын албан ёсны газрын зурагт тэмдэглэгдээгүй, Хэнтийн нурууны далайн төвшнөөс дээш 2361,5 метрт орших “Хэнтий Хаан уул” нэрээр тэмдэглэгдсэн байна.

-Газрын тухай хуулийн 8.2-д Хилийн цэс, газар усны нэрийг Улсын Их Хурал батална, 8.5-д газар усны албан ёсны нэрийг зөвхөн Улсын Их Хурал өөрчилнө

-Геодези, зураг зүйн тухай хуулийн 11.6-д “уугуул иргэд нь нэрлэж заншсан уламжлалт нэрийг сэргээх хүсэлт тавьсан бол газар зүйн нэрийг өөрчилж болно”

-11.8-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах газар зүйн нэрийг Засгийн газар нэгтгэн Улсын Их Хурлаар батлуулна” гэж тус тус заажээ.


ХИЛИЙН ЦЭС:



“Дэлхийн өвийн жагсаалт”-д бүртгэгдэн батлагдсан энэхүү газар нутаг нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт орших Хэнтийн нурууны салбар уулсын нэг болох 109о00’30” 48о45’43”-ын солбицолд байрлах “Хэнтий Хаан уул” нэрээр газрын зурагт тэмдэглэгдсэн 2361.5 тоот өндөрлөг юм.

ТОГТООЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

Тогтоол батлагдсанаар Монгол Улсад хэрэглэгдэж байгаа төрөл бүрийн масштабтай байр зүйн цаасан болон тоон зурагт Бурхан Халдун уул нэрээр тэмдэглэгдэнэ. Дэлхийн соёлын өвийн хорооноос өгсөн зөвлөмж зааврыг биелүүлэх ажлын хүрээнд хил хязгаарыг газрын зурагт нарийвчлан тусгах, цаашид соёлын өв болох Бурхан Халдун уулыг хамгаалах менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын эхлэл болох ач холбогдолтой.



Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолын хавсралтаар баталсан жагсаалтад “Хэнтий Хаан уул, Hentii Naan uul, Хэнтий, Өмнөдэлгэр” гэсэн газар зүйн нэрийг “Бурхан Халдун уул, Burkhan Khaldun uul, Хэнтий, Өмнөдэлгэр” гэж өөрчилж уламжлалт нэрийг сэргээлээ. Түүнчлэн газар зүйн нэрийн өөрчлөлтийг бүртгэх, уулын нэрийг Монгол Улсын газрын зурагт тусгах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгалаа.

Е) Аюулгүй байдал, Олон улсын гэрээ, конвенцийн чиглэлээр:**ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

БАТАЛСАН ОГНОО 2016.12.01	<b style="color: #e67e22;">ХУУЛЬ САНААЧЛАГЧ Ерөнхийлөгчөөс 2016.02.05-ны өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАН МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	--	--

Төрийн нууцын тухай Монгол Улсын хууль нь 1995 онд батлагдсан бөгөөд анх удаа төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулж, төрийн нууцыг хамгаалах тогтолцоо, эрх зүйн үндсийг тавьсан.

ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ:**1**

Монгол Улсын байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн дагаж мөрдөнө.

2

Монгол Улсын төрийн болон албаны нууцтай танилцсан гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийг биелүүлэх үүрэг хүлээнэ.

3

Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улс, олон улсын байгууллагаас шилжүүлэн өгсөн төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг хамгаалахад энэ хуульд заасан журам нэгэн адил үйлчилнэ.

ХУУЛИЙН ЗОРИЛТ: Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлж, мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгоно.

“ТӨРИЙН
НУУЦ”

Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгоно.

“АЛБАНЫ
НУУЦ”

Мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцлах зарчим Мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцлахад хуульд нийцсэн, үндэслэлтэй, цаг үеэ олсон байх зарчмыг удирдлага болгоно.

Өнгөрсөн хугацаанд манай улсын эдийн засаг, нийгэм, хууль зүйн салбарт гарсан өөрчлөлт, шинэчлэл, мэдээллийн технологийн хөгжил, гадаад улсуудын төрийн нууцыг хамгаалах тухай хууль тогтоомжийн нийтлэг чиг хандлага зэрэг нь Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үндэслэл болсон юм.

Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль нь зөрчил, хийдэлтэй, хоорондын уялдаа холбоо хангалтгүй байсан нь хуулийг шинэчлэх бас нэг үндэслэл болсон.

Төрийн болон албаны нууцын тухай хууль нь 7 бүлэг, 40 зүйлтэй бөгөөд дараах зарчмын шинжтэй шинэ зохицуулалтыг тусгасан. Үүнд:

1.Төрийн болон албаны нууцын тухай ойлголтыг тодорхой хуульчилж, холбогдох нэр томъёоны тодорхойлолт, нууцлах зарчмыг тусгаж, тус хуулиар төрийн болон албаны нууцыг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахаар заасан;

2.Төрийн болон албаны нууцыг хамгаалах байгууллага, албан тушаалтан, иргэний нийтлэг үүрэг, нууцад хамаарах мэдээллийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын талаар шинээр зохицуулалт оруулсан;

3.Төрийн болон албаны нууцыг хамгаалах талаархи төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрхийг нарийвчлан тусгасан;

4.Төрийн нууцад хамааруулах мэдээллийн жагсаалтыг тодорхой тусгаж, уг жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд хамаарах төрийн нууцын дэлгэрэнгүй жагсаалтыг Засгийн газар тогтоох, албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг эрхэлсэн сайд болон холбогдох байгууллагын дарга баталж байхаар тусгав;

5.Нууцлах хугацаа нь дуусгавар болсон, эсхүл нууцлах шаардлагагүй болсон мэдээ, баримт сэлтийг ил болгох ажиллагаа шат дамжлага ихтэй, ил болгох шийдвэрийг зөвхөн Улсын Их Хурал гаргадаг байсныг өөрчилж, нууцлах хугацаа дуусахын өмнө үргэлжлүүлэн нууцлах эсэхийг байгууллага, албан тушаалтан тагнуулын байгууллагын саналыг авсны үндсэн дээр шийдвэрлэж байхаар заасан;

6.Мэдээллийг нууцлах хугацааг сунгах эсэх асуудлаар тухайн салбарын байгууллага санал гаргаагүй бол дахин мөн хугацаагаар сунгагдсанд тооцох зохицуулалтыг тусгасан;

7.Мэдээллийг нууцлах хугацааг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн нууцын зэрэглэлээс хамааран харилцан адилгүй байх, нууцлах дээд хугацаа 30 жил, шаардлагатай бол хугацааг үргэлжлүүлэн сунгах боломжтой байхаар зохицуулсан;

8.Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд 14 төрлийн мэдээллийг “байнга” нууцлахаар заасан байснаас тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын нууц гүйцэтгэх ажилтан, эдгээр байгууллагатай

нууцаар хамтран ажиллаж байсан болон нууцаар хамтран ажиллаж байгаа хүн, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтад авсан хүний талаархи мэдээллийг “байнга” нууцлахаар үлдээж, бусад мэдээллийг тодорхой хугацаанд нууцлахаар өөрчлөв;

9.Гадаад улсуудын нийтлэг жишгийн дагуу албан тушаалтан, иргэнд төрийн нууцтай танилцах эрх олгох, шалгах, олгохоос татгалзах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэлүүдийг тодорхой тусгасан;

10.Төрийн болон албаны нууцтай танилцсан албан тушаалтан, иргэн, нууц хамгаалах ажилтны үүрэг, эрх зүйн баталгааг тодорхой заасан;

11.Төрийн нууцыг хамгаалах өнөөгийн тогтолцоог шинэчилж, нууц тээгчийг бүтээх, ашиглах, хадгалах, шилжүүлэх, тээвэрлэх, бүртгэх, түүнчлэн төрийн нууцыг ашиглан ажил явуулах, төрийн болон албаны нууцыг хамгаалах техник, криптографийн асуудал, мэдээлэл хамгаалах хэрэгслийг шалгаж баталгаажуулахтай холбоотой харилцааг тус тус хуульд заасан тусгай журмаар нарийвчлан зохицуулж байхаар тусгасан болно.

Хуулийн ач холбогдол:

- 1. Төрийн болон албаны нууцын ойлголт, нууцад хамааруулах мэдээлэл, түүнийг тогтоох субъект, нууцлахыг хориглох мэдээлэл, нууцтай танилцах, харьцах, хамгаалах арга, хэлбэр тодорхой болно;*
- 2. Төрийн болон албаны нууцыг хамгаалах байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг, хариуцлага тодорхой болно;*
- 3. Төрийн нууцын хамгаалалт сайжирч, албан тушаалтан, иргэний үүрэг, хариуцлага дээшилнэ;*
- 4. Мэдээллийг хууль бусаар нууцлах, иргэний мэдээлэл авах эрхийг зөрчихөөс сэргийлэх механизм бүрдэнэ;*
- 5. Төрийн нууцыг хамгаалах эрх зүйн орчин боловсронгуй болно.*

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН
ОГНОО

2016.12.01

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

Засгийн газраас 2015.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн

ДАГАН МӨРДӨХ
ХУГАЦАА

Ердийн
журмаар

Олон улсын гэрээний тухай хуулийг 1993 онд баталж, 1998, 2012 онуудад тодорхой нэмэлтүүд оруулсан байдаг.



ЗОРИЛГО:

Хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах, соёрхон батлах, батлах, хүчин төгөлдөр олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох, тайлбар хийх, гэрээг биелүүлэх, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээний үйлчлэлийг дуусгавар болгох, нийтлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

ХУУЛЬТАЙ ХОЛБОГДУУЛАН:

- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хууль тус тус баталсан.

ХУУЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ:

- Олон улсын гэрээ байгуулах процедурын харилцааны зохицуулалт тодорхой болох;
- Гэрээ нийтлэх зардлыг жил бүрийн төсөвт тусгаснаар нийтлэх зардлын асуудал шийдэх;
- Олон улсын гэрээний талаархи олон нийтийн ойлголт дээшлэх;
- Шүүх хоёр болон олон талт бүх гэрээг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа хэрэглэх боломж бүрдэх.

ХУУЛЬД ТУСГАГДСАН ЗОХИЦУУЛАЛТУУД:

- Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцид хэрэглэгдсэн бүрэн эрхийн итгэмжлэл, үзэглэл, тайлбар зэрэг нэр томъёог бүрэн тусгасан;
- Хуулийн үйлчлэх хүрээг оновчтой байдлаар тодорхойлсон;
- Олон улсын гэрээ үйлдэх хэлний зохицуулалт, гэрээний орчуулга, орчуулгыг хянан баталгаажуулалтын талаархи төрийн захиргааны төв байгууллагуудын эрх, үүргийг тодорхой болгосон;
- Хоёр болон олон талт гэрээ байгуулах, нэгдэн орох харилцааны зохицуулалтын ялгааг тодорхой болгосон;
- Олон улсын гэрээг соёрхон батлах болон батлах асуудлыг нэг мөр болгон нарийвчлан зохицуулсан;
- Гэрээг нийтлэх харилцааны зохицуулалтыг тодорхой болгож шийдвэрлэсэн.

Монгол Улс Үндсэн хуулиараа олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталсан гадаад бодлого явуулах, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй олон улсын гэрээг дагаж мөрдөхгүй байх суурь зарчмуудаа тодорхойлж Улсын Их Хурал олон улсын гэрээг соёрхон батлах, Ерөнхийлөгч Монгол Улсын нэрийн өмнөөс, Засгийн газар Монгол Улсын болон Засгийн газрын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах эрх зүйн үндсийг тогтоосон байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн эдгээр суурь заалтуудыг нарийвчлан зохицуулсан Олон улсын гэрээний тухай хуульд зохицуулалтын дараах дутагдал, хийдэл байна гэж үзэн эдгээр зохицуулалтыг тодорхой болгон хуульчлах зорилгоор Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2011 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 46/26 дугаар зөвлөмжөөр Олон улсын гэрээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, батлуулах үүргийг Засгийн газарт өгсөн.

Мөн энэ хуультай холбогдуулан Засгийн газрын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг тус тус баталлаа.

Хууль батлагдсанаар олон улсын гэрээ байгуулах зохицуулалт тодорхой болж, дээр дурдсан хууль зүйн болон практик асуудлууд бүрэн шийдвэрлэгдэнэ. Гэрээ нийтлэх зардлыг жил бүрийн төсөвт тусгаснаар нийтлэх зардлын асуудал шийдэгдэх бөгөөд ингэснээр олон улсын гэрээний талаархи олон нийтийн мэдлэг, ойлголт дээшилж, тухайн гэрээгээр олгогдсон эрхээ эдлэх боломж өсөн нэмэгдэх ач холбогдолтой юм. Мөн шүүхээс зөвхөн олон талт бус, хоёр болон олон талт бүх гэрээг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа хэрэглэх боломж бүрдэж байна.

Хууль батлагдсанаар шинээр байгууллага, бүтэц үүсэхгүй бөгөөд үүнтэй холбоотой нэмэлт хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүй.

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН
ОГНОО

2017.02.02

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

Засгийн газраас 2016.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн

ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА

Ердийн
журмаар

Энэ хуулийн ЗОРИЛГО нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах зөвлөл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, сайн дурын хэсэг, иргэний эрх үүрэг, оролцоог тодорхойлох, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах, хэрэгжүүлэх харилцааг зохицуулахад оршино.



Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хэрэглэдэг олон улсын нэр томъёог өөрийн орны онцлогт нийцүүлэн тодорхойлолтыг шинээр томъёолон оруулснаар энэ хуулийг цаашид дагаж мөрдөх, ойлгож хэрэглэх асуудлыг нэгдсэн ойлголтод оруулсан.



Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зарчмыг хүмүүнлэг, шуурхай, ил тод, хариуцлагатай, мэргэжлийн нэгдмэл удирдлагатай, шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологи, инновацид тулгуурласан, өмчийн хэлбэрийг үл харгалзан иргэдийн оролцоонд түшиглэсэн байхаар шинээр томъёолсон.



Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь гамшгийн өмнөх, гамшгийн үеийн, гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа гэсэн үе шатуудаас бүрдэхээр нарийвчлан, зааг ялгаатай тодорхойлж, эрх зүйн зохицуулалтыг тусгайлан заасан.



Онцгой байдлын байгууллагын тогтолцоо, чиг үүргийг шинээр томъёолон оруулж, төрийн цэргийн байгууллагын хувьд нэгдмэл байх зарчимд нийцүүлэн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу онцгой байдлын байгууллагын алба хаагчид төрийн цэргийн байгууллагын алба хаагчдад олгогддог бусад баталгааг нэгэн адил эдлүүлэхээр тогтоож, албан хаагчдын эдийн засаг, нийгмийн баталгааг сайжруулсан.



Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх бүхий субъектүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор гамшгаас хамгаалах үндэсний болон орон нутгийн зөвлөл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, онцгой байдлын байгууллагын чиг үүрэг, бүрэн эрх, түүнчлэн хуулийн этгээд, иргэний эрх, үүргийг илүү тодорхой болгох эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн тусгасан.



Дотоодын болон гадаадын хүмүүнлэгийн тусламжийн талаархи эрх зүйн зохицуулалтыг шинээр тусгасан.

Энэ хууль батлагдсанаар гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчин боловсронгуй болж, гамшгийн эрсдэл буурч эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Энэхүү хууль нь нийтлэг үндэслэл, гамшгийн өмнөх үйл ажиллагаа, гамшгийн үеийн үйл ажиллагаа, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлага, гамшгаас хамгаалах удирдлагын бүрэн эрх, хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг, гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламж, онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт, бусад зүйл гэсэн 11 бүлэг, 52 зүйлтэй.

Шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад 45 хуульд нэр томъёоны шинэчлэлтэй холбогдуулан өөрчлөлт оруулсан байна. Төсвийн 1.0 хувийг орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах санд тусгаж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд зарцуулах зохицуулалтыг тодорхойлсон.

Энэ хууль батлагдсанаар гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн нэр томъёог хэрэглэх нэгдсэн ойлголт бий болох, гамшгаас хамгаалах удирдлага, зохицуулалтын механизм бүрдэж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоо нэмэгдэх, удирдлагын субъектүүдийн бүрэн эрхийн зааг, ялгаа оновчтой тодорхойлогдож, хоорондын уялдаа холбоо, хариуцлага, хяналтын тогтолцоо сайжрах, гамшгийн өмнөх, гамшгийн үеийн, гамшгийн дараах үйл ажиллагааны эрх зүйн үндэс бүрдэж гамшгийн эрсдэл буурах, гамшгийн үеийн хойшлуулшгүй сэргээн босгох хүмүүнлэгийн тусламж, түүнийг зохицуулахтай холбогдон гардаг хүндрэл, бэрхшээл арилах, онцгой байдлын байгууллагын тогтолцоо, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн чиглэл тодорхой болж, гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний шуурхай байдал хангагдах, онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгаа сайжрах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчин боловсронгуй болж, гамшгийн эрсдэл буурснаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах нөхцөл бүрдэх ач холбогдолтой юм.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ДЭЛХИЙН БАНКНЫ ОЛОН
УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ ХООРОНД БАЙГУУЛСАН “ЭКСПОРТЫГ
ДЭМЖИХ ТӨСӨЛ”-ИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдөр урьдчилан зөвшилцсөний дагуу Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Экспортыг дэмжих төсөл”-ийн Санхүүжилтийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж баталлаа.

Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн салбараас хамааралтай байдлыг бууруулах, түүнчлэн экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага бий болсон бөгөөд Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацитай хамтран хэрэгжүүлэх “Экспортыг дэмжих төсөл” нь Монгол Улсын уул уурхайн бус салбар дахь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн экспортын чадавхийг бэхжүүлж, гадаад зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх зорилготой юм.

Хэрэгцээ шаардлага:

**Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх,
уул уурхайн салбараас хамааралтай байдлыг
бууруулах, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг
нэмэгдүүлэх шаардлага бий болсон.**

“Экспортыг дэмжих төсөл”-ийг хэрэгжүүлснээр Монгол Улсын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд экспортлоход шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, туршлага судлах, экспортын даатгал гэх мэт санхүүгийн шинэ бүтээгдэхүүнүүдийг бий болгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна тодорхой зорилтот зах зээлд нэвтрэх боломжийг нээх зэрэг эерэг үр нөлөөг бий болгоно.

Төсөл нь үндсэн 2 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэх бөгөөд 5 жилийн хугацаанд хэрэгжинэ. Үүнд:

1.Экспортыг дэмжих санхүүгийн шинэ бүтээгдэхүүнүүдийг бий болгох, хөгжүүлэх—Экспортод чиглэсэн үндэсний аж ахуйн нэгжүүдэд экспортын зээлийн даатгал болон баталгаа олгох санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх, институцийн тогтолцоог бий болгоход чиглэнэ.

2.Экспортын өрсөлдөх чадварыг сайжруулах—Дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудын өрсөлдөх чадварыг сайжруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор экспорттой холбоотой тусгай сургалтын хөтөлбөр боловсруулах, сургах, чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ зохион байгуулна.

Мөн экспортлогчдын олон улсын зах зээл дээрх өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор шаардлагатай санхүүжилтэд дүйцэх хэмжээний санхүүгийн дэмжлэг олгоно.

Санхүүжилтийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хууль батлагдсанаар эдийн засаг, нийгэм, хууль зүйн сөрөг үр дагавар гарахгүй.

Зээлийн нөхцөл:

Энэхүү төслийг Дэлхийн банкны 20.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх бөгөөд энэхүү зээлийг жилийн 1,25 хувийн хүү, 1,25 хувийн бусад шимтгэлтэй, эргэн төлөгдөх хугацаа 25 жилийн хугацаатай, эхний 5 жилд зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэйгөөр авч байна.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНД БАЙГУУЛСАН “САНХҮҮГИЙН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ”
ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар урьдчилан зөвшилцсөний дагуу Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг соёрхон батлах тухай” хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн соёрхон баталлаа.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газартай тус улсын хөнгөлөлттэй зээлээр тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг санхүүжүүлж хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсоны дагуу анхны 40 сая еврогийн “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг 2012 онд байгуулсан.

Уг зээлийн хөрөнгөөр “Монгол Улсын Хавдар судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх”, “Улаанбаатар хотын цэвэр, бохир усны хоолойг шуудуу ухалгүйгээр шинэчлэх технологийг нэвтрүүлэх”, “Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх”, “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх”, “Төрийн тусгай албаны эмнэлэг”, “Онцгой байдлын газрын гал унтраах техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах” зэрэг таван төслийг амжилттай хэрэгжүүлжээ.

2012 онд байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг амжилттай хэрэгжүүлсэн туршлага дээр үндэслэн, Бүгд Найрамдах Австри Улсын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх бодит хэрэгцээ, шаардлага байгааг харгалзан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газартай 40 сая еврогийн өртөг бүхий хоёр дахь удаагийн “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан.

Энэхүү хэлэлцээрийн нөхцөл нь хөнгөлөлттэй зээлийн хөнгөлөлтийн түвшинд тавигдах шаардлага (35 хувь)-ыг хангасан, жилийн 0,0 хувь хүүгүй, 18 жилийн хугацаатай, зээлийн үндсэн төлбөрөөс 5 жилийн хугацаанд чөлөөлөгдөх нөхцөлтэй юм.

Олон Улсын Валютын Сангийн аргачлалаар энэхүү зээлийн хөнгөлөлтийн түвшин 40.93 хувь байгаа бөгөөд Монгол Улсын Өрийн удирдлагын тухай хуулиар нэн хөнгөлөлттэй зээлийн ангилалд хамаарч байна.

Тус санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр хоёр жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд дэд бүтэц, цэвэр ус, эрүүл ахуй, хог хаягдал, бохир ус, замын хөдөлгөөний аюулгүй байдал, төмөр зам, боловсрол, техник, мэргэжлийн сургалт, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын төслүүдийг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.


Энэхүү хууль батлагдсанаар Монгол Улс нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр Бүгд Найрамдах Австри Улсаас нийт 40 сая еврогийн зээлийн санхүүжилтийг авч улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, хүн амын амьдрах нөхцөлийг сайжруулах, нийгмийн тодорхой салбарын хөгжлийг дэмжихэд чухал ач холбогдолтой болно.

ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ ТУХАЙ МАРРАКЕШИЙН ХЭЛЭЛЦЭЭРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар урьдчилан зөвшилцсөний дагуу Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Дэлхийн худалдааны байгууллага /цаашид ДХБ гэх/ байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколд нэгдэн орох тухай” хуулийн төслийг Монгол Улсын Их Хурал 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн баталлаа.

1947 онд байгуулагдсан Тарифын болон худалдааны ерөнхий гэрээний тээврийн дамжин өнгөрөх эрх чөлөөний тухай 5 дугаар заалтыг боловсронгуй болгох, тус заалтыг ДХБ-ын гишүүн улсууд заавал дагаж мөрдөх эрх зүйн орчныг бий болгох зорилгоор 2003 онд Бүгд Найрамдах Мексик Улсын Канкун хотноо зохион байгуулагдсан ДХБ-ын сайд нарын 5 дахь удаагийн бага хурлын үеэр Монгол Улс, Бүгд Найрамдах Парагвай Улс, Болив зэрэг далайд гарцгүй орнууд нэгдэн Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколын хавсралт болох Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийг анх санаачилсан.

Хэлэлцээрийг боловсруулсан үе шат :



Санаачлагч улс: Монгол, Парагвай, Боливи

Хүчин төгөлдөр болох нөхцөл: ДХБ-ын гишүүн 110 улс нэгдэн орсноор хүчин төгөлдөр болно.

Нэгдэн орсон улс: 96 улс

Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол болон түүний хавсралт “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр” нь нийт 3 хэсэг, 37 заалтаас бүрдэж байна.

Хэлэлцээрийн эхний хэсэгт, бараа тээвэрлэлтийн шилжилт хөдөлгөөн, гаалийн бүрдүүлэлт, бараа олгох, татвар, хураамж, төлбөр зэрэг хил, гаалийн зохицуулалттай холбоотой журмыг цахим хуудсанд байршуулах, мэдээллийн төв ажиллуулах зэрэг заалтууд тусгагдсан. Хоёрдугаар хэсэгт, хөгжиж буй болон нэн буурай хөгжилтэй орнуудад хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчлэх зарчим тусгагдсанаас гадна хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор шууд хэрэгжиж эхлэх, эсвэл тодорхой хугацааны дараа хэрэгжүүлэх, сургалт, техникийн туслалцаа авч өөрийн чадавхыг бэхжүүлсний үндсэн дээр хэрэгжүүлэх заалтуудыг тусгасан байна. Гуравдугаар хэсэгт, хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор ДХБ-ын гишүүн улсууд хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж ажиллах Үндэсний хороо байгуулах тухай тусгасан байна.

Дэлхийн худалдааны байгууллагаас хөгжиж буй болон нэн буурай хөгжилтэй орнуудад тус хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажиллахад дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор тусламжийн хөтөлбөрийг санаачилсан бөгөөд энэхүү хөтөлбөр нь уг хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хэрэгжиж эхэлнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн банк, Дэлхийн гаалийн байгууллага зэрэг олон улсын байгууллагаас гадна бусад донор орнуудаас үзүүлэх техникийн туслалцаанд хамрагдах боломжтой болно.

Монгол Улс уг протоколд нэгдэн орох асуудлыг дэмжиж, Нэгдсэн Үндэстний Байгууллагатай хамтран 2014 оны 06 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо “Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн ач холбогдол” сэдэвт олон улсын хурлыг зохион байгуулсан.

Ач холбогдол:

- Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын хөгжлийн түншүүдээс дэмжлэг туслалцаа авах хууль ёсны эрх баталгаажих;
- Чадавхийг бэхжүүлэх төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг авах боломж бүрдэх;
- Гадаад худалдааны зардал буурах, экспорт нэмэгдэх;
- Тээврийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын асуудлыг шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх;
- Авто болон төмөр замын дэд бүтцийн сүлжээг сайжруулж, эрсдэлийг бууруулах;
- Худалдааны корридор, хил дамнасан дэд бүтцийн бүтээн байгуулалтыг бусад улстай хамтран хэрэгжүүлэх;
- Хил, гаалийн байгууллагуудын хамтын үйл ажиллагаа идэвхжих;
- Бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийг татан оролцуулах, дэмжих боломжийг бүрдүүлэх зэрэг чухал ач холбогдолтой юм.

ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН
ОГНОО

2017.01.26

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

Засгийн газраас 2016.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн

ДАГАН МӨРДӨХ
ХУГАЦАА

Ердийн
журмаар

Хуулийн зорилго:

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлалд заасан төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах, дипломат албанд ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулахад оршино.



Дипломат албаны тухай хуульд дор дурдсан нэмэлт, өөрчлөлтүүд орж байна. Үүнд:

1. Дипломат ажилтны суугаа улсын сургуулийн өмнөх боловсролын сургалт төлбөртэй бол хүүхдийнх нь сургалтын төлбөрийг тухайн улсын сургалтын зардлын дундаж жишгийн 70 хувиар тооцон улсын төсвөөс олгох;

2. Дипломат төлөөлөгчийн газарт ажиллах дипломат ажилтны эхнэр буюу нөхөр нь төрийн албан хаагч бол ажил олгогч түүнд томилолтын хугацаагаар чөлөө олгох, дипломат төлөөлөгчийн газар ажиллах томилолтын хугацаа дуусч эх орондоо буцаж ирэхэд ажлын байраар хангах, ажил олгогч нь татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо цөөрсөн, хасагдсан тохиолдолд тухайн асуудлыг Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулах;

3. Дипломат албанд томилогдон ажиллагсдын цалин хөлсийг гурван жил тутамд Засгийн газраас шинэчлэн тогтоож байх;

4. Дипломат албанд ажиллуулах журмыг гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах;

5. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заасан болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас

зөвшөөрснөөс бусад тохиолдолд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, түүний нэгж, салбар, төлөөлөгчийн газрыг гадаад улсад байгуулах, төлөөлөгч томилон ажиллуулахыг хориглох;

6.Монгол Улсаас гадаад улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчийг болон олон улсын бусад байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгч нь гадаад улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүргийг хавсран гүйцэтгэх тохиолдолд түүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч хуульд заасны дагуу томилж, эгүүлэн татах;

7.Дипломат төлөөлөгчийн газар ажиллах дипломат ажилтны ажиллах хугацааг гурван жил байсныг дөрвөн жил болгосон бөгөөд уг өөрчлөлт нь энэхүү хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө Дипломат төлөөлөгчийн газарт томилогдон ажиллаж байгаа дипломат ажилтанд хамаарахгүй байхаар тус тус өөрчлөлт оруулсан.

Хуулийн ач холбогдол:

- Төрийн гадаад бодлого нэгдмэл байх, гадаад харилцаанд үндэсний ашиг сонирхлыг дээдлэх зарчмыг тууштай хэрэгжүүлэх;
- Төв, орон нутгийн бүх түвшинд үндэсний нийтлэг ашиг сонирхол, төрийн бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг дээдлэх зарчим хэрэгжих;
- Дипломат ажилтнуудын үүргээ биелүүлэх нөхцөл, бололцоо хангагдах, нийгмийн баталгаа сайжрах, албандаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл хангагдах;
- Дипломат ажилтнуудын гэр бүлийн гишүүд /эхнэр, нөхөр/ төрийн алба хаагч бол томилолтын хугацаа дуусгавар болоод эргэн ирэхэд ажлын байраар хангагдах баталгаа бий болох.

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫГ ХААЖ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛДЫН ХЭЛСЭН ҮГ



Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

УИХ-ын 2016 оны намрын ээлжит чуулган ажлын 85 өдөр чуулж, төлөвлөсөн асуудлаа амжилттай шийдвэрлэлээ.

Намрын чуулганы хугацаанд 2017 оны улсын төсөв, эдийн засгийг сэргээх хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл болон зайлшгүй шаардлагатай бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж, Засгийн газар, төрийн бусад байгууллагад ажлаа саадгүй явуулах бүхий л бололцоог хангаж өглөө. Түүнчлэн хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг баталсан бөгөөд Үндсэн чиглэлд тусгаснаар УИХ 2020 он хүртэл нийт 201 хууль 12 тогтоол хэлэлцэж батлахаар байна.

Намрын чуулганы хугацаанд нийт дүнгээрээ УИХ-ын нэгдсэн хуралдаан 34 удаа болж, Байнгын болон Дэд хороод 140 удаа хуралджээ. Намрын ээлжит чуулганаар бие даасан 22 хууль, хуульд өөрчлөлт оруулах тухай 190 хууль, зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай 3 хууль, УИХ-ын 59 тогтоолыг хэлэлцэн баталлаа.

УИХ намрын чуулганаараа сүүлийн жилүүдэд гаргасан бодлогын алдааг залруулахад анхаарлаа төвлөрүүлж ажиллалаа.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтоох зарчмыг мөнгөний бодлогод тусгаж, төсвийн тооцооллыг түүнд нийцүүлээ.

Улсын гадаад өрийн асуудал төр засгийн төдийгүй эх орноо гэсэн сэтгэлтэй хүн болгоны санааг зовоосон асуудал болж байна. 2017 оны эхний ээлжинд төлөгдөх Хөгжлийн банкны 580.0 сая ам. долларын евро бондыг Засгийн газар гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл найдварыг алдахгүйгээр өнөөгийн төлөвлөж буй байдлаараа цаг хугацаанд нь бүрэн барагдуулах нь зүйтэй.

УИХ төсөв батлахдаа тэвчиж болох зардлыг аль болох танах, үндэсний хэмжээнд хэмнэлтийн горимд шилжих, төсвийн орлого, зарлагыг бодитой тооцож, төсвийн сахилга батыг хангах зарчмыг чанд баримталлаа. Бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарын бараа үйлчилгээний зардлыг нэг хувиар, үндэслэлгүйгээр төсөвт өртгийг нэмэгдүүлсэн хөрөнгө оруулалтын санхүүжих дүнг 58.0 тэрбум төгрөгөөр танаж, төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 9.9 байсныг 9.1 болгож 0.8 пунктээр сайжруулан, Засгийн газрын төлөвлөснөөс 180.5 тэрбум төгрөгөөр бууруулж баталсан. Өөрөөр хэлбэл, төсвийн орлогыг хийсвэрээр тооцож, төсвийн зардлыг тооцоо, судалгаагүйгээр нэмдэг буруу жишгийг халж байна.

Эдийн засгийг тогтворжуулах, өсөлтийг нь хангах зорилгоор Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг баталлаа. Гадаадын хөрөнгө оруулагчдын Монголд итгэх итгэлийг сэргээх, Засгийн газрын авсан зээлийн зардлыг бууруулах, уул уурхай, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх томоохон төслүүдийг эрчимжүүлэх арга хэмжээг уг хөтөлбөрт тусгасан. Хөтөлбөрт тусгасан томоохон төслүүдийг хэрэгжүүлснээр экспорт нэмэгдэж, 2019 онд 4.9 тэрбум ам.долларт хүрэх, импорт 4.4 тэрбум ам.доллар болох, гадаад худалдааны нийт бараа эргэлт 9.3 тэрбум ам.долларт, Монгол Улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт жилд 1.7-2.0 тэрбум ам.долларт хүрч өсөх эерэг үр дүн гарах юм. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт 2017 онд 3.0, 2018 онд 5.1, 2019 онд 7.1 хувьд хүрнэ гэж тооцож байна.

УИХ-аас зөвхөн хөтөлбөр батлах нь хангалттай бус, энэхүү хөтөлбөрийн зүйл, заалт болгоны хэрэгжилтийг Засгийн газар, хариуцсан бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудаас УИХ шаардаж ажиллах болно гэдгийг хэлье. Тиймээс Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хаврын чуулганд танилцуулахыг Засгийн газарт үүрэг болгож байна.

Гадаад, дотоодын хөрөнгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлж, Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн, эдийн засгийн

тогтвортой өсөлтийг хангах үүрэг бүхий Хөгжлийн банкны үйл ажиллагаа байгуулагдсан цагаасаа доголдож улсын нэгдсэн төсөв, өрийн удирдлагын томоохон бэрхшээл болон хувирсан гэдгийг бүгд хүлээн зөвшөөрөөд байна.

Энэхүү бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор юуны өмнө Хөгжлийн банкны богино хугацааны санхүүгийн чадавхийг тогтворжуулан, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж өглөө.

Түүнчлэн Хөгжлийн банкны үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчлэн баталлаа. Энэ хуулиар Хөгжлийн банкны засаглал, ил тод байдлыг сайжруулж, бие даасан байдлыг нь хангах, цаашид ямар нэгэн улстөрч, улс төрийн бүлэглэлийн дохио зангаагаар бус, харин эргэн төлөгдөх боломжтой, Монгол Улсын хөгжилд хэрэгтэй зээлийг, шаардлагатай аж ахуйн нэгжид нь олгодог болох эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Бодит ажлын байр, бодит орлого бий болгодог үндэсний үйлдвэрлэлээ дэмжих зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дэмжиж баталсан. Энэхүү хуулиар жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй газар тариалан, мал аж ахуй болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа, хүнсний үйлдвэрлэл, нэхмэл болон хувцасны үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа 4700 орчим жижиг, дунд бизнес эрхлэгчдийн орлогын албан татварын хэмжээ 1.0 хувь болж байгаа юм.

Түүнчлэн төсвийн орлогын байдал хүнд байгаа хэдий ч импортоор оруулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг 2018 он хүртэл гаалийн албан татвараас чөлөөлөх шийдвэр гаргалаа. Ингэснээр 54 мянга гаруй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үйлдвэрлэлээ өргөтгөх, бүтээмжээ нэмэгдүүлэх таатай боломж нээж өгч байна. Ингэснээр энэ салбарт ажиллаж байгаа 767 мянга орчим иргэний ажлын байр найдвартай хадгалагдах боломж бүрдэнэ.

Эдийн засгийн хүндрэлээс гарахад нь татварын бодлогоор дэмжлэг үзүүлэн, бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор татвараа төлөөгүйн улмаас хаагдсан байсан 3993 татвар төлөгчийн дансыг нээснийг цагаа олсон зөв алхам болсон гэж үзэж байна.

Эрхэм гишүүд ээ,

Улсын эдийн засаг хүнд, макро эдийн засгийн үзүүлэлтүүд дордсоор байгаа боловч төсвийн сахилга хариуцлагыг чангатгах чиглэлээр гаргасан бодлого, шийдвэр үр өгөөжөө эхнээсээ бага ч гэсэн өгч байна. Сүүлийн саруудад эдийн засгийн зарим үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлт ажиглагдаж байна.

Тухайлбал, сүүлийн дөрвөн жилийн турш тасалдаж байсан төсвийн орлого 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 504.8 тэрбум төгрөг буюу 9.4 хувиар давж биелсэн, төсвийн зарлага төлөвлөснөөс 173.5 тэрбум төгрөг буюу 1.8 хувиар хэмнэгдсэн байна.

Мөн эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 1.4 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 442.3 сая ам.доллараар нэмэгдсэн, гадаад худалдаа 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарахаар байна. 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн 9.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1.2 их наяд төгрөгөөр өсчээ.

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 18.3 тонн болж, өнгөрсөн оноос 3.2 тонноор нэмэгдсэн, гадаад валютын албан нөөц жилийн эцсийн байдлаар 1.3 орчим тэрбум ам.долларт хүрч, дотоод зах зээлд гадаад валютын ханшийн тогтвортой байдлыг хангах, ханшийн огцом өөрчлөлтийг бууруулах нөхцөл бүрдэж байна. Эдгээр нааштай өөрчлөлтүүдийг цаашид тогтвортой хадгалж, илүү сайжруулж чадах, эсэх нь УИХ, Засгийн газрын үйл ажиллагаанаас шууд хамаарна.

Төсвийн хөрөнгийг зөвхөн төлөвлөсөн арга хэмжээнд зарцуулахаас гадна, зарцуулсан хөрөнгө болгоноос иргэдэд хэрэгтэй, бодитой үр дүн гарсан байх ёстой гэдгийг онцлон хэлмээр байна. Тухайлбал, нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийн цахилгаан хангамжийн дэд бүтцийг бий болгох зорилгоор 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээр 1562 өрх айл цахилгаанд холбогдож чадсан байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсөв, санхүүгийн боломж хязгаарлагдмал, эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа хэдий ч нийгмийн халамж, хамгааллын асуудал УИХ-ын анхаарлын төвд байсаар байна. УИХ энэ чуулганаар нийгмийн эмзэг, зорилтот бүлэгт чиглэсэн хэд хэдэн шийдвэр гаргалаа.

Ахмад настны тухай хуулийг батлан гаргаж, азай буурлууддаа Билгийн тооллын Хаврын тэргүүн сарын Шинийн нэгэн болон Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан жилд 2 удаа, нийт 100-500 мянган төгрөгийн “Насны хишиг” олгохоор боллоо. Удахгүй болох Цагаан сарын баярыг тохиолдуулан 122 мянга орчим ахмад настанд 20.5 тэрбум төгрөгийн “Насны хишиг” олгоно.

Тэтгэврийн зээлийн хүү жилийн 18 хувь байсныг 15 болгож 3.0 хувиар бууруулж чадсан. Цаашид ч тэтгэврийн зээлийн хүүг багасгах ажлыг шат дараалан, төсөвт дарамт учруулахгүйгээр хэрэгжүүлэхийг хичээж ажиллах ёстой. Түүнчлэн, тэтгэврийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах

өвчний даатгалын сангаас тэжээгчээ алдсан тахир дутуугийн тэтгэвэр авагч иргэдэд 3 хүртэлх сарын тэтгэврийн 50 хувьтай тэнцэх хэмжээний урьдчилгаа олгохоор шийдвэрлэлээ.

Эхчүүд хүүхдээ 3 нас хүртэл нь асрах эрхтэй боловч нийгмийн даатгалын шимтгэл нь жирэмсний болон амаржсаны тэтгэмжтэй хугацаанд нь л төлөгдөж, хоёр жил гаруй хугацаагаар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа нь тасардаг байв. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүд цөөхөн жил ажиллаад тэтгэвэрт гардаг, түүнээс болж тэтгэврийн хэмжээ нь маш бага тогтоогддог байсан. Энэ мэт олон жил яригдсан ч шийдэж чадалгүй өдийг хүрсэн асуудлыг нэг мөр зохицуулж, цэгцэнд нь оруулах талаар арга хэмжээ авч ажилласан. Хууль батлагдсанаар хүүхдээ асарч буй 92 мянга орчим эхийн нийгмийн даатгалын шимтгэлийг жил бүр төлж, 5800 эхийн ажилласан жил дээр төрүүлсэн болон үрчлэн авч өсгөсөн хүүхэд бүрийн тоогоор нь 1.5 жил нэмж тооцохоор боллоо.

УИХ-аас уламжлалт мал аж ахуй, нүүдлийн соёл иргэншлийн өвийг тээж яваа малчин ардынхаа тэтгэвэр тогтоолгох насыг таван насаар урагшлуулж, малчнаар ажиллаж шимтгэл төлсөн нэг жилийг 1.5 жилээр тооцох нь зөв гэж үзлээ.

Мөн Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг батлан гаргаж, нийгмийн шилжилтийн явцад хөдөлмөр эрхлэлтийн байдал нь өөрчлөгдөж, эрхэлж байгаа ажил, үйлчилгээний онцлогоос хамааран тэтгэврийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь төлж чадаагүй малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд тэтгэврийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх боломж олголоо.

Оюутан сурагчдад урт хугацаатай бага хүүтэй сургалтын зээл олгох тогтолцоог шинээр эмхлэн байгуулж, сургалтын зээлийн сангийн үйл ажиллагааг эхлүүллээ. Ингэснээр сургалтын тодорхой шалгуур хангасан 70.0 мянга орчим оюутан энэ зээлд хамрагдах боломж бололцоо бүрдсэн. Сургалтын зээлийн сангийн эх үүсвэрт шаардагдах 90.0 тэрбум төгрөгийг 2017 оны төсөвт тусгасан.

2010 оноос хойш шийдэгдэлгүй 7 дахь жилийнхээ нүүрийг үзэж байгаа цэргийн алба хаагчийн иргэний байгууллагад шимтгэл төлж ажилласан 1 жилийг, 6 сар цэргийн байгууллагад ажилласнаар тооцож, цэргийн тэтгэвэр тогтоолгох боломжийг Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар бүрдүүлж шийдсэн.

УИХ-ын анхаарлын төвд байнга байх ёстой асуудлын нэг нь иргэдийн эрүүл мэндийн асуудал гэдэг нь маргаангүй юм. Зарим нэг тархалт ихтэй, эмчлэхэд хүндрэл бэрхшээлтэй өвчинтэй тэмцэхэд тусгайлан анхаарлаа хандууллаа. Тухайлбал, элэгний “Харвони” эмийн үнийг бууруулж, эмийн зардлын 40 хувийг, түүнчлэн гемодиализийн аппаратад орж цус цэвэршүүлэх

эмчилгээ байнга хийлгэж байгаа иргэдийн эмчилгээний төлбөрийг төрөөс бүрэн хариуцахаар болж, улсын төсөвт 24.2 тэрбум төгрөгийг тусгалаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өмнөх парламентын үед шийдэж чадаагүй, нэгэнтээ буцаагдаж байсан, УИХ-д дахин өргөн мэдүүлсэн боловч хэлэлцүүлгийг хийлгүй орхисон Авлигатай тэмцэх хөтөлбөрийг энэ чуулганаар хэлэлцэн баталсан нь өнөөгийн УИХ-ын авлигатай тэмцэх хүсэл зоригийг илэрхийлж байгаа хэрэг юм. Авлигаас ангид байх үзлийг төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан болон ард түмний эрхэмлэх үнэт зүйл болгон төлөвшүүлэх нь хөтөлбөрийн гол зорилт бөгөөд түүний хэрэгжилт нь эдийн засгийн өсөлтөд чухал хувь нэмэр оруулж, цаашид тогтвортой хөгжлийн суурь болох нь гарцаагүй юм.

Бодлогыг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих байгууллагууд, ялангуяа Авлигатай тэмцэх газар тодорхой төлөвлөгөө гаргаж үе шат, дараалалтайгаар уг хөтөлбөрийг хэрэгжүүлж, бодит үр дүн гаргахад анхаарч ажиллах шаардлагатай байна. Улс орны төр засаг авлигатай хэрхэн тэмцэж байгааг тооцдог индекс олон улсад байдаг боловч хөтөлбөрийн жинхэнэ үр дүнг зөвхөн Монгол Улсын иргэд үнэлнэ гэдгийг бид мартаж өсгүй.

УИХ энэ намрын чуулганаар хууль зүйн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, иргэдийнхээ амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр Монгол Улсын Хилийн тухай, Цагдаагийн албаны тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Олон улсын гэрээний тухай зэрэг хуулиудыг шинэчилж, иргэний улс төрийн эрхийг баталгаажуулах зорилгоор Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийг шинээр баталсан.

Гэр бүлийн гишүүд, түүний дотор хүүхэд, эмэгтэйчүүд гэр бүлийн орчиндоо амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хүчирхийллийн золиос болох аливаа хандлага, үзэгдэлтэй тууштай тэмцэх ажилд шинэчлэн баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль ахиц, дэвшил авчирна гэдэгт итгэлтэй байна.

Хүн амын талаас дээш хувь нь амьдарч байгаа нийслэл хотын агаар, орчны бохирдлын асуудал тэвчиж болох хэмжээнээс аль хэдийнэ хэтэрлээ. Саяхан энэ асуудлаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан болж УИХ, Засгийн газар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлсэн. Шинэчлэн зохион байгуулж байгаа Орчны бохирдлын асуудлаарх онцгой байдлын үндэсний хороо яаралтай ажилдаа орж, бодитой үр дүн гаргаж ажиллах шаардлагатай байна. Агаарын бохирдлыг бууруулах асуудлаар тодорхой санал, шийдвэрийн төслийг Засгийн газар өргөн баривал УИХ-ын ээлжит бус чуулганыг хэдийд ч зарлан хуралдуулах боломжтой гэдгийг хэлье. Улаанбаатар хот маань зөвхөн Монгол Улсын нийслэл, нүүр царай төдийгүй

бидний ирээдүй хойч үеийн ихэнх нь ажиллаж амьдрах хот гэдгийг мартах эрх бидний үеийнхэнд байхгүй.

УИХ хууль, УИХ-ын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх талаар зохих хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Чуулганы хугацаанд УИХ-ын гишүүдээс бүрдсэн 13 Ажлын хэсэг гарч, дөрвөн Ажлын хэсэг дүнгээ нэгтгэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх талаар холбогдох эрх бүхий этгээдэд тодорхой үүрэг, чиглэл өгсөн байна. Тухайлбал, Туул голын бохирдлын асуудал, улсын төсөвт үйлдвэрийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн эдийн засаг, санхүүгийн байдал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Ажлын хэсгээс гарсан санал дүгнэлтийг холбогдох Байнгын хороодын түвшинд хэлэлцэн шийдвэрлэжээ.

УИХ-ын гишүүд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, зарим яам, агентлаг, сургууль, цэцэрлэг, Төрийн орон сууцны корпораци зэрэг 17 байгууллагад хүрэлцэн очиж хууль тогтоомжийн хэрэгжилттэй биечлэн танилцсан байна.

Хууль зүйн байнгын хороо “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Монголросцветмет” ХХК-ийн энгийн хувьцааны Оросын талын эзэмшиж байсан 49 хувийг Монголын нэр бүхий иргэдийн эзэмшиж байгаа “Монголиан Коппер Корпорэйшн” ХХК худалдан авсан асуудлыг энэ чуулганы явцад Ажлын хэсэг гаргаж, нэлээд хугацаанд шалгалаа. Шалгалтын дүн, түүний дагуу авах арга хэмжээний талаар УИХ шийдвэрээ гаргалаа. Шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газар, Хууль зүйн байнгын хороо шуурхай зохион байгуулах хэрэгтэй. Цаашдаа “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагаа, удирдлагын ил тод, хараат бус байдлыг сайжруулан, олон нийтийн оролцоо, хяналттай, компанийн сайн засаглал бүхий зохион байгуулалтын хэлбэрт шилжүүлэх цаг нь болсон гэж үзэж байна.

Түүнчлэн Боловсролын тухай болон Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн хэрэгжилтийн талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг орон нутагт одоо ч ажилласаар байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

УИХ-ын намрын ээлжит чуулган ийнхүү завсарлаж байгаа ч түмэн олноо төрд төлөөлсөн гишүүд бидний ажил завсарлахгүй. Юуны өмнө сонгогдсон тойрогтоо ажиллаж, батлан гаргасан хууль тогтоомжоо сурталчлах, хэрэгжилтийг хангах, иргэдийн санаа бодлыг сонсох, харилцан ярилцах, гарах шийдвэрт тэдний оролцоог хангах ажил биднийг хүлээж байна. Ажлыг маань

хэрхэн үнэлж, ямар дүн тавьж байгаагаа, юунд анхаарлаа илүү хандуулж, ямар шийдвэр гаргах нь чухал байгааг иргэд сонгогчид Та бидэнд хэлж өгөх болно.

Завсарлаж буй ээлжит чуулганы ард шийдвэрлэх ээлжээ хүлээж буй олон хууль, тогтоомжийн төсөл үлдэж байна. Улс орны амьдралд тохиолдож буй саад бэрхшээлийг даван туулах, уруудаж өөөдсөн эдийн засгаа сэргээх, ард иргэдийнхээ амьжиргааг өөд татах, улмаар хөгжил дэвшлийн суурийг бүрдүүлэх зорилтыг хууль, эрх зүйн хувьд ханган, бодлогоор дэмжих томоохон үүрэг хариуцлага энэ удаагийн УИХ-д ногдсон гэдгийг Та бидний хэн нь ч мартаж учиргүй. Тиймээс завсарлагааны хугацаанд ирэх хаврын чуулганы бэлтгэлээ сайтар хангах, бэрхшээлт асуудлуудын ээдрээг тайлах шийдлийг олох, сонгогчдынхоо хүлээлгэсэн итгэл, найдварыг биелүүлэх чиглэлд анхаарч ажиллаарай хэмээн хүсээд УИХ-ын намрын чуулганы ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

Монгол түмэндээ, Эрхэм гишүүд Та бүхэндээ хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе.



Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы хаалтын ажиллагаа

ИРГЭН ТА ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВАХ ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?



Хууль санаачлагч нь өөрийн санаачилсан хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхийн өмнө уг хуулийн төслийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахаар төслийг forum.parliament.mn сайтад байршуулсан байна

Иргэн Та эхлээд сайтын **Бүртгэлийн** хэсэгт дарж хэрэглэгчээр бүртгүүлнэ

-Өөрийн нэр
-Нууц үг
-Майл хаягаа оруулна

Дараа нь сайтын **Нэвтрэх** хэсэгт дарж нэвтэрнэ

-Хэрэглэгчийн нэр
-Нууц үгээ оруулна

Хэлэлцүүлэг хэсгийг сонгоно

-Энэ хэсгээс сонирхсон хуулийн төслөө сонгоно

Сонгосон хуулийн төсөлтэйгээ холбогдуулж

Коммент бичиж байр сууриа илэрхийлэх

Санал асуулгад оролцох боломжтой

Төсөл дагах

Бусад иргэдийн коммент, санал, мессежийг өөрийн майл хаягаар авах боломжтой

Сайтад холбогдож хэрэглэгч болсноор

Зурвас

Мэдэгдэл

хэлбэрээр хуулийн төсөлтэй холбоотой бүх мэдээллийг Танд хүргэнэ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА**

Редактор: С.Батбаатар

Эмхэтгэсэн: Ц.Оюун

Эх бэлтгэсэн: Г.Сугарсүрэн

Гэрэл зургийг: Г.Эрдэнэтуяа
А.Батжаргал

Улсын Их Хурлын Тамгын газраас
2017 оны 03 дугаар сарын 06-ны өдөр эрхлэн гаргав.

/Төлбөргүй тараана/